

Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013

Судалгааны тайлан



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013

Судалгааны тайлан

Судалгааны багийн бүрэлдэхүүн: Л.ОТГОНТУЯА
Монголын төсвийн мэргэжилтнүүдийн холбооны тэргүүн,
Удирдлагын академийн багш, доктор, дэд профессор

Д.ЦЭРЭНЖАВ
Ил тод байдал сангийн Гүйцэтгэх захирал

Д.ОЮУНБАДАМ
Эдийн засгийн ухааны доктор, Нээлттэй Нийгэм Форумын
Эдийн засгийн хөтөлбөрийн менежер

© Нээлттэй Нийгэм Форум

Энэхүү судалгааны тайланг бүтнээр нь болон хэсэгчлэн хувилж олшруулах, дахин хэвлэхийг хүсвэл доорх хаягаар хандаж зөвшөөрөл авна уу.

Уг судалгаатай холбоотой аливаа асуулт, тодруулга байвал Нээлттэй Нийгэм Форум буюу oyunbadam@forum.mn цахим шуудангийн хаягаар хандана уу.

Хаяг: Жамъян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,
Утас: 976-11-313207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn

DDC
336.014
O-454

ISBN 978-99929-64-49-9

Агуулга

ӨМНӨХ ҮГ	7
БҮЛЭГ 1. УДИРТГАЛ.....	8
1.1 “Орон нутгийн төсвийн ил тод байдал – 2011” судалгааны тухай.....	9
1.2 “Орон нутгийн төсвийн ил тод байдал – 2013” судалгааны онцлог.....	10
1.3 Судалгааны ажлын зохион байгуулалт	11
1.4 Үнэлгээний аргачлал	12
1.5 Судалгаанд хамруулсан төсвийн баримт бичиг ба үйл явц.....	13
БҮЛЭГ 2. РЕЙТИНГ (АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ТӨСВИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ИНДЕКС)	14
БҮЛЭГ 3. СУДАЛГААНЫ ҮР ДҮН	18
3.1 Орон нутгийн төсвийн ил тод байдал (аймаг, нийслэл тус бүрээр)	18
3.2 Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах заалтыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрхзүйн баримт бичигт тусгасан байдал.....	20
3.3. Төсвийн баримт бичгүүдийн ил тод байдал (аймаг, нийслэлийн нэгдсэн үнэлгээ)	25
БҮЛЭГ 4. ДҮГНЭЛТ, БОДЛОГЫН ЗӨВЛӨМЖ	34
ХАВСРАЛТУУД	40

Хүснэгт, графикийн жагсаалт

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 1.	Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын индекс тооцсон байдал	15
Хүснэгт 2.	Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын үнэлгээний харьцуулалт, 2011 ба 2013 он.....	17
Хүснэгт 3.	Нутгийн удирдлагаас баталсан эрх зүйн баримт бичигт төсвийн ил тод байдлын талаар тусгасан байдлын үнэлгээ	21

Графикийн жагсаалт

График 1.	Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын өнөөгийн түвшин	16
График 2.	Төсвийн ил тод байдлын “дунджаас дээш” үнэлгээтэй аймгууд.....	18
График 3.	Төсвийн ил тод байдлын “дундаж” үнэлгээтэй аймаг, нийслэл	19
График 4.	Төсвийн ил тод байдлын “дунджаас доош” үнэлгээтэй аймгууд.....	20
График 5.	Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийг хэлэлцэж, батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал (аймаг, нийслэлийн нэгтгэсэн дүнгээр).....	27
График 6.	Аймаг, нийслэлийн төсвийг хэлэлцэж, баталсан хуралдааны баримт бичгийн ил тод байдал.....	27

Хавсралтын жагсаалт

Хавсралт 1. Судалгааны арга зүй.....	40
Хавсралт 2. Орон нутгийн судлаачийн ажлын удирдамж	41
Хавсралт 3. Аймаг, нийслэлийн төсвийн мэдээлэл, баримт бичгийг цуглуулж, тэдгээрийг хэрхэн ил тод, нээлттэй болгосныг нотолж ирүүлэх маягтууд.....	45
Хавсралт 4. Орон нутгийн төсвийн баримт бичгүүд болон төсвийн үйл явцын нээлттэй, ил тод байдлыг үнэлэхэд ашиглах шалгуур үзүүлэлт, түүнд харгалзах оноо.....	69
Хавсралт 5. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын индекс тооцсон байдал	70
Хавсралт 6. Нутгийн удирдлагаас баталсан эрх зүйн баримт бичигт төсвийн ил тод байдлын талаар тусгасан байдлын үнэлгээний нэгтгэл.....	71
Хавсралт 7. Аймаг, нийслэлийн төсвийн баримт бичгийн ил тод байдлын үнэлгээ.....	72
Хавсралт 8. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдал (аймаг, нийслэл тус бүрээр)	84
Хавсралт 9. Аймаг, нийслэлийн төсвийн мэдээлэл бүхий цахим хуудасны талаарх мэдээлэл.....	93
Хавсралт 10. Хөндлөнгийн үнэлгээний багийн гишүүдийн жагсаалт	94
Хавсралт 11. Орон нутгийн төсвийн мэдээлэл цуглуулах багийн гишүүдийн жагсаалт.....	95
Хавсралт 12. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй сайн туршлагаудаас	97

Товчилсон үгийн жагсаалт

ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
ННФ	Нээлттэй Нийгэм Форум
ОНТИТБ	Орон нутгийн төсвийн ил тод байдал
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс

ӨМНӨХ ҮГ

Орон нутгийн төсвийн нийт зарлага 2013 онд 1.8 орчим их наяд төгрөг буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 10.6 хувьд хүрч, өмнөх онтой харьцуулахад 2.5 дахин өсчээ. Жил бүр ийнхүү өсөн нэмэгдэж буй төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулах, иргэдэд үзүүлж буй үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эн тэргүүний хэрэгцээт үйлчилгээ, дэд бүтцийг тодорхойлох, төсөв захиран зарцуулагчдын хариуцлагыг дээшлүүлэхэд орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах нь нэн чухал үүрэгтэй юм.

Нээлттэй Нийгэм Форум (ННФ)-аас эрхлэн орон нутгийн төсвийн ил тод байдлыг үнэлсэн хоёрдахь удаагийн судалгааны тайланг уншигч Танд толилуулж байна. 2013 оны 10 дугаар сараас 2014 оны 2 дугаар сар хүртэл нийт 4 сарын хугацаанд Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль, тэдгээрт холбогдох дүрэм журамд үндэслэн 2013 оны орон нутгийн төсвийн үйл явц, батлагдсан төсөв болон төсвийн холбогдолтой гарсан шийдвэр, баримт бичгүүдийн ил тод байдлыг үнэллээ. Судалгааны дүн орон нутгийн төсвийн ил тод байдал хангалтгүй хэвээр байгааг харууллаа. Аймаг, нийслэлийн дундаж оноо 36 буюу нийт авбал зохих онооны дөнгөж гуравны нэгд хүрч байна. 2011 оны судалгаагаар энэ оноо 35 байсан юм. Энэ нь төсвийн ил тод байдлыг хангах талаар гарсан хууль тогтоомжийн хэрэгжилт орон нутгийн захиргааны байгууллагуудын анхаарлын төвд ороогүй байгааг харуулж байна.

Нийт аймаг, нийслэл хотыг хамарсан энэхүү судалгааг хийж гүйцэтгэсэн 30 гаруй хүний бүрэлдэхүүнтэй баг, ялангуяа судалгааг удирдан явуулсан Монголын төсвийн мэргэжилтнүүдийн холбооны тэргүүн Л.Отгонтуяа, Ил тод байдал сангийн Гүйцэтгэх захирал Д.Цэрэнжав болон ННФ-ын Эдийн засгийн хөтөлбөрийн менежер Д.Оюунбадам нарт гүн талархал илэрхийлье.

Энэхүү судалгааны дүн нь төсвийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, иргэдийн оролцоог сайжруулах талаар олон нийт, бодлого боловсруулагчид, орон нутгийн удирдлагуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлэхэд зохих хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна.

П.Эрдэнэжаргал

Нээлттэй Нийгэм Форумын Гүйцэтгэх захирал

1 Удиртгал

Сүүлийн арав хүрэхгүй жилийн дотор Монгол Улсын нэгдсэн төсвийн хэмжээ эрс нэмэгдэж урьд өмнө хэрэглэгдэж байгаагүй их наяд хэмээх тоогоор хэмжигдэх болсонтой зэрэгцэн төсвийн төвлөрлийг сааруулж, ялангуяа орон нутгийн эрх мэдлийг нэмэгдүүлэх чиглэлээр төрөөс дэс дараалсан арга хэмжээ авч байна. Тухайлбал, орон нутгийн төсвөөс хөгжлийн сангийн хөрөнгийг тусгаарлаж, зарцуулалтыг нь иргэдийн саналаар шийдвэрлэж байхаар болж орон нутагт иргэдийн дунд нээлттэй хэлэлцүүлгүүд өрнөлөө. Мөн төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах үүднээс олон нийтийн оролцоог бага багаар нэмэгдүүлж байна.

Төсвийн харилцааны шинэ нөхцөлд түүний ил тод, нээлттэй байдлыг хангах явдал улам чухлаар шаардагдах болжээ. Урьд өмнө байгаагүй их хэмжээний төсвийг иргэд, олон нийтийн идэвхтэй оролцоогүйгээр бодитой төлөвлөх, хянах боломжгүй. Үүний тулд иргэд, татвар төлөгчдийн оршин суугаа газар нутаг өдөр тутмын ажил, амьдралтай шууд холбоотой төсвийн үнэн зөв мэдээллийг ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар өгч байх нь тэдний зүгээс төсвийн үйл явцад анхаарлаа хандуулж бүтээлчээр оролцох үндсэн нөхцөл болдог.

Иймээс төсвийн талаар төрөөс, ялангуяа нутгийн удирдлагын зүгээс хүлээх хариуцлагыг тодорхой болгох шаардлага нь манай улсын хувьд нэн чухал асуудал болоод байна. Энэхүү хариуцлагын тогтолцоог бүрдүүлэх зорилт нь төсвийн үйл явцын нарийн асуудлуудыг хүн амын цөөн хувь нь ойлгодог манайх шиг улс оронд төвөгтэй төдийгүй төсвийн үйл явцын үндсэн үе шатуудад иргэдийн зүгээс бүтээлчээр оролцох боломжийг олгохгүй байгаа юм. Иймээс төсвийн үйл явцын талаарх олон нийтийн ойлголт, түүн дэх иргэдийн оролцоо нь төсвийг боловсруулах, хэрэгжүүлэх үйл явцад Засгийн газар, нутгийн удирдлагын зүгээс хүлээх хариуцлагыг бий болгож, дээшлүүлэхэд шийдвэрлэх ач холбогдолтой.

Энэ утгаар авч үзвэл, олон нийтийн оролцоог хангахуйц байхын тулд төсвийн үйл явц ил тод байх шаардлагатай гэдгийг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Төсвийн үйл явцын ил тод байдал хангагдаагүй тохиолдолд олон нийтийн оролцоо бий болохгүй бөгөөд энэ нь мөн төсвийн бодлогыг боловсруулах үйл явц дахь олон нийтийн хэлэлцүүлгийн хамрах хүрээ, агуулгыг хязгаарлах болно. Нөгөө талаас, төсвийн үйл явц ил тод байх нь бодлого боловсруулагчдад хариуцлагын мэдрэмжийг бий болгох; төрөөс хариуцлагатай, шударга шийдвэр гаргадаг болгох; ирээдүйн хөгжлийн талаар илүү сайн төсөөлөл, стратегийг тодорхойлох; төсвийн төслийг цаг хугацаанд нь, үр дүнтэй боловсруулж хэрэгжүүлэхийг дэмжих; төсвийн үйл явцад хуулийн дагуу илүү сайн хяналт тавих; олон нийтийн хүсэл

эрмэлзэл, итгэлийг бий болгох, түүнчлэн Засгийн газар хүнийхээ төлөө ажиллах чадварыг бий болгоход хувь нэмрээ оруулдаг.

Төсвийн ил тод байдлын ойлголт нь ихэвчлэн төсвийн үйл явцын нээлттэй байдал, энэ үйл явцад олон нийтийг оролцуулах боломжтой холбоотой байдаг. Ил тод төсвийн үйл явц нь төр, орон нутгийн бодлого, тэргүүлэх чиглэлийг тодорхойлоход иргэд оролцох боломжит орон зайг бий болгодог хэдий ч оролцоонд тулгуурлан хариуцлагатайгаар шийдвэр гаргахыг баталгаажуулна гэсэн үг биш юм. Олон нийтийн оролцоог хангахуйц байхын тулд төсвийн үйл явц нь улсын болон орон нутгийн түвшинд аль алинд нь ил тод байх хэрэгтэй. Иймээс орон нутгийн түвшинд төсвийн эрх мэдэл шилжихийн хэрээр ил тод байдлын ач холбогдол улам өсөн нэмэгдэж байгаа болно.

Өргөн уудам нутагтай манай орны засаг захиргааны үндсэн нэгж болох 21 аймаг, нийт хүн амын 40 гаруй хувь оршин суудаг нийслэл Улаанбаатар хотод орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангаж, иргэддээ төсвийн мэдээллийг нээлттэй хүргэж байгаа эсэхийг үнэлж, чухам юуг өөрчлөх шаардлагатай байгаа талаар тулгамдсан асуултад хариу өгөх нь “Орон нутгийн төсвийн ил тод байдлын индекс” судалгааны ажлын үндсэн зорилго юм.

Орон нутгийн төсвийн ил тод байдлыг үнэлэх судалгааг 2010-2011 онд Олон улсын төсвийн түншлэл байгууллагын Нээлттэй төсвийн санаачилгын санхүүжилт, арга зүйн дэмжлэгтэйгээр Нээлттэй Нийгэм Форум (ННФ), “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээтэй хамтран гүйцэтгэсэн билээ. Орон нутгийн төсвийн ил тод байдалд гарч буй өөрчлөлтийг тодорхойлох үүднээс энэхүү судалгааг хоёр жил тутамд хийж байгаа юм. 2013 оны ээлжит судалгааг ННФ орон нутгийн иргэний нийгмийн байгууллагууд болон судлаачидтай хамтран гүйцэтгэлээ.

Энэхүү тайланг дараах бүтэцтэйгээр боловсрууллаа. Бүлэг 1-д “Орон нутгийн төсвийн ил тод байдал – 2011” судалгааны тухай, “Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013” судалгааны онцлог, судалгааны ажлын зохион байгуулалт, үнэлгээний аргачлал, судалгаанд хамруулсан төсвийн баримт бичиг ба үйл явцын талаар өгүүлэх болно. 2-р бүлэгт аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын индекс буюу рейтингийг танилцуулна. 3-р бүлэгт “Орон нутгийн төсвийн ил тод байдал-2013” судалгааны үр дүнг аймаг, нийслэл тус бүрээр нь болон нутгийн удирдлагын байгууллагаас орон нутгийн төсвийн ил тод байдлыг эрх зүйн баримт бичигт тусгаж ил тод болгосон байдал, төсвийн баримт бичгүүдийн ил тод байдлын аймаг, нийслэлийн нэгдсэн үнэлгээг дэлгэрэнгүй хэлбэрээр танилцуулах бол 4-р бүлэгт судалгааны үр дүнд тулгуурлан гаргасан ерөнхий дүгнэлт болон бодлогын зөвлөмжийг багтаасан болно.

1.1 “Орон нутгийн төсвийн ил тод байдал – 2011” судалгааны тухай

2011 онд хийсэн судалгаа нь Монгол Улсад орон нутгийн төсвийг ил тод байдлын талаас нь иж бүрнээр үнэлэх анхны оролдлого байв. Хоёр жилийн өмнө Монгол Улсын төсвийн эрх зүйн орчин одоогийнхоос эрс өөр, шинэчлэгдэж амжаагүй, шинээр батлагдсан зарим хууль тогтоомж хэрэгжиж эхлээгүй байлаа.

Судалгааны дүнгээс үзэхэд төсвийн ил тод байдал орон нутагт бүхэлдээ хангалтгүй байсан юм. Энэ нь төсвийн эрх Засгийн газарт хэт төвлөрч орон нутгийн эрх мэдэл хязгаарлагдмал хэвээр байсантай холбоотой. Ялангуяа төсвийн төсөл боловсруулах үйл

явцын талаар иргэдэд мэдээлэл өгдөггүй, хаалттай учраас санал бодлоо илэрхийлэх, тусгах ямар ч боломжгүй байсныг олж тогтоосон юм. Нийслэл Улаанбаатар хот дангаараа харьцангуй өндөр оноо авсан нь газар зүйн хувьд алслагдсан аймгуудтай харьцуулахад илүү таатай нөхцлийн илрэл болохоос биш, төсвөө иргэддээ илүү нээлттэй байлгадаг гэсэн үг биш байв.

Энэхүү судалгааг явуулахдаа Олон улсын төсвийн түншлэл байгууллагын арга зүйд түлхүү тулгуурласан боловч өөрийн орны онцлог нөхцөлд нийцсэн зарим асуудлыг жишээлбэл, төсвийн баримт бичгийг судалгааны асуулгад нэмж оруулан боловсруулсан юм. Орон нутгийн иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл дээрх судалгааны асуулгын дагуу мэдээлэл цуглуулж, нотлохоос эхлээд олон хариултаас сонгох төдийгүй дүгнэлт хийх үүрэг хүлээж ажилласан юм. Харин тэдний ирүүлсэн дүгнэлтийг нэгтгэн аймгуудыг оноогоор байр эзлүүлж жагсаан үнэлгээг хийсэн.

Энэ нь “Иргэд төсвөө хянана” сүлжээний гишүүн орон нутгийн байгууллагуудын хувьд хамтран гүйцэтгэсэн анхны томоохон судалгаа, төсвийн мэдээлэл цуглуулах, түүнийгээ нотлох зэрэг арга барилыг эзэмшиж, чадавхиа сайжруулахад бодитойгоор нөлөөлсөн ач холбогдолтой ажил болсон билээ.

1.2 “Орон нутгийн төсвийн ил тод байдал – 2013” судалгааны онцлог

Эхний судалгаанаас хойш хоёр жилийн хугацаанд төсвийн эрх зүйн зохицуулалт үндсээрээ шинэчлэгдлээ. Төсвийн тухай хуулийг шинэчлэн баталж, түүнд орон нутгийн төсвийн эрх мэдлийг өргөжүүлэх чиглэлээр ОНХС, түүнийг бүрдүүлэх, зарцуулах, тус сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг, хороодод олон нийтийн нээлттэй санал асуулга явуулах тухай олон чухал зохицуулалт орж, хэрэгжүүлэх ажиллагаатай холбогдох хэд хэдэн журам, дүрмийг Сангийн сайдын тушаалаар батлан мөрдөж байна.

Түүнчлэн “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрх чөлөөний тухай хууль” батлагдаж төсөв, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах нэлээд нарийвчилсан заалтуудыг тусгасан Засгийн газрын хэд хэдэн тогтоол гарсан юм. Мөн 2012-2013 оны туршид Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс “Иргэдийн оролцоотой төсвийн менежмент”-ийн санаачилга гаргаж үндэсний хэмжээний хэд хэдэн удаагийн форум зохион байгуулав. Анх удаа 2013 онд ОНХС-гийн хөрөнгийг хэрхэн зарцуулах талаар засаг захиргааны хамгийн анхан шатны нэгж болох баг, хороодод хэлэлцүүлэг өрнөж, аймаг, нийслэл, сум, дүүргийн түвшинд санал асуулга явуулсан нь янз бүрийн шалтгааны улмаас учир дутагдалтай байсан хэдий ч орон нутгийн иргэдийн анхаарлыг энэ зүгт хандуулсан чухал алхам боллоо.

Үүний зэрэгцээ иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс төсвийн ил тод байдлыг сайжруулах чиглэлээр төрөл бүрийн санал, санаачилга гаргаж ажилласны нэг нь 2012-2013 онд “Иргэд төсвөө хянана” төрийн бус байгууллагын сүлжээнээс “Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын загвар стандарт”-ыг боловсруулах ажлыг хийж гүйцэтгэсэн явдал юм. Энэ баримт бичигт орон нутгийн төсөв, ОНХС, худалдан авах ажиллагаатай холбоотой эрх зүйн олон тооны, заримдаа өөр хоорондоо зөрчилдсөн зохицуулалтуудыг нэгтгэж энгийн, ойлгомжтой загвар хэлбэрт оруулсан. Энэ нь нэг талаас төрийн албан

хаагчид тэдгээрийг түвэггүй хэрэгжүүлэх, нөгөө талаас иргэд, олон нийтийн зүгээс ашиглахад хялбар мэдээлэлтэй болсноор төсөвт хяналт тавих боломжийг олгосон юм. Загвар стандартыг зарим аймаг, сум болон нийслэл, түүний дүүрэгт туршин хэрэгжүүлсэн байна. Өнөөгийн байдлаар тус загварыг www.iltusuv.mn цахим хуудсанд байршуулан орон нутгийн төсвийн мэдээллийг загварын дагуу ил тод болгох ажлыг үргэлжлүүлж байна.

Ийм шинэ нөхцөл байдалд “Орон нутгийн төсвийн ил тод байдал-2013” судалгааг Нээлттэй Нийгэм Форумгаас зохион байгуулж “Иргэд төсвөө хянана” сүлжээний гишүүн байгууллагууд болон судлаачдын оролцоотойгоор хэрэгжүүлж судалгааны үр дүнг толилуулж байна.

1.3 Судалгааны ажлын зохион байгуулалт

Монгол Улсын 21 аймаг, нийслэл Улаанбаатар хот, түүний 4 дүүрэг бүрт нэг иргэний нийгмийн байгууллагыг төлөөлсөн тус бүр нэг судлаач ажиллаж, мэдээлэл цуглуулсан бөгөөд судлаачдаас бүрдсэн баг үнэлгээг хийж гүйцэтгэлээ. Орон нутгийн судлаачид орон нутгаас мэдээлэл цуглуулан нотолж ирүүлэх ажлыг 2013 оны 10 дугаар сараас 2014 оны 1 дүгээр сарыг дуустал нийт 3 сарын хугацаанд хийж гүйцэтгэсэн ба үнэлгээг 2014 оны хоёр, гуравдугаар сард хийж дуусгав.

Судалгааны эхний үе шатанд судалгааны багийнхан ажлын төлөвлөгөө гаргаж төсвийн баримт мэдээлэл цуглуулж нотлох асуулгын маягт, орон нутгийн судлаачийн ажлын удирдамж зэргийг боловсруулж, орон нутагт ажиллах судлаачдыг сонгож авсан*. Ингэхдээ гол төлөв тухайн аймаг, нийслэл буюу дүүрэгт үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллагын ажилтан, зарим тохиолдолд хэвлэл мэдээллийн ажилтан, сэтгүүлчийг ажиллуулав. Аль ч тохиолдолд орон нутгийн төр, захиргааны байгууллагаас хараат бусаар ажиллах, баримт мэдээлэл олж цуглуулах чадварыг чухалчилсан болно.

2013 оны 11 дүгээр сарын эхээр орон нутагт ажиллах судлаачдыг Улаанбаатар хотод урьж, хоёр өдрийн судалгааны арга зүйн сургалт, семинарт оролцуулан уг судалгааны зарчим, төсвийн үйл явцын ба баримт бичгийн мэдээлэл цуглуулж, түүнийг нотлон ирүүлэх арга зүй, асуулгын маягт бөглөх аргачлалыг таниулж, удирдамж, чиглэл өгсөн юм.

Өмнөх судалгаанд орон нутгийн судлаачид олон сонголтот хариулт бүхий асуулгад хариулах, эцсийн дүгнэлт хийх үүрэгтэй байсан нь янз бүрийн шалтгаанаар хувийн үнэлэмжээр бодитой бус хандах, эсвэл дүгнэлтээ нотолж чадахгүй байх хандлага ажиглагдсан юм. Үүнээс сургамж авч энэ удаад орон нутаг дахь судлаач нь мэдээлэлд ямар нэгэн дүгнэлт хийх үүрэг хүлээхгүй, зөвхөн удирдамж, асуулгын маягтын дагуу төсвийн холбогдолтой баримт мэдээллийг цаглабарын дагуу үндсэн эхээр нь цуглуулж, тэдгээрийг иргэд, олон нийтэд хэрхэн ил тод, нээлттэй болгосон тухай баримт нотолгооны хамт Улаанбаатар хот дахь судалгааны багт шуурхай ирүүлэх үүрэгтэйгээр ажиллав.

Тэдний ирүүлсэн төсвийн баримт мэдээлэл, хавсаргасан нотолгоо, эх сурвалж, маягтын дагуу хийсэн тайлбарыг үндэслэн судлаачдын баг шинжилгээ хийж, төсвийн үйл явцын болон баримт бичгийн ил тод байдлыг үнэлэх, индекс гаргаж жагсаах ажлыг хийж гүйцэтгэсэн болно.

* Асуулгын маягтыг Хавсралт 3-аас, судлаачийн ажлын удирдамжийг Хавсралт 2-оос үзнэ үү.

1.4 Үнэлгээний аргачлал

Монгол Улсын 21 аймаг, нийслэл Улаанбаатар хотын төсвийн ил тод байдлыг ижил шалгуураар үнэллээ. Нийслэлийн хувьд илүү давуу нөхцөл байдалд оршдог тул судалгааны дүнг бодитой болгох үүднээс зарим дүүргийн төсвийг тусгайлан судалж харгалзсан болно. Харин энэ удаад сум, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит компаниудыг судалгаанд хамруулаагүй.

Үнэлгээний шалгуур буюу жиших үзүүлэлт нь юуны өмнө Монгол Улсын Төсвийн тухай хууль, түүнд холбогдох журам, дүрэм болон олон улсын жишиг, стандарт гэх мэт баримт бичгийн шаардлагад үндэслэгдсэн болно. Шалгуурыг дээр дурдсан “Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын загвар стандарт”-ын дагуу томъёолов. Мөн “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”-аас аймаг, нийслэлийн төсөвт хамаарах заалтуудыг сонгон авч, харин төсвийн байгууллагад хамаарах заалтуудыг энэхүү судалгааны шалгуур болгосонгүй.

Ингэхдээ 2011 оны судалгааны асуулгад төсвийн баримт бичиг ба үйл явцыг салгасны улмаас асуултууд нэлээд давтагдаж нүсэр харагдуулж байсан юм. Үүнийг цэгцэлж нэгтгэсний зэрэгцээ судалгааны мэдээлэл цуглуулах маягтыг аль болохоор хялбар бөглөх, баримт нотолгоо цуглуулах ажлыг орон нутаг дахь төрийн бус байгууллагын судлаачдад хүндрэлгүй байхаар зохион байгууллаа.

Орон нутгийн судлаачид нь “Аймаг, нийслэлийн төсвийн мэдээлэл, баримт бичгийг цуглуулж, тэдгээрийг хэрхэн ил тод, нээлттэй болгосныг нотолж ирүүлэх маягтууд”-ын асуултуудад хариулахдаа тухайн төсвийн мэдээлэл, баримт бичгүүдийг олж үзээд, уг мэдээллийг олон нийтэд ил тод болгосон эх сурвалж, цаг хугацаа, арга хэлбэр, нөхцөл байдлын талаар асуулгын зохих нүдэнд тайлбарлаж, бас ямар мэдээлэл, баримт бичиг, нотолгоог (цаасан, цахим, дуу, дүрс бичлэгийн ямар ч хэлбэрээр байж болно) хавсаргаснаа жагсаан ирүүлсэн юм. Орон нутгийн судлаач нь төсвийн баримт бичгийг анхдагч эх сурвалжаас авсан үндсэн эхээр буюу хуулбарлаж ирүүлэх ба өөрчлөхгүй, нэмж хасахгүй, агуулгад дүгнэлт хийхгүй, агуулгыг тайлбарлахгүй байх зарчмыг баримтлав.

Орон нутгийн төсвийн үйл явц, баримт мэдээллийн ил тод байдлыг дараах байдлаар үнэллээ.

Нэгдүгээрт, нээлттэй эх сурвалжаар ил тод болгосон бол хамгийн өндөр оноо өгсөн болно. Ингэхдээ, орон нутгийн сонин хэвлэл, телевиз, радио, нутгийн удирдлагын байгууллагын албан ёсны болон бусад цахим хуудас, мэдээллийн хуудас, товхимол, мэдээллийн самбар, аймаг, нийслэлийн номын сан, иргэний танхим, хэвлэлийн бага хурал, уулзалт, хэлэлцүүлэг гэсэн дарааллаар авч үзэн ил тод байдлыг үнэлэв.

Хоёрдугаарт, дээр дурдсан нээлттэй эх сурвалжаас олдоогүй буюу ил тод болоогүй тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд амаар буюу энгийн байдлаар хандан авч болох бол үнэлгээний оноо бага байхаар тооцлоо.

Гуравдугаарт, албан тушаалтанд хандаад авч чадаагүй бол “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн 3 дугаар бүлгийн холбогдох заалтын дагуу албан бичгээр хүсэлт тавьж авч болно. Ийм аргаар нээлттэй болгосон бол хамгийн бага оноогоор үнэлэв.

Ил тод, нээлттэй болгосныг нотлох аргууд нь сонин, хэвлэлийн тухайн дугаар буюу хайчилбар, ном товхимол, сонин бичгийн нэг хувь, гэрэл зураг, эсвэл видео бичлэг, цахим хуудсанд нийтлэгдсэн материал, түүний зураг (screenshot) ба хуулбар (текст), огноо ба линк (холбоос), баримт бичгийн хуулбар, мэдээлэл, баримт бичгийг олж авахын тулд байгууллага, албан тушаалтантай уулзаж харилцсан тухай товч тэмдэглэл болно.

1.5 Судалгаанд хамруулсан төсвийн баримт бичиг ба үйл явц

Судалгаанд 2013 оны төсвийн үйл явц болон тухайн жилийн туршид гарсан баримт бичгүүдийг хамруулав. Тодруулбал, 2012 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны төсвийн зарцуулалтын үйл явц, 2014 оны төсвийн төсөл, түүнийг хэлэлцэх үйл явц, мөн 2014 оны нэгдүгээр сард эцэслэн гарсан орон нутгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө зэрэг баримт бичгийг хамруулсан болно. Өмнөх жилүүдийн, эсвэл тодорхой цаг хугацаагүй тохиолдлыг “ил тод болгодог” гэх мэтээр ерөнхийлөн авч үнэлээгүй.

Судалгааны хүрээнд дараах үйл явц, баримт бичгүүдийн ил тод байдлыг үнэллээ. Үүнд:

1. Төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдал
2. Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийн баримт бичиг, түүний хэлэлцүүлгийн ил тод байдал
3. Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал
4. Аймаг, нийслэлийн 2014 оны батлагдсан төсвийн ил тод байдал
5. Иргэний төсөв
6. Аймаг, нийслэлийн 2013 оны төсвийн тодотгол (хэрвээ тодотгол хийгдсэн бол)
7. Аймаг, нийслэлийн 2013 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал
8. Аймаг, нийслэлийн 2012, 2013 оны төсвийн гүйцэтгэлийн ил тод байдал
9. Аймаг, нийслэлийн 2014 оны ОНХС-гийн төлөвлөлтийн ил тод байдал
10. Аймаг, нийслэлийн Засаг даргын 2013 оны нөөц хөрөнгийн ил тод байдал
11. Аймаг, нийслэлийн орон нутгийн тусгай сангуудын 2013 оны төсвийн ил тод байдал
12. Аймаг, нийслэлийн 2013 оны хандив, тусламжаар авсан хөрөнгө, түүний зарцуулалтын ил тод байдал

Судалгааны цахим хуудас: Судалгааны явцад орон нутгаас ирүүлсэн зарим мэдээллийг орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын www.iltusuv.mn цахим хуудсанд байршуулж байв. Судалгааны үйл явцын нээлттэй байдлыг хангаж, иргэд, олон нийт, судлаачдын зүгээс санал бодлоо илэрхийлж хэлэлцэх, ашиглах боломжийг хангаж ажиллалаа.

2 Рейтинг

(Аймаг, нийслэлийн төсвийн
ил тод байдлын индекс)

Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын үнэлгээ нь:

- “Төсвийн ил тод байдлыг эрх зүйн баримт бичигт тусгасан байдал”
- “Төсвийн баримт бичгийн ил тод байдал” гэсэн үндсэн хоёр хэсгээс бүрдэнэ.

Нэгдсэн үнэлгээг гаргахдаа төсвийн ил тод байдлыг эрх зүйн баримт бичигт тусгасан байдалд авсан оноог 30 хувь, харин төсвийн баримт бичгийн ил тод байдалд харгалзах оноог 70 хувь гэж тооцсон болно. Энэ нь Монгол Улсын Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн дагуу нутгийн удирдлагын зүгээс орон нутагт мөрдүүлэхээр баталсан шийдвэр, холбогдох төсвийн захирагч нартай байгуулсан гэрээнд орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах асуудлыг хэрхэн тусган ажиллаж буйг харуулна. Үүний зэрэгцээ орон нутгийн төсвийн захирагчид хууль, журмыг хэрхэн мөрдөж төсвийн баримт бичгүүдийг ил тод болгож байгааг илтгэж байгаа юм.


Орон нутгийн төсвийн ил тод байдлыг үнэлсэн судалгааны үр дүнг нэгтгэн Хүснэгт 1-д аймаг, нийслэл бүрээр эрэмбэлэн харуулав.

Хүснэгт 1. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын индекс тооцсон байдал

№	Аймаг, нийслэл	Төсвийн ил тод байдлыг эрх зүйн баримт бичигт тусгасан байдал (30%)	Төсвийн баримт бичгийн ил тод байдал (70%)	Нэгдсэн үнэлгээ	Рейтинг
1	Хөвсгөл	14	41	55	
2	Төв	17	35	52	
3	Говьсүмбэр	14	38	52	
4	Дорноговь	17	32	49	Дунджаас дээш
5	Ховд	15	32	47	
6	Увс	17	30	47	
7	Өмнөговь	13	32	45	
8	Улаанбаатар	14	25	39	
9	Хэнтий	10	27	37	
10	Архангай	8	29	37	
11	Булган	10	26	36	Дундаж
12	Дархан-Уул	12	23	35	
13	Дундговь	10	24	34	
14	Орхон	10	22	32	
15	Сүхбаатар	12	20	32	
16	Дорнод	7	22	29	
17	Завхан	11	16	27	
18	Өвөрхангай	10	17	27	
19	Говь-Алтай	10	17	27	Дунджаас доош
20	Баян-Өлгий	11	15	26	
21	Сэлэнгэ	9	10	19	
22	Баянхонгор	7	8	15	
	Дундаж	12	25	36	

Үнэлгээний дүнг аймаг, нийслэлийн дунджаар авч үзвэл нийт авбал зохих 100 онооны 36.2 хувийг авсан нь орон нутгийн төсвийн ил тод байдал хангалтгүй түвшинд байгааг илтгэж байна. Хөвсгөл аймаг хамгийн өндөр буюу 55.3 хувьтай үнэлэгдсэн бол Баянхонгор аймгийн үнэлгээ 15.0 хувь байна.

График 1. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын өнөөгийн түвшин



Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дээд оноо нь 55 байгаа учир аймаг, нийслэлийн үнэлэгдсэн дундаж үзүүлэлтэд үндэслэн орон нутгийн төсвийн ил тод байдлын өнөөгийн түвшинг үнэлэхэд “дунджаас дээш (43-аас дээш оноотой)” үнэлгээг Хөвсгөл, Төв, Говьсүмбэр, Дорноговь, Ховд, Увс, Өмнөговь аймгууд авсан бол “дундаж (30-42 оноотой)” үнэлгээг Улаанбаатар хот, Хэнтий, Архангай, Булган, Дархан-Уул, Дундговь, Орхон, Сүхбаатар аймгууд авчээ. Харин Дорнод, Завхан, Өвөрхангай, Говь-Алтай, Баян-Өлгий, Сэлэнгэ, Баянхонгор аймгууд “дунджаас доош (30 хүртэл оноотой)” түвшинд үнэлэгдсэн байна.

Энэ нь аймаг, нийслэлийн түвшинд төсвийн ил тод, нээлттэй байдал “нэн хангалтгүй байна” гэсэн өмнөх судалгааны үр дүнтэй адил байгааг харуулна. Өөрөөр хэлбэл, төсвийн ил тод байдлыг хангах талаар хууль тогтоомжид хангалттай олон заалт тусгагдсан боловч

эдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр үндсэндээ ахиц гарсангүй гэж дүгнэж болохоор байна. Гэхдээ зарим аймгууд тухайлбал, Дорноговь, Өмнөговь, Хөвсгөл, Говьсүмбэр, Орхон, Дархан-Уул, Дундговь, Төв, Увс, Хэнтий аймгуудын төсвийн ил тод байдлын үнэлгээ сайжирсан бол Улаанбаатар хот болон Баянхонгор, Баян-Өлгий, Завхан, Өвөрхангай, Сэлэнгэ зэрэг аймгийн үнэлгээ буурсан үзүүлэлттэй байгаа юм.

Хүснэгт 2. Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын үнэлгээний харьцуулалт, 2011 ба 2013 он

№	Аймаг, нийслэл	Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2011		Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013	
		Нийт оноо	Рейтинг	Нийт оноо	Рейтинг
1	Архангай	44.5	5	36.8	10
2	Баян-Өлгий	32.3	15	26.0	20
3	Баянхонгор	32.4	14	15.0	22
4	Булган	44.6	4	36.5	11
5	Говь-Алтай	29.4	17	26.7	19
6	Говьсүмбэр	38.3	8	51.5	3
7	Дархан-Уул	25.5	19	35.2	12
8	Дорноговь	28.2	18	48.9	4
9	Дорнод	36.5	11	29.3	16
10	Дундговь	18.0	21	34.5	13
11	Завхан	37.4	9	27.1	17
12	Орхон	16.6	22	32.1	14
13	Өвөрхангай	37.0	10	27.0	18
14	Өмнөговь	29.7	16	44.5	7
15	Сүхбаатар	34.6	12	31.4	15
16	Сэлэнгэ	47.6	3	18.3	21
17	Төв	40.2	6	51.9	2
18	Увс	38.4	7	46.4	6
19	Ховд	48.0	2	47.1	5
20	Хөвсгөл	33.8	13	55.3	1
21	Хэнтий	19.9	20	37.1	9
22	Улаанбаатар	55.5	1	38.7	8
Дундаж оноо		34.9		36.2	

Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээний дундаж оноо 2011 онд 34.9 байсан бол төсвийн харилцааг ялангуяа төсвийн ил тод байдлыг зохицуулсан хэд хэдэн эрх зүйн баримт бичиг батлагдан мөрдөгдөж байгаатай холбоотойгоор 2013 оны байдлаар 36.2 болж 1.3 оноогоор нэмэгджээ. Энэ нь аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлыг хангах ажилд бага ч болов ахиц гарч нутгийн удирдлагын зүгээс төсвийн үйл явц болон төсвийн баримт бичгийг ил тод, нээлттэй болгох эхний алхмууд хийгдэж эхэлж буйг илтгэнэ гэж үзэж байна.

З Судалгааны үр дүн


Бүлэг 2-т орон нутгийн төсвийн ил тод байдлыг 2013 оны байдлаар үнэлсэн судалгааны үр дүнг “Нутгийн удирдлагын байгууллагаас орон нутгийн төсвийн ил тод байдлыг эрх зүйн баримт бичигт тусгасан байдал” болон “Төсвийн баримт бичгүүдийн ил тод байдал” гэсэн үндсэн хоёр чиглэлээр нэгтгэн аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын рейтингийг товч танилцуулсан билээ. Харин энэ бүлэгт:

- Орон нутгийн төсвийн ил тод байдал (аймаг, нийслэл тус бүрээр)
- Нутгийн удирдлагын байгууллагаас орон нутгийн төсвийн ил тод байдлыг эрх зүйн баримт бичигт тусгасан байдал
- Төсвийн баримт бичгүүдийн ил тод байдлын аймаг, нийслэлийн нэгдсэн үнэлгээг дэлгэрэнгүй танилцуулж байна.

3.1 Орон нутгийн төсвийн ил тод байдал (аймаг, нийслэл тус бүрээр)


Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлын түвшинг 2013 оны байдлаар үнэлэхэд дунджаас дээш үнэлгээг Хөвсгөл, Төв, Говьсүмбэр, Дорноговь, Ховд, Увс, Өмнөговь аймгууд авсан болно.

График 2. Төсвийн ил тод байдлын “дунджаас дээш” үнэлгээтэй аймгууд



Эдгээр аймгуудын үнэлгээг дунджаар авч үзвэл төсвийн гүйцэтгэлийн болон хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал нийт 4 оноо авахаас 2.7-2.8 гэж үнэлэгдсэн нь хамгийн сайн гарсан үзүүлэлт болсон байна.¹ Мөн батлагдсан төсөв, ИТХ-ын хуралдаан, ОНХС, орон нутгийн тусгай сангуудын ил тод байдал харьцангуй сайн буюу 2.4-2.6 гэсэн үнэлгээг авчээ. Энд дурдсанаас бусад төсвийн баримт бичгийн үнэлгээ хангалттай биш байгааг График 3-аас харж болно.


График 3. Төсвийн ил тод байдлын “дундаж” үнэлгээтэй аймаг, нийслэл



Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээгээр дундаж гэж үнэлэгдсэн 8 аймгаас Хэнтий, Архангай аймгууд хандив, тусламжийн ил тод байдлаараа тэргүүлсэн бол Улаанбаатар хот төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлаар, Сүхбаатар аймаг ИТХ-ын хуралдааны болон төсвийн тодотголын ил тод байдлын үнэлгээгээр бусдаасаа илүү үнэлэгджээ. Эдгээр аймгийн үзүүлэлтүүдийг дунджаар авч үзвэл төсвийн гүйцэтгэл л 2.5 гэсэн үнэлгээг авч бусад баримт бичгүүд 2.0-оос доош үнэлгээтэй байна.

¹ Орон нутгийн төсвийн ил тод байдлын шалгуур үзүүлэлтүүд болон тэдгээрт харгалзах оноог Хавсралт 4-өөс үзнэ үү.

График 4. Төсвийн ил тод байдлын “дунджаас доош” үнэлгээтэй аймгууд



Төсвийн ил тод байдал нь дунджаас доош үнэлэгдсэн 7 аймгаас Дорнод төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлаар, Говь-Алтай батлагдсан төсвийн ил тод байдлын үнэлгээгээр бусад аймгаас илүү байгаа юм. Өвөрхангай аймгийн төсвийг хэлэлцэн баталж буй ИТХ-ын хуралдаан, Баянхонгор аймгийн орон нутгийн тусгай сангуудын мэдээлэл арай илүү үнэлгээг авчээ. Эдгээр аймгийн хувьд төсвийн бусад баримт бичгүүд үндсэндээ иргэд, олон нийтэд ил тод мэдээлэгдээгүй байна.

Орон нутгийн нийт 26 судлаачийн цуглуулсан мэдээлэл, баримт нотолгоо, үнэлгээний багийн 5 гишүүний хараат бусаар гаргасан үнэлгээнд тулгуурлан дундаж оноогоор авч үзэхэд орон нутгийн төсвийн ил тод байдал хангалтгүй байна гэсэн дүгнэлтэд хүрлээ.

3.2 Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах заалтыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрхзүйн баримт бичигт тусгасан байдал

Орон нутагт ажилласан судлаачдын цуглуулсан болон аймаг, нийслэлийн цахим хуудас дахь мэдээлэлд тулгуурлан үнэлгээний багийн гишүүд дараах 10 чиглэлээр үнэлгээг хийж оноог нэгтгэв (Хүснэгт 3).²

2 Нутгийн удирдлагаас баталсан эрх зүйн баримт бичигт төсвийн ил тод байдлын талаар тусгасан байдлын үнэлгээний нэгтгэлийн дэлгэрэнгүйг Хавсралт 6-аас үзнэ үү.

Хүснэгт 3. Нутгийн удирдлагаас баталсан эрх зүйн баримт бичигт төсвийн ил тод байдлын талаар тусгасан байдлын үнэлгээ

№	Эрх зүйн баримт бичгийн нэр	Аймаг, нийслэлийн дундаж	Оноо ³
1	Орон нутгийн бодлогын баримт бичиг	72	2.9
2	Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ба Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр	37	1.5
3	Аймаг, нийслэлийн Засаг даргын салбарын Төсвийн ерөнхийлөн захирагч нартай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх гэрээ	27	1.1
4	Аймаг, нийслэлийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр	78	3.1
5	Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар	45	1.8
6	Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ	31	1.2
7	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын даргын албан бичиг, үүрэг даалгавар	17	0.7
8	Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын даргын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ	32	1.3
9	Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан бичиг, үүрэг даалгавар	13	0.5
10	Аймгийн төсвийн байгууллагуудын төсвийн захирагч нартай байгуулсан үр дүнгийн гэрээ	37	1.5
Нэгдсэн үнэлгээ		39	1.6

Орон нутгийн бодлогын баримт бичиг-т тухайлбал, аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2013, 2014 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилтыг тодорхойлсон баримт бичигт орон нутгийн төсвийн ил тод байдлын талаар тусгасан эсэхийг судалж үзэхэд ихэнх аймаг “Төсвийн ил тод байдлыг ханган ажиллаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлийг олон нийтэд мэдээлэх” талаар тодорхой заалтыг тусгасан нь сайшаалтай байна. Баян-Өлгий, Говь-Алтай, Дорноговь, Дундговь, Завхан, Сэлэнгэ, Увс, Ховд, Хэнтий аймгууд эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийг тодорхойлсон баримт бичигтээ орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах зорилтыг тусгаж баталсны зэрэгцээ олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байршуулан иргэд, олон нийт чөлөөтэй олж үзэх боломжоор хангасан байна. Орхон, Төв, Хөвсгөл зэрэг аймгууд төсвийн ил тод байдлыг хангах зорилтыг тусгасан энэхүү баримт бичгийг ном товхимол, CD болгон хэвлүүлж нийтийн хүртээл болгожээ.

Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал (ИТХ) ба Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр: Орон нутагт ажилласан судлаачдын цуглуулсан мэдээлэл, аймаг, нийслэлийн цахим хуудсанд тавигдсан ИТХ-ын болон Тэргүүлэгчдийн хурлын тогтоолд төсвийн ил тод байдлыг хангах талаар тусгасан байдлыг үнэлэхэд ИТХ-аас гаргасан тогтоолуудыг нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэл, иргэний танхим, мэдээллийн самбаруудад байршуулсан байна. Гэтэл төсвийн ил тод байдлыг хангах асуудлыг хэлэлцсэн тухай ИТХ-

3 Орон нутгийн төсвийн баримт бичгүүд болон төсвийн үйл явцын нээлттэй, ил тод байдлыг үнэлэхэд ашиглах шалгуур үзүүлэлт, түүнд харгалзах оноог Хавсралт 4-өөс үзнэ үү.

ын хуралдааны дэгд тусгагдсан ч тодорхой журам, зохицуулалтыг баталсан баримтууд олдсонгүй.

Аймаг, нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, захирамж, албан даалгавар: Аймаг, нийслэлийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд ихэнх аймаг орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах зорилтыг тусган баталжээ. Тухайлбал:

- Булган аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах” гэсэн бүлэгт “Төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайланг байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлж, иргэд, иргэний нийгмийн зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байх”, 26 дахь заалтад “Орон нутгийн төсвийн эх үүсвэрийг хөгжлийн бодлого, зорилго, зорилттой уялдуулан хамгийн оновчтой, үр ашигтай хуваарилж хэрэгжүүлэх, төсвийн ил тод, тунгалаг байдлыг хангана” гэж заасан байна.⁴
- Дундговь аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Иргэн-идэвхтэй оролцогч” гэсэн 5-р бүлгийн 5.16 дахь заалтад “Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтын шатанд ил тод байдлыг ханган бүх шатны төлөвлөлтийг орон нутгийн иргэдийн оролцоонд тулгуурлан гүйцэтгэх зарчим баримтална” гэжээ.⁵
- Завхан аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг товхимол болгон хэвлүүлсэн бөгөөд Иргэний нийгэм, ТББ-ын салбарын хүрээнд гэсэн хэсгийн 4.2.2 дахь заалтад “Төсвийн нээлттэй ил тод, байдлыг хангаж, төсөв боловсруулах, зарцуулах үйл ажиллагаанд хамт олны буюу үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас дүгнэлт өгч, санал гаргах шинэ аргыг нэвтрүүлж, хэвшүүлнэ” гэж тусгасан байна.
- Өвөрхангай аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны “Бүтээлч-Өвөрхангай” хөтөлбөрийн 1.1.5-д “Төсөвт байгууллагын “зардлыг санхүүжүүлдэг” аргыг өөрчилж, “хөтөлбөрт төсөв”-ийн тогтолцоонд шилжүүлэн, төсвийн гүйцэтгэлийн тайлагналыг иргэдэд ил тод, нээлттэй болгоно”, 1.1.12-т “Төсвийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлж, иргэд, олон нийтийн хяналт дор ил тод явуулах тогтолцоог бүрдүүлнэ” гэсэн заалт оржээ.
- Өмнөговь аймгийг 2013-2016 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Аймгийн эдийн засаг, төсөв санхүүгийн чадавхийг нэмэгдүүлж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ” гэсэн бүлгийн 15-д “Төрийн сангийн тогтолцоог иж бүрэн нэвтрүүлж, дотоод хяналтыг сайжруулан, ажиллагсдын чадавхийг бэхжүүлэх замаар төсвийн тогтвортой, иж бүрэн, үнэн зөв, ил тод, зохистой хариуцлагатай байх зарчмыг хангана” гэсэн заалт оруулсан байна.
- Сүхбаатар аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг товхимол болгон хэвлүүлж, бүх айл өрхүүдэд тараасан бөгөөд уг хөтөлбөрийн “Төсөв санхүүгийн бодлого” бүлгийн 8-д “төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа,

4 эх сурвалж: <http://www.bulgan.gov.mn/serv/activity>

5 эх сурвалж: <http://www.dundgovi.gov.mn/dundgobi/index.php?pid=126&nid=272>

ажил үйлчилгээ, худалдан авах үйл ажиллагааг ил тод нээлттэй байлган, үр ашгийг сайжруулна” гэж заажээ.

- Хэнтий аймгийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “Аймгийн санхүү, татварын бодлогыг сайжруулах чиглэлээр” гэсэн бүлгийн 1.5.2-д “Төсвийг төлөвлөх, бүрдүүлэх, хуваарилах, тайлагнах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангаж, төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхэд баримтлах 5 зарчмыг мөрдлөг болгон ажиллана” гэсэн заалт орсон байна.⁶
- Увс аймгийн Засаг даргын 2013-2016 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр “Увсын өнгө” сонинд хэвлэгдэн тараагдсан бөгөөд хөтөлбөрийн “Ажилтай, орлоготой монгол хүн” бүлгийн 1-д “Орон нутагт төсвийн эрх мэдлийг нэмэгдүүлэн төсвийн нээлттэй, ил тод байдлыг хангаж, “Шилэн халаас” хөтөлбөр хэрэгжүүлэх, төсвийн хэлэлцүүлгийг тогтмолжуулах, аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайланг цахим шуудангаар авах нөхцөлийг бүрдүүлнэ” гэж заажээ.⁷
- Ховд аймгийг 2013-2016 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн “Эдийн засгийн бодлогын хүрээнд” бүлгийн 3.5-д “Сангуудын удирдлагын менежментийг боловсронгуй болгож, зарцуулалтын үр ашгийг сайжруулж, ил тод нээлттэй болгоно”, 3.7-д “Төсвийн шинэчлэлийн хүрээнд орон нутгийн болон төсвийн байгууллагуудын удирдлага, санхүүгийн ажилтнуудад сургалт зохион байгуулан чадваржуулах, төсвийн шинэ програм нэвтрүүлэх, тоног төхөөрөмж шинэчлэх замаар төсвийн төлөвлөлт, зарцуулалтыг сайжруулж, ил тод байдлыг хангаж ажиллана” гэсэн заалт орсон байна.
- Дархан-Уул аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн “ Санхүү эдийн засгийн бодлого” бүлгийн зорилт 23-т “Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн бүртгэлийн чанарыг дээшлүүлж, төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлыг хангана”, 3 дахь заалтад “Төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлыг хангана” гэж тусгажээ.

Аймгийн Засаг дарга нарын үйл ажиллагааны хөтөлбөрт дээрх байдлаар төсвийн ил тод байдлыг хангах зорилтыг тусган орон нутгийн цахим хуудсанд байршуулснаас гадна товхимол болгон хэвлэж, эсвэл аймгийн сониндоо нийтэлсэн нь иргэд, олон нийт чөлөөтэй танилцах боломжийг олгосны зэрэгцээ төсвийн үйл явцад эдгээр зорилт хэрхэн хангагдаж байгааг хянах нөхцөлийг бүрдүүлж байгаа юм. Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрт орон нутгийн төсвийн ил тод байдлыг тусгасан байдлын үнэлгээ нь эрх зүйн бусад баримт бичгийн үнэлгээнээс хамгийн өндөр буюу дунджаар 78 оноотой байгааг дурдах нь зүйтэй.

Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах асуудлыг Өмнөговь, Увс, Ховд аймаг болон Нийслэл Засаг даргын шийдвэрээр зохицуулсан байна. Өмнөговь аймгийн Засаг дарга 2013 оны 3 дугаар сарын 5-ны өдөр “Хуулийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай” 01 тоот албан даалгавар гаргаж, уг албан даалгаврын 3.5 дахь хэсэгт

6 эх сурвалж: http://www.khentii.gov.mn/main/index.php?option=com_content&view=article&id=199:2010-07-17-08-43-06&catid=90:2010-07-17-04-37-54&Itemid=172

7 эх сурвалж: <http://uvs.gov.mn/data/main/main1384312816.pdf>

“Төрийн байгууллага нээлттэй, иргэдийн ашиг сонирхолд нийцсэн үйл ажиллагаа явуулж байгаа эсэхэд хяналт тавьж, хамтран ажиллах, мэдээлэл харилцан солилцох, олон нийтэд мэдээллийг тогтмол хүргэж байх” гэж заасан байна. Дээрх албан даалгавар нь орон нутгийн цахим хуудас болон Засаг даргын Тамгын газар (ЗДТГ)-ын мэдээллийн самбарт тавигдаагүй байсан тул орон нутагт ажилласан судлаач хүсэлт тавьж шийдвэрлүүлсэн байна.

Увс аймгийн Засаг даргын 2013 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн А/96 тоот захирамжаар “Шилэн халаас” хөтөлбөрийг баталжээ. Уг хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2013 оны үйл ажиллагааны төлөвлөгөө гаргаж, аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтэс (СТСХ)-ийн даргаар батлуулан хөтөлбөрийн хэрэгжилтийн тайланг эхний 3 улирлын байдлаар нэгтгэн төсвийн мэргэжилтэн нь хариуцан тайлагнасан байна. “Шилэн халаас” хөтөлбөрийг бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн батлагдсан жилийн төсөв, түүний гүйцэтгэлийг олон нийтэд нээлттэй болгох, орон нутгийн төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад иргэд, олон нийтийн хяналт, оролцоог хангаж, төсөв, санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангах зорилгоор батлан хэрэгжүүлжээ. Түүнчлэн хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал тутам дүгнэж тайлагнадаг бөгөөд аймгийн Засаг дарга төсвийн захирагч нарт зөвлөмж гарган хүргүүлсэн дэвшилтэт сайн туршлага, санал санаачилга байгааг түгээн дэлгэрүүлэх нь чухал юм.

Ховд аймгийн Засаг дарга 2013 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр А/135 тоот “Төсвийн ил тод байдлыг хангах зарим арга хэмжээний тухай” захирамжаар “аймгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын www.khovdtusuv.wordpress.com цахим хуудас, номын санд байрлах санхүүгийн буланд санхүү, төсвийн мэдээ, мэдээллийг тогтмол оруулж иргэд, олон нийтэд мэдээлж ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг 9 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулсан байна. Мөн өдрийн А/136 тоот “Төсвийн ил тод, нээлттэй байдалд хяналт тавих тухай” захирамжаар “Санхүү, төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн орон тооны бус зөвлөлийг ИТХ, ЗДТГ, иргэний нийгмийн болон хувийн хэвшлийн байгууллагын төлөөллийг оролцуулан 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан ажиллуулжээ.”⁸

Нийслэлийн Засаг дарга “Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” А/606 тоот захирамжийг 2012 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр гаргаж, захирамжийн 1.3 дахь буюу “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр” гэсэн хэсгийн “а” заалтад “Байгууллагын өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудсанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх”; “г” заалтад “тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолдажлын 14 өдрийн дотор энэ тухай цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх” гэсэн заалтуудыг тусгасан байна. Жишээлбэл, нийслэлийн Засаг даргын 606 тоот захирамжаар баталсан “Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай” журмаар удирдах албан тушаалтнуудын гадаад

⁸ эх сурвалж: <http://www.khovd.gov.mn/home/#>

томилолтын зардлын тайланг нээлттэй мэдээлэхээр заасан хэдий ч төсвийн голлох бусад зардлуудыг мэдээлэх талаар орхигдуулсан буюу ерөнхийлсөн байна.

Төлөөлөн гүйцэтгэх болон үр дүнгийн гэрээ: Аймаг, нийслэлийн Засаг дарга салбарын Төсвийн ерөнхийлөн захирагч нартай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх гэрээ, мөн ЗДТГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээнд үндсэндээ төсвийн ил тод байдлыг хангах заалт ороогүй байгаа бөгөөд эдгээр гэрээ нь зөвхөн албан хэрэгцээнд ашиглагддаг тул орон нутгийн судлаачид тэр бүр олж үзэж чадаагүй юм. Харин Дорноговь аймгийн Засаг дарга аймгийн ЗДТГ-ын даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний 3.6.5-д “Төсвийн тухай хуульд заасны дагуу орон нутгийн тухайн оны төсөв, төсвийн төслийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлнэ” гэсэн заалт оржээ. Энэхүү гэрээг судлаач хүсэлт тавьсны үндсэн дээр олж авсан байна.

Дорноговь аймгийн ЗДТГ-ын дарга СТСХ-ийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний 2.3 дахь заалтад “Төсвийн ил тод байдлыг хангаж ажиллана; Аймгийн 2013 оны төсөв, 2014 оны төсвийн төслийг иргэд, олон нийтэд ил тод мэдээлнэ” гэсэн заалтыг оруулсан байна. Говьсүмбэр аймгийн ЗДТГ-ын дарга Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргатай хийсэн үр дүнгийн гэрээний 1.1.5-д “Төсвийн ил тод байдлыг хангах ажлыг зохион байгуулна” гэж заасан бол аймгийн Засаг дарга Хөдөлмөрийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээний “Төсвийн хөрөнгийн төлөвлөлт, зарцуулалтын ил тод байдлыг хангах” гэсэн зорилт 1-т “Засгийн газрын 2012 оны 1-р тогтоолын хэрэгжилтийг хангаж ажиллана; Мэдээллийн самбар болон цахим хуудсаар төсвийн талаарх мэдээллийг ил тод тавьж мэдээлнэ” гэж тусгасан сайн жишээнүүдийг дурдаж болно.

Нутгийн удирдлагын зүгээс гаргаж буй шийдвэр, баримт бичиг, гэрээнд орон нутгийн төсвийн ил тод байдлын асуудлыг хэрхэн тусгасныг нэгтгэн үнэлбэл дундаж оноо 39.0 байгаа нь аймаг, нийслэлийн түвшинд энэ тал дээр санаачилга багатай ажиллаж байгааг харуулж байна.

3.3. Төсвийн баримт бичгүүдийн ил тод байдал (аймаг, нийслэлийн нэгдсэн үнэлгээ)

3.3.1. Төсвийн төсөл

Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийн баримт бичгийн ил тод байдлыг дээд шатны төсвийн захирагчид хянуулсан төсвийн санал болон аймаг, нийслэлийн аудитор, ИТХ-д өргөн барьсан орон нутгийн төсвийн төслийг олон нийтэд ил тод, нээлттэй болгосон эсэхийг харгалзан үнэлсэн юм. Аймаг, нийслэл тус бүрийн үнэлгээг эдгээр үзүүлэлтээр нэгтгэн дундаж оноог гаргахад 15.3 байгаа нь орон нутгийн төсвийн төслийн баримт бичгийн ил тод байдал маш хангалтгүй байгааг харуулна.

Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийн баримт бичиг, түүний хэлэлцүүлгийн ил тод байдлыг үнэлэхдээ аймаг, нийслэлийн Засаг дарга ирэх оны төсвийн саналыг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн хянуулахдаа иргэд, олон нийтэд танилцуулж, саналыг нь авсан эсэх, орон нутгийн болон Монгол Улсын төсвийн ил тод байдлын цахим хуудсанд байрлуулан иргэд, байгууллагууд чөлөөтэй танилцах нөхцөлийг бүрдүүлсэн

эсэхийг харгалзан үзсэн болно⁹. Орон нутгийн төсвийн санал, төсвийн төслийг дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэхээс өмнө Архангай, Төв, Хөвсгөл аймгууд иргэдээс цахим хэлбэрээр санал авахаар хэлэлцүүлэг хийснээс бусад тохиолдолд энэ үйл явц иргэд, олон нийтэд ил тод болоогүй байна. Дархан-Уул аймаг зөвхөн 2013-2015 оны төсвийн төслийг цахим хуудсандаа тавьсан байлаа.

Орон нутгийн төсвийн ил тод байдлын үнэлгээ хийх энэхүү судалгааг гүйцэтгэх явцад аймаг, нийслэлийн Засаг дарга 2014 оны төсвийн төслөө аймаг, нийслэлийн ерөнхий аудиторт 11 дүгээр сарын 10-ны дотор өргөн барих үйл явц тун хангалтгүй байсныг орон нутгийн судлаачид мэдэгдэж байсныг тэмдэглэх нь зүйтэй. Хуулийн хугацаанд төсвийн төсөлдөө аудитын дүгнэлт гаргуулахаар хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгох үйл явц хэрэгжихгүй байгаа нь Говьсүмбэр аймгийн Засаг даргын ИТХ-даа өргөн барьсан төсвийн төсөл, Дархан-Уул аймгийн ерөнхий аудиторын тус аймгийн төсвийн төсөлд өгсөн аудитын гэрчилгээ 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр орон нутгийн цахим хуудсанд тавигдсан, Дорнод, Хөвсгөл аймгийн судлаачдаас төсвийн төслийг аймгийн төрийн аудитын газарт өргөн барьсныг нотлох мэдээлэл цаасаар ирснээр батлагдаж байгаа юм.

Харин аймаг, нийслэлийн төсвийн төслийг боловсруулах явцдаа Дархан-Уул, Өвөрхангай аймгийн Засаг дарга нар олон нийтэд хугацаа хоцорч танилцуулсан бол Булган, Хөвсгөл аймгууд ИТХ-д төсвийн төслөө өргөн мэдүүлэхдээ иргэдээс санал авсан тухай танилцуулсан баримт орон нутгийн судлаачдаас бичгээр ирсэн байна. Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон аймгийн Засаг дарга нар аймгийнхаа 2014 оны төсвийн төслийг ИТХ-д 2013 оны 11 дүгээр сарын 25-ны өдөр өргөн барихдаа нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ил тод болгож, олон нийтэд танилцуулсан байна. Булган, Төв аймгийн ерөнхий аудитор ирэх оны төсвийн төслийн талаарх дүгнэлтийг ИТХ-д хуулийн хугацаанд хүргүүлэхдээ ил тод болгосон байсан нь сайшаалтай.


Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийн баримт бичиг, түүний хэлэлцүүлгийн ил тод байдлын үнэлгээг нэгтгэж, дунджаар авч үзвэл авбал зохих 100 онооноос зөвхөн 15.3 оноо авч байгаа нь орон нутгийн төсвийн санал, төсвийн төслийг боловсруулах, хянах үйл явцад ил тод, нээлттэй байдал хангагдахгүй байгааг харуулж байна. Энэ нь орон нутгийн удирдах ажилтан, холбогдох мэргэжилтнүүд хууль, тогтоомжийн эдгээр заалт, шаардлагыг ойлгож, хэрэгжүүлэхэд анхаарч ажиллахгүй байгаатай холбоотой.

3.3.2. ИТХ-ын хуралдаан

Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийг хэлэлцэн батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдлыг дараах үзүүлэлтүүдээр үнэлж, үнэлгээг нэгтгэн гаргав (График 5, 6).

⁹ Аймаг, нийслэлийн төсвийн баримт бичгийн ил тод байдлын үнэлгээний нэгтгэлийн дэлгэрэнгүйг Хавсралт 7-оос үзнэ үү.


График 5. Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийг хэлэлцэж, батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал (аймаг, нийслэлийн нэгтгэсэн оноогоор)



Орон нутгийн төсвийн төслийг хэлэлцэн батлах ИТХ-ын хуралдаанд Дундговь, Өвөрхангай, Сүхбаатар, Төв аймгийн иргэд, иргэний нийгэм, төрийн бус байгууллагын төлөөлөл оролцсон бөгөөд аймаг, нийслэлийн үнэлгээг нэгтгэн үзвэл дунджаар 45.7 оноотой байна. Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслийг оролцуулан төсвийг хэлэлцэн батлах хуралдааныг сурвалжлуулах боломжийг Архангай, Дорноговь, Дундговь, Завхан, Орхон, Өвөрхангай, Сүхбаатар, Төв, Хөвсгөл аймаг, нийслэл Улаанбаатар хотын ИТХ-аас олгосон нь төсвийг хэлэлцэн батлах үйл явцын нээлттэй байдлыг хангахад нөлөөлж энэ үзүүлэлтийн үнэлгээ нэлээд өндөр буюу 68.0 оноотой гарсан байна. Дорноговь, Орхон, Өвөрхангай, Төв, Хөвсгөл аймаг болон нийслэлийн төсвийг хэлэлцсэн ИТХ-ын хуралдааныг радио, телевизээр шууд дамжуулсан талаарх баримтыг орон нутгийн судлаачид ирүүлжээ.

Аймаг, нийслэлийн төсвийг хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны талаарх баримт бичгийн ил тод байдлыг үнэлэхэд дараах үр дүн гарсан болно.

График 6. Аймаг, нийслэлийн төсвийг хэлэлцэж, баталсан хуралдааны баримт бичгийн ил тод байдал



Орон нутгийн төсвийг хэлэлцэн баталсан ИТХ-ын хуралдааны тогтоол, шийдвэр (62.0 оноо) хугацаа хоцорсон ч гэсэн ямар нэгэн хэлбэрээр олон нийтэд ил тод болдог бол хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, тэмдэглэл, илтгэл танилцуулга албан хэрэгцээний зориулалтаар л тараагддаг байна. Эдгээр баримт бичгийг нээлттэй эх сурвалжаас иргэн бүр олж үзэх боломж хомс байдаг нь үнэлгээний явцад харагдсан болно.

Төсөв хэлэлцэн батлах ИТХ-ын хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө (41.4 оноо)-г Өмнөговь, Сүхбаатар, Увс аймгууд, Улаанбаатар хот; мөн хуралдаанд хэлэлцүүлсэн илтгэл, танилцуулга (30.2 оноо)-ыг Сүхбаатар, Хөвсгөл аймгууд; хурлын тогтоол, шийдвэрийг Булган, Говьсүмбэр, Хөвсгөл, Хэнтий аймгууд цахим хуудсандаа хуулийн хугацаанд байршуулсан байлаа. Харин хуралдааны тэмдэглэл буюу протокол (20.7 оноо)-ыг Дорноговь, Сүхбаатар, Төв, Хөвсгөл аймагт ажилласан судлаачид холбогдох албан тушаалтанд хүсэлт гаргасны үндсэн дээр гаргуулж авсан байна.

3.3.3. Батлагдсан төсөв

Аймаг, нийслэлийн 2014 оны батлагдсан төсвийн ил тод байдлын үнэлгээг нэгтгэн гаргавал 48.8 оноотой гарчээ. Үүнд аймаг, нийслэлийн түвшинд орон нутгийн төсвөө батлагдсанаас хойш 7 хоногийн дотор олон нийтэд мэдээлсэн байх шаардлага 67.5 оноотой, дараа оны 1 дүгээр сарын 10-ны дотор цахим хуудсанд байрлуулан иргэд, байгууллага чөлөөтэй танилцаж мэдээлэл авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал 66.1 оноотой үнэлэгдсэн хэдий ч аймаг, нийслэлийн Засаг дарга 2014 оны сар, улирлын хуваариа батлан Сангийн яаманд хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгож танилцуулахгүй байгаагаас энэ үзүүлэлт 17.3 оноо буюу маш бага үнэлгээтэй гарсан нь нөлөөлсөн гэж үзэх үндэстэй.

Орон нутгийн 2014 оны батлагдсан төсвийг хүчин төгөлдөр болсны дараа 7 хоногийн дотор олон нийтэд ил тод болгож мэдээлэх ажлыг Булган, Дархан-Уул, Өмнөговь, Увс, Хөвсгөл аймгууд хуулийн дагуу гүйцэтгэсэн бол Баянхонгор, Дорнод аймаг огт хийгээгүй байна. Харин Архангай, Завхан аймаг товч мэдээлсэн, Дундговь, Орхон аймгууд хүсэлт шаардлага тавьсны үндсэн дээр ил тод болгож, бусад аймгууд хуулинд заасан хугацаанаас хоцорсон ч олон нийтэд ил тод мэдээлжээ.

Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хуулинд заасны дагуу аймаг, нийслэлийн батлагдсан төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор холбогдох цахим хуудсанд байрлуулсан байх шаардлагыг Баян-Өлгий, Булган, Говьсүмбэр, Дархан-Уул, Өвөрхангай, Өмнөговь, Сэлэнгэ, Увс, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгууд, Улаанбаатар хот бүрэн хангаж чаджээ. Харин Говь-Алтай, Завхан аймгууд хугацаа хоцорсон ч батлагдсан төсвөө цахим хуудсаар ил тод болгосон бол бусад аймгууд хуулийн энэ заалтыг ханган ажиллаагүй байна.

Батлагдсан төсвийг 7 хоногийн дотор ил тод мэдээлсэн байдал 67.5 оноотой, 1 дүгээр сарын 10-ны дотор цахим хуудсанд байрлуулан иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал 66.1 оноотой байгаа нь аймаг, нийслэлийн түвшинд батлагдсан төсвийг олон нийтэд ил тод болгох ажил төсвийн бусад баримт бичгээс илүү үнэлэгдсэн байгааг харуулна.

Батлагдсан төсвийн ил тод байдлыг үнэлэх өөр нэг үзүүлэлт нь аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн сар, улирлын хуваарийг 12 дугаар сарын 25-ны дотор баталж, мөн сарын 31-ний

дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ ил тод болгож танилцуулсан эсэхийн үнэлгээ юм. Өмнөговь аймгийн хувьд батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийг хугацаанд нь бүрэн ил тод болгосон бол Говь-Алтай аймгийн төсвийн сар, улирлын хуваарь хугацаа хоцорсон ч ил тод мэдээлэгдсэн байна. Говьсүмбэр, Ховд аймгуудын холбогдох албан тушаалтанд орон нутагт ажилласан судлаач хүсэлт шаардлага тавьж төсвийн сар, улирлын хуваарийг олж үзжээ. Баян-Өлгий, Дорноговь, Увс, Хөвсгөл аймгуудын төсвийн хуваарийн талаар ямар нэгэн товч мэдээлэл олдож байсан боловч бусад аймаг, нийслэлийн хувьд төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийг ил тод мэдээлсэн тухай баримт олдоогүй болно. Аймаг, нийслэлийн төсвийн сар, улирлын хуваарийн талаарх мэдээлэл нээлттэй биш байгаа нь энэ үзүүлэлтийн үнэлгээ 17.3 оноотой гарснаар батлагдана.

3.3.4. Иргэний төсөв

Зөвхөн Говьсүмбэр аймгийн Иргэний танхимд батлагдсан төсвийн талаар хийсэн илтгэл танилцуулгыг эс тооцвол бүх аймаг, нийслэл иргэдэд зориулан хялбаршуулан бэлтгэсэн “иргэний төсөв”-ийг огт гаргадаггүй хэвээр байна. Цаашид “Шилэн данс”-ны хуулийг батлан гаргахдаа орон нутаг болон төсвийн байгууллагуудын зүгээс иргэний төсвийг бэлтгэх нөхцөл, хэлбэрийг нарийвчлан тодорхойлох шаардлагатай нь энэхүү судалгааны явцад харагдлаа.

3.3.5. Төсвийн тодотгол

2013 оны төсөвт Завхан аймгаас бусад бүх аймаг, нийслэл тодотгол хийсэн байна. Төсвийн тодотголын төслийг ИТХ-даа өргөн мэдүүлэхдээ Дархан-Уул, Сүхбаатар аймаг олон нийтэд ил тод мэдээлсэн бол төсвийн тодотгол хэлэлцсэн ИТХ-ын худалдааныг Дорноговь, Өмнөговь, Төв, Хөвсгөл аймгууд нээлттэй буюу орон нутгийн телевизээр шууд дамжуулжээ. Ялангуяа Хөвсгөл аймгийн ИТХ-аас тус хуралдааны илтгэл, танилцуулгыг бүрэн ил тод болгожээ. Орон нутгийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, тодотгосон төсвийн тухай нийслэл хот болон Говьсүмбэр, Дархан-Уул, Орхон, Өмнөговь аймгууд ажлын 14 өдрийн дотор цахим хуудас, мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байршуулан мэдээлсэн байна. Харин Говь-Алтай, Увс, Ховд аймгууд хугацаа хоцорсон ч энэ талаар олон нийтэд мэдээлж танилцуулжээ. Төсвийн тодотголын ил тод байдлыг аймаг, нийслэлийн дунджаар авч үзвэл 41.5 оноотой үнэлэгдсэн байна.

3.3.6. Хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагаа

Орон нутгийн 2013 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдалд тавигдаж буй шаардлагын тавин хувь (50.9 оноо)-ийг л хангаж байна. Үүнийг аймаг, нийслэлийн 2013 оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан (44.5 оноо), 2014 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө (63.5 оноо), 2013 оны худалдан авалтын санхүүжилтийн тайлан (55.9 оноо) болон явц, үр дүнгийн сарын мэдээ (41.8 оноо), үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хөндлөнгийн төлөөллийг оролцуулсан байдал (48.4 оноо) ил тод, нээлттэй бус байгаатай холбоотой гэж үзэж байна.

Аймаг, нийслэлийн 2013 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн жилийн тайланг 2014 оны 1 дүгээр сарын 15-ны дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ Орхон, Өмнөговь, Төв, Увс, Баян-Өлгий, Сүхбаатар аймгуудын Засаг дарга цахим хуудас болон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд танилцуулж ил тод болгосон байна.

Ихэнх аймаг, нийслэл хот худалдан авах ажиллагааны жилийн тайлангаа нээлттэй мэдээлээгүй байгаа нь энэ үзүүлэлтийн үнэлгээ 44.5 оноотой үнэлэгдэхэд нөлөөлсөн юм.

Худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг Баянхонгор, Говьсүмбэр, Дорноговь, Дундговь, Сэлэнгэ, Увс, Хөвсгөл, Хэнтий аймгууд, Улаанбаатар хот аймаг, нийслэлийн төсөв батлагдсанаас хойш 1 сарын дотор буюу 2014 оны 1 дүгээр сарын 5-ны дотор худалдан авах ажиллагааны цахим хуудас болон орон нутгийнхаа цахим хуудсанд нийтэлж, зарлан мэдээлсэн байна. Дорнод, Өмнөговь, Сүхбаатар аймгуудаас бусад аймгийн хувьд хугацаа хоцорсон ч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг бүрэн болон хэсэгчилсэн байдлаар мэдээлсэн тул энэ үзүүлэлтийн дундаж үнэлгээ 63.6 оноотой гарчээ.

2013 оны худалдан авалтын явц, үр дүнгийн ил тод байдлаар Архангай, Дорноговь, Увс, Орхон аймаг, нийслэл хот 90-100 оноотой тэргүүлж, тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаар мэдээллийн самбартаа шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэж, санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж чаддагаа харуулав. Өмнөговь, Төв, Ховд, Хөвсгөл аймгууд хугацаа хоцорч энэ талаарх мэдээллийг олон нийтэд түгээдэг гэсэн баримтыг орон нутгийн судлаачид ирүүлсэн байна.

Аймгуудын Засаг дарга нар өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх сар бүрийн тайланг дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал хангалтгүй байгаа нь энэ үзүүлэлтийн үнэлгээ 41.8 оноотой байгаагаас харагдаж байна. Харин нийслэлийн хувьд энэ үзүүлэлт маш сайн байгаа юм.

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2013 онд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд хоёроос доошгүй хөндлөнгийн төлөөллийг оролцуулсан байдлын үнэлгээ нь авбал зохих нийт онооны 50 хувьд ч хүрэхгүй (48.4 оноо) байна. Энэ нь нэг талаас, орон нутагт үнэлгээний хороонд ажиллах тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллага, тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилох АЗ сертификаттай мэргэшсэн иргэн цөөн байгаатай холбоотой. Нөгөө талаас, үнэлгээний хороонд эдгээр төлөөллөөс оролцуулан баталсан шийдвэр ил тод биш байгаа нь нөлөөлж болох талтай. Нийслэл Улаанбаатар хотод үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухай бүр өөр өөр хүнийг сонгож, түүнийгээ шууд ил тод танилцуулан ажиллуулдаг бол Хөвсгөл зэрэг аймагт нэг хүнийг хэд хэдэн үнэлгээний хороонд зэрэг ажиллуулаад сонгон шалгаруулалт дууссаны дараа нийтэд зарлажээ. Булган, Говьсүмбэр, Дундговь, Завхан, Ховд зэрэг аймгууд хуулинд тусгагдсан дээрх төлөөллийг оролцуулан үнэлгээний хороог байгуулан ажиллуулдаг нь үнэлгээний хороо байгуулсан шийдвэр, ажилласан цагийн бүртгэл зэрэг баримтаар нотлогдож байгаа юм.

3.3.7. Төсвийн гүйцэтгэл

Аймаг, нийслэлийн 2012, 2013 оны төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлыг 2013 оны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ, хагас жилийн тайлан, 2012 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан, энэхүү тайланд аудит хийсэн тайлангийн ил тод байдлыг аймаг, нийслэлийн дунджаар авч үзвэл 55.6 оноогоор үнэлэгдсэн байна. Энэ нь төсвийн баримт бичгүүд дотроос ил тод байдлаараа хамгийн өндөр оноо авсан үзүүлэлт боллоо.

Орон нутгийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг Дархан-Уул, Дорнод аймаг, нийслэл хотын ЗДТГ-ын СТСХ-ээс сар бүрийн 6-ны дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ цахим хуудсандаа иж бүрэн мэдээлж хэвшсэн нь сайшаалтай. Харин Булган, Говьсүмбэр, Өмнөговь, Увс, Ховд, Хэнтий аймгууд хугацаа хоцроож, эсвэл тогтмол бус ч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг орон нутгийн хэмжээнд нэгтгэн, мөн байгууллага бүрээр гаргадаг байна. Бусад аймгийн хувьд төсвийн гүйцэтгэлийн талаар сар бүр ямар нэгэн байдлаар олон нийтэд мэдээлдэг тул энэ үзүүлэлтийн үнэлгээ 52.3 оноотой гарчээ.

2013 оны хагас жилийн Төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг Дундговь, Өмнөговь аймаг, Улаанбаатар хот цаг хугацаанд нь буюу 8 дугаар сарын 15-ны дотор гаргаж Сангийн яаманд хүргүүлэхдээ цахим хуудсандаа байрлуулж ил тод болгосон байна. Орхон, Төв, Ховд, Хөвсгөл аймгуудын хувьд орон нутгийн төсвийн хагас жилийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг хугацаа нь тодорхойгүй ч цахим хуудас, мэдээллийн самбартаа нээлттэй болгосон юм.

Харин 2012 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлангийн ил тод байдал нь төсвийн гүйцэтгэлийн ил тод байдлыг илтгэх бусад үзүүлэлтээс харьцангуй дээгүүр (67.3 оноотой) үнэлэгдсэн байна. Булган, Говь-Алтай, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймгууд 2012 оны төсвийн гүйцэтгэлийг 2013 оны 4 дүгээр сарын 1-ний дотор аймгийнхаа цахим хуудсанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлж чаджээ. Дорноговь, Орхон, Төв, Увс, Ховд аймаг болон нийслэл өмнөх оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг хугацаа хоцорсон ч нийтэд ил тод болгосон байна. Баян-Өлгий, Баянхонгор, Завхан, Сэлэнгэ аймгуудын цахим хуудас болон мэдээллийн самбарт энэ төрлийн мэдээллийг гаргасан гэх баримт нотолгоо байхгүй байгаа юм.

Өмнөх оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аймаг, нийслэлийн төрийн аудитын газраас аудит хийсэн тайлангийн ил тод байдал судалгааны хүрээнд үнэлэгдсэн төсвийн баримт бичгүүдээс хамгийн өндөр буюу 68.6 оноотой байна. Булган, Дорнод, Дундговь, Өмнөговь, Хөвсгөл, Хэнтий аймаг, нийслэлийн хувьд энэхүү тайланг хугацаанд нь олон нийтэд ил тод мэдээлсэн байна. Дөрвөн аймгаас бусад аймаг хугацаа хоцроосон ч ямар нэгэн байдлаар аудитлагдсан санхүүгийн тайлан болон аудитын гэрчилгээг нээлттэй болгожээ.

3.3.8. Орон нутгийн хөгжлийн сан

ОНХС-гийн ил тод байдал аймаг, нийслэлийн нэгдсэн үнэлгээгээр 38.5 оноотой гарсан нь Төсвийн тухай шинэ хуулийн орон нутгийн түвшинд хамаарах чухал асуудал төдийлөн хангалттай биш байгааг харуулж байгаа юм.

Аймаг, нийслэлийн түвшинд авч үзвэл, дараагийн онд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний урьдчилсан жагсаалтыг Говьсүмбэр аймаг орон нутгийн цахим хуудасныхаа сайн засаглал булангийн “ил тод байдал” цэсийн “төсөв, санхүү” хэсэгт 2013 оны 3 дугаар сард жагсаалтыг тавьж, иргэдээс санал авч урьдчилсан жагсаалтыг гаргасан байна. Тус аймгийн Засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд, олон нийтэд танилцуулан хэлэлцүүлсэн нь орон нутгийн

судлаачийн ирүүлсэн фото зургуудаар нотлогдсон болно. Хөвсгөл аймаг 12 дугаар сар хүртэл олон нийтийн дунд энэ чиглэлээр үр дүнтэй хэлэлцүүлэг хийгээгүй байсан ч аймгийн ИТХ иргэний нийгмийн байгууллагуудын зөвлөлтэй хамтран 2012 оны 12 дугаар сарын 1-2-ны өдрүүдэд теле болон иргэдийн хэлэлцүүлгийг зохион байгуулжээ. Архангай, Дорноговь, Увс, Ховд, Хэнтий аймгууд аймгийн төвийнхээ иргэдийн дунд 11, 12 дугаар саруудад хэлэлцүүлэг зохион байгуулсан тухай мэдээллийг орон нутгийн судлаачид мөн ирүүлсэн болно. Аймаг, нийслэлийн Засаг дарга нар ИТХ-даа төсвийн төслийг өргөн барихдаа дээр дурдсан жагсаалтыг иргэд, олон нийтэд танилцуулах үйл явц хангалттай ил тод болоогүй байна.

Түүнчлэн ОНХС-гийн хөрөнгөөр 2014 онд санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар иргэдээс санал авсан болон түүнийг шийдвэрлэсэн үйл явц (38.9 оноотой), мөн сум, дүүргийн Засаг дарга баг, хорооны Иргэдийн нийтийн хурлаас баталгаажсан хөтөлбөр, төсөл, арга хэмжээ нь сум, дүүргийн төсвөөр бие даан хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүйгээс саналын жагсаалтыг тусд нь бэлтгэж аймаг, нийслэлийн Засаг даргад хүргүүлэх үедээ ил тод болгосон байдал (22.7 оноотой) нь Сүхбаатар, Хөвсгөлөөс бусад аймагт хангалтгүй байгаа нь харагдлаа.

Энэ нь ОНХС-гийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээний талаар шийдвэр гаргах үйл явцад иргэдийг оролцуулах эхний алхмууд хийгдэж байгаа хэдий ч санал авах, хэлэлцүүлэг хийх үйл явцад оролцоогүй иргэдэд энэ талаарх мэдээлэл нээлттэй биш байгааг харуулж байна гэж үзэж байгаа болно.

3.3.9. Засаг даргын нөөц хөрөнгө

Засаг даргын нөөц хөрөнгийн зарцуулалт, эх үүсвэрийн үлдэгдлийн талаарх 2013 оны мэдээллийг Засаг даргын зөвлөлийн хуралд улирал бүр танилцуулахдаа олон нийтэд ил тод болгосон байх хуулийн заалтыг аймаг, нийслэлийн түвшинд ерөнхийд нь авч үзвэл хэрэгжиж чадахгүй байна (30.2 оноо авсан байна). Говьсүмбэр аймагт ажилласан судлаач тус аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 1, 2, 3-р улирлын тооцоог аймгийн ЗДТГ-ын мэдээллийн самбар болон Нэг цэгийн үйлчилгээнээс авсан байна. Булган, Дорнод, Орхон, Өмнөговь, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн хувьд орон нутгийн судлаачид холбогдох албан тушаалтнуудад хүсэлт тавьж энэ талаарх товч мэдээллийг олж авсан байна.

3.3.10. Орон нутгийн тусгай сангууд

Аймаг, нийслэлийн түвшинд Аймаг хөгжүүлэх сан, Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Замын сан, Халамжийн сан зэрэг тусгай сангуудын зарцуулалт, эх үүсвэрийн талаарх мэдээллийн ил тод байдлыг судалж үзэхэд Дорноговь аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн блогт орон нутгийн тусгай сангуудын талаарх мэдээллийг нээлттэй тавьсан байв. Говьсүмбэр аймаг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан, Сум хөгжүүлэх сан, Авто замын сангийн талаарх мэдээллийг аймгийн цахим хуудас, мэдээллийн самбар, орон нутгийн сонинд нийтэлж иргэд, олон нийтэд танилцуулсан бол Архангай аймаг Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх чиглэлээр зээл олгосон төслийн жагсаалтыг нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлд байрлуулжээ. Хэнтий аймгийн нутгийн удирдлагын зүгээс тусгай сангуудад шалгалт хийж зөвлөмжийг аймгийнхаа цахим хуудсанд тавьсан байв. Бусад аймгийн хувьд тусгай сангуудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг олон нийтэд ил тод болгоогүй байгаа учир энэ үзүүлэлт 43.4 оноогоор үнэлэгдсэн юм.

3.3.11. Хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалт

Төсвийн тухай хуулиар “аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч буюу Засаг дарга хандив тусламжаар хүлээн авсан хөрөнгө, түүний зарцуулалтын талаар олон нийтэд мэдээлэх” шаардлагыг тодорхойлсон билээ. Гэтэл хандив, тусламжийн хөрөнгийн зарцуулалтын ил тод байдал маш хангалтгүй байна. Тухайлбал, 2013 онд 90 жилийн ойгоо тэмдэглэсэн Архангай, Хэнтийгээс бусад аймаг, нийслэл хот хандив, тусламжаар авсан хөрөнгө, түүний зарцуулалтыг иргэд, олон нийтэд ил тод болгоогүй байна. Харин Төв аймгийн 90 жилийн ойд зориулан хандив өгсөн иргэн, ААН-ийн жагсаалтыг 2013 оны 5 дугаар сард гаргасныг тус аймгийн Иргэний танхимын мэдээллийн самбараас хувилуулж авсан баримтаас орон нутгийн судлаач ирүүлжээ. Хандив тусламжийн ил тод байдал хамгийн доогуур буюу 16.8 оноотой байна.

4 Дүгнэлт, Бодлогын зөвлөмж

Аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлыг 2013 оны байдлаар үнэлж дүгнэхэд, Төсвийн тухай хууль, Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн Монгол Улсын Засгийн газар, Сангийн сайдын шийдвэрээр батлагдсан холбогдох журмууд иж бүрэн хэрэгжиж эхэлсэн эхний жилд орон нутгийн түвшинд төсвийн ил тод байдал хангагдаж чадахгүй байгаа нь харагдлаа. Энэ нь нэг талаас, орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангаж буй эсэхэд хяналт тавих чиг үүргийг ямар этгээд гүйцэтгэх нь тодорхойгүй, төсвийн үйл явцын болон баримт бичгийн ил тод байдлыг хангаагүй тохиолдолд хариуцлага хүлээлгэх зохицуулалт хууль тогтоомжид тодорхой тусгагдаагүйтэй холбоотой гэж үзэж байна. Нөгөө талаас, үйлчилж буй хууль тогтоомж, журам зааврыг холбогдох албан тушаалтнууд үзэж судлаагүй, энэ чиглэлээр олон улсын болон дотоодын төрийн бус байгууллагуудаас хийсэн судалгаа, боловсруулсан загвар, стандартыг хэрэгжүүлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа бараг хийгдээгүй нь нөлөөлсөн байж болох юм. Түүнчлэн аймаг, нийслэлийн төсвийн ил тод байдлыг үнэлэхэд ашиглах баримт нотолгоо, судалгааны мэдээллийг цуглуулах үүрэгтэй ажилласан орон нутгийн судлаачдын төсвийн талаарх мэдлэг, харилцааны ур чадвар, идэвх, санаачилга ч нөлөөлсөн байх талтай.

2011 онд хийсэн судалгааны үр дүнтэй харьцуулахад орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага болох ИТХ, түүний төсвийг хэлэлцэн батлах хуралдаан, батлагдсан төсвийг ил тод болгох үйл ажиллагаа тогтмолжих шинжтэй байна. Мөн худалдан авах ажиллагаа, төсвийн гүйцэтгэлийн баримт бичгүүдийг илүү ил тод нийтэлдэг болж байна. Зарим аймаг, орон нутаг төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг огт ил тод мэдээлэхгүй байгаа хэдий ч дундаж үзүүлэлтээр эдгээр баримт бичгийг нээлттэй болгох нь харьцангуй тогтмолжсон харагдаж байна. Орон нутгийн судлаачдын цуглуулсан мэдээлэл, баримт нотолгоонд тулгуурлан үнэлгээний багийн хараат бус гаргасан үнэлгээнээс харахад орон нутгийн төсвийн ил тод байдал хангалтгүй байна.

Орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгааны үр дүнд тулгуурлан дараах бодлогын зөвлөмжийг гаргаж байна. Үүнд:

1. *Орон нутгийн төсвийн ил тод байдлын талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах.* Төсвийн ил тод байдлын эрх зүйн зохицуулалт 2013 оноос эхлэн хангалттай түвшинд бүрдсэн бөгөөд одоогоор хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудыг өөрчлөх шаардлага ажиглагдсангүй. Харин эдгээр хууль, тогтоомжийг илүү үр дүнтэй хэрэгжүүлэх, хяналт тавих, хариуцлага хүлээлгэх үйл ажиллагааг боловсронгуй болгох шаардлага нэн тэргүүнд тулгарч байгаа юм.

Орон нутгийн түвшинд төсвийн мэдээллийг бодит утгаар нь ил тод болгохгүй байх тохиолдол цөөнгүй байна. Тухайлбал, зарим аймаг төсвийн баримт бичгийг ил тод болгохгүйгээр, зөвхөн тухайн баримт бичгийг өргөн барих үйл явцыг олон нийтэд товч мэдээлээд орхиж байгаа нь холбогдох албан тушаалтан төсвийн мэдээллийг ил тод болгох хууль, тогтоомжийг бүрэн ойлгоогүй, эсвэл тухайн баримт бичгийг нийтэд ил болгох сонирхолгүй байгаатай холбоотой гэж үзэж байна. Иймд төсвийн ил тод байдлын холбогдох хууль, тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, холбогдох албан тушаалтнуудын төсвийн хууль, эрхзүйн мэдлэгийг дээшлүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

2. *Орон нутгийн түвшний эрх зүйн баримт бичигт төсвийн ил тод байдлыг тодорхой тусган зохицуулах.* Аймаг, нийслэлийн ИТХ, Засаг даргын зүгээс төсвийн ил тод байдлыг хангах асуудлыг эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичигт тусгах, мөн тогтоол, журам, удирдамж, албан даалгавар гарган нутаг дэвсгэртээ хэрэгжүүлж байгаа нь судалгааны явцад харагдлаа. Энэ нь нутгийн өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэн санаачилгатай ажиллаж байгаагийн илрэл боловч тэдгээр эрх зүйн баримт бичиг агуулгын хувьд ихэнхдээ ерөнхий байна. Зарим баримт бичигт төсөв, худалдан авах ажиллагааны олон асуудлаас зөвхөн ганц нэгийг сонгож ил тод болгохоор тусгажээ. Энэ нь нутгийн удирдлагын байгууллагууд эрх зүйн баримт бичиг боловсруулж батлахдаа дээрээс гаргасан хууль тогтоомжид тусгагдсан нийтлэг зарчим, заалтуудыг давтах бус, орон нутгийнхаа онцлогт тохирсон тодорхой зохицуулалт, дүрэм журмыг бий болгоход түлхүү анхаарах шаардлагатайг харуулж байна.
3. *Орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах чиг үүргийг удирдлагын түвшин бүрээр зааглан тодорхой болгох.* Төсвийн ил тод, нээлттэй байдал аймаг, нийслэлийн түвшинд маш хангалтгүй байгаа нь орон нутгийн төсвийн ил тод байдлыг хангах чиг үүрэг тодорхой бус, орон нутгийн нэгжүүд тус тусдаа салангид байдлаар чиг үүргийг хэрэгжүүлж байгаатай холбоотой гэж үзэж байна. Иймээс орон нутгийн төсвийн ил тод байдлыг нэгдсэн байдлаар хангах үйл ажиллагааг сайжруулахын тулд төсвийн ил тод байдал, ялангуяа орон нутгийн төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдлыг хангах чиг үүргийг тодорхой болгох, жигд ажиллагааг хангах, нутагшуулахад анхаарлаа хандуулбал зохино.
4. *Орон нутгийн цахим хуудсан дахь төсвийн мэдээллийг нэгдсэн загварт оруулан мэдээллийг тогтмол байрлуулдаг болгох.* Төсвийн мэдээллийг ил тод, нээлттэй болгоход сонин, хэвлэл мэдээллийн хэрэгсэл, цахим хуудас зэрэг олон арга хэлбэрийг ашиглаж байгаа боловч тогтмол гаргадаг, жигдэрсэн арга хэрэгсэл байхгүй байна. Ялангуяа сүүлийн үед хурдтай хөгжиж буй цахим орчинд мэдээллийг ил тод болгох зайлшгүй шаардлага байгаа боловч аймаг, орон нутгийн цахим хуудас загварын хувьд харилцан адилгүй, мэдээлэл олоход хүндрэлтэй, эсвэл шаардлагатай мэдээллийг огт байршуулаагүй байна. Түүнчлэн мэдээлэл цахим хуудсанд биш албаны сэйф, шүүгээнд байгаа нь иргэд мэдээлэл олж авахад хүндрэл учруулж байна. Энэ чиглэлээр аймаг, орон нутгийн цахим хуудсыг нэгдсэн загварт оруулах, түүнчлэн ил тод байдал, эсвэл шилэн данс зэрэг дэд цэсийг зайлшгүй байрлуулах, тогтоосон хугацаанд томилогдсон

ажилтан тогтсон мэдээ, мэдээллийг тавьж байх үйл ажиллагааны дэгийг тогтоох хэрэгтэй байна.

5. *Аймаг, нийслэлийн албан ёсны цахим хуудсанд төсвийн олон жилийн мэдээллийг нэг дор төвлөрүүлэн оруулж, архивлах.* Судалгааны явцад орон нутгийн цахим хуудсанд орж үзэхэд төсвийн мэдээллийг нэг дор төвлөрүүлээгүйгээс иргэд мэдээллийг олоход хялбар биш байна. Иргэд төсвийн мэдээллийг түргэн шуурхай авах боломжийг бүрдүүлэхийн тулд орон нутгийн цахим хуудсанд төсвийн мэдээллийн санг бий болгон нэг дор төвлөрүүлэх нь зүйтэй гэж үзэж байна. Мөн ихэнх аймгууд цахим хуудсанд зөвхөн сүүлийн ганц хоёр жилийн төсвийн мэдээллийг л нийтэлсэн байна. Энэ нь иргэд төсвийн олон жилийн мэдээллийг хялбар олж авах боломж хангалтгүй байгааг харуулж байна. Иймд орон нутгийн цахим хуудсанд дахь төсвийн мэдээллийн санд төсвийн олон жилийн мэдээллийг нэг дор төвлөрүүлэн оруулж, архивлах нь чухал юм.
6. *Орон нутгийн төсвийн цахим хуудасны нэгдсэн загвар боловсруулах.* Аймгуудын албан ёсны цахим хуудас нь төсвийн цар хэмжээ, үйл явдлын хурдац асар их нэмэгдсэн өнөө цагт бүх мэдээллийг багтааж үргэлж шинэчилж, бас өмнөхийг хадгалж байх боломжийг олгох хамгийн хүртээмжтэй орон зай болжээ. Хоёр жилийн өмнө явуулсан анхны судалгаанаас хойш гарсан хамгийн чухал өөрчлөлт бол ихэнх аймаг албан ёсны цахим хуудсандаа тусгай булан нээж орон нутгийн төсөв, худалдан авах ажиллагааны мэдээллийг байршуулдаг болсон явдал юм. Зарим аймаг бие даасан цахим хуудас ажиллуулж эхэлсэн байна. Гэхдээ орон нутаг бүрийн идэвх санаачилга, боломж, тэнд байгаа мэдээллийн технологийн мэргэжилтний чадавхиас шалтгаалан ийм булан, хуудсууд өөр өөр загвартай, боловсронгуй биш, техникийн хувьд саатал ихтэй байв. Үүнийг харгалзан орон нутгийн төсвийн мэдээллийн булан, эсвэл тусдаа цахим хуудасны загварыг нэгдсэн журмаар гаргаж ажиллуулах заавар, тэнд байршуулах мэдээллийн агуулга, хэлбэрийг хууль тогтоомжид нийцүүлэн тодорхойлж өгөх нь зүйтэй.
7. *Төсвийн ил тод байдлыг оны эхнээс тасралтгүй хэрэгжүүлэх.* Өмнөх судалгааг хийснээс хойш орон нутгийн төсвийн ил тод байдалд дорвитой өөрчлөлт гараагүй нь орон нутгийн төсвийн төслийг батлагдахаас өмнө, гэхдээ бүр төсвийн санал, төлөвлөгөөг боловсруулахаас эхлэн иргэдэд нээлттэй болгож, тэдний зүгээс санал өгөх, шүүмжлэх зэргээр оролцох боломжийг хангаж чадахгүй хэвээр байгаатай холбоотой юм. Өнгөрсөн хугацаанд ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний талаар иргэдээс санал авах хууль, журмын заалтууд хэрэгжиж эхэлжээ. Гэвч 2013 оны тухайд нэгэнт батлагдсан тухайн оны ОНХС-гийн хөрөнгийг хэрхэн зарцуулахыг хэлэлцсэн бол 2014 оны ОНХС-гийн төлөвлөгөө, төслийн талаар хууль, журамд заасны дагуу эхлээд иргэддээ мэдээлэл хүргэж, ирсэн саналд тулгуурлан эрэмбэлсэн жагсаалт гаргах дараалал алдагдсан, цаг хугацаа ихээхэн хоцорч хэрэгжсэн болно. Нөгөө талаар, ОНХС нь улсын төдийгүй орон нутгийн төсвийн харьцангуй бага хэсэг тул нийт төсвийн ил тод байдлыг ОНХС-гийн ил тод байдлаар орлуулж орхигдуулах нь буруу юм. Ийм учраас орон нутгийн төсвийн төслийн ил тод байдлыг ИТХ-ын хуралдааны хугацаа ойртсон 10, 11 дүгээр сараас биш “Орон нутгийн төсвийн

төсөл боловсруулах журам” болон бусад хууль, журамд заасныг баримтлан нэгдүгээр улирлаас эхлэн хэрэгжүүлэх нь зүйтэй юм. Ингэхдээ нийт төсвийн хэмжээнд авч үзэх шаардлагатай байна.

8. *Орон нутгийн төсвийн ил тод байдлыг нэг загварт оруулах.* Нутгийн удирдлагын байгууллагууд төсвийн мэдээллийг нутгийн иргэд, оршин суугчиддаа хүргэхийн тулд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль” (2011), “Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам” (2012), “Мэдээллийн ил тод байдлыг хангах нийтлэг журам” (2013), зарим тохиолдолд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газраас боловсруулсан “Нийтийн зар мэдээний үлгэрчилсэн журам” (2013) зэрэг баримт бичгийн заалтуудыг дагаж мөрдөж байгаа боловч тэдгээр нь ихэнх тохиолдолд ерөнхий, эсвэл хэт техникийн шинжтэй учраас ягштал хэрэгжүүлэхэд түвэгтэй тал ажиглагдлаа. Үүнээс болж албан тушаалтнууд төсөвтэй холбоотой л бол ямар ч хамаагүй мэдээллийг цахим хуудас, мэдээллийн самбар зэрэгт байршуулж оромдох, төсвийн бодит мэдээллийг ерөнхий яриа, уриа лоозонгоор орлуулах хандлагатай байна. Ийм учраас урьд гарсан хууль тогтоомжийн заалтуудыг нэгбүрчлэн нягталж хооронд нь уялдуулах, янз бүрийн ойлголтыг нэг мөр тайлбарлах, шалгуур үзүүлэлтийг нарийвчлах замаар орон нутгийн төсвийг нээлттэй болгож, түүнд иргэдийн оролцоог хангах эрх зүйн иж бүрэн тогтолцоо болон зохион байгуулалтыг бүрдүүлэх цаг болжээ. Ингэхдээ иргэний нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагааны дүнд боловсруулсан “Орон нутгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын загвар стандарт” зэрэг баримт бичиг, бусад санаачилгад тулгуурлах боломжтой гэж үзэж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн зүгээс санаачилж, үзэл баримтлал, хуулийн төслүүд нь боловсруулагдаж буй “Шилэн төсөв”, “Шилэн тэндер”-ийг ийм зарчмаар авч үзэх нь зүйтэй.
9. *Орон нутгийн төсвийн ил тод байдлын загвар стандартыг батлан мөрдүүлж хэрэгжүүлэх.* Өмнөх судалгааны дүнд үндэслэн Засгийн газар, хяналтын байгууллагууд орон нутгийн төсвийн үйл явцыг боловсронгуй болгох, мэдээ, мэдээллийн агуулгыг тодорхойлж нэг стандарт загвар гаргах, цаг хугацааг тогтоохыг зөвлөмж болгосон юм. Гэвч энэ чиглэлээр огт ажил хийгдээгүй ба дээрх байгууллагууд анхаарлаа хандуулаагүй хэвээр байна. Иймээс орон нутгийн төсвийн ил тод байдлын загвар стандартыг батлан мөрдүүлж, хэрэгжүүлэх механизмыг бүрдүүлэх нь чухал байна.
10. *Тухайн орон нутагт зарцуулж байгаа бүх төсвийг ил тод болгох.* Аймаг, нийслэл, сум, дүүргийн удирдах байгууллагууд төсвийн ил тод байдлыг зөвхөн өөрийн эрх мэдлийн хүрээнд захиран зарцуулж буй төсөвт хамааруулах хандлагатай байна. Бодит байдал дээр тухайн засаг захиргааны нэгжийн нутаг дэвсгэрт өөрийн төсвийн хөрөнгөөс гадна дээд шатны буюу суманд аймгийн төсвийн, харин аймгийн хэмжээнд улсын төсөв, гадаад, дотоодын төсөл хөтөлбөр, зээл тусламж, хандивын хөрөнгө оруулалт, барилга байгууламж, дэд бүтцийн томоохон худалдан авах ажиллагаа явагдаж, тэр хэмжээгээр орон нутгийн хөгжилд хувь нэмэр оруулж, ашиг тусыг нь нутгийн иргэд шууд хүртдэг билээ. Гэтэл энэ бүгдийг иргэд хөндлөнгөөс идэвхгүй харахаас өөрөөр оролцоогүй байна. Иймээс тус тусын орон нутагт зарцуулагдаж байгаа улсын

төсөв, салбарын яамдаас эрх шилжиж ирсэн болон бусад төсөв, хөрөнгө оруулалтын талаарх мэдээллийг иргэддээ орон нутгийн төсвийн нэгэн адил нээлттэй болгож, шаардлагатай тохиолдолд хяналт тавьж, асууж лавлан, цаашдаа оролцох боломжийг бүрдүүлж ажиллах нь чухал юм.

11. *Төсвийн мэдээллийг нийт иргэдэд хүргэх чиг үүргийг төрийн бус байгууллагаар гүйцэтгүүлэх.* Төсвийн мэдээллийг интернэтээс авах боломж маш хязгаарлагдмал гэсэн ойлголт түгээмэл байдаг ч өнөөдөр орон нутгийн иргэдийн дийлэнх нь оршин суудаг аймаг төдийгүй сумын төвүүд сүүлийн хэдхэн жилд өндөр хурдны интернэтийн сүлжээнд ээлж дараалан холбогдоод байна. Үүний ачаар тухайн аймаг, суманд үйл ажиллагаа явуулдаг нэг талаас төрийн байгууллага, албан хаагчид, нөгөө талаас залуучууд, төрийн бус байгууллагынхан зэрэг идэвхтэй хэсэг интернэтийг улам өргөнөөр ашигладаг болж байгаа тул тэднээр дамжуулан бусад иргэд тухайлбал, малчдад төрийн ямар ч мэдээллийг хүргэх загварыг нарийвчлан боловсруулах нь зүйтэй. Тухайлбал, төсвийн мэдээллийг цахим хуудсанд хэрхэн нээлттэй болгож байгааг төрийн бус байгууллагууд хянахын зэрэгцээ алслагдсан гэр хорооллын иргэд, хөдөөгийн малчид, нийгмийн бусад хэсэг бүлэгт шинэлэг, ойлгомжтой байдлаар хүргэх ажлыг төрийн зарим чиг үүргийг төрийн бус байгууллагаар гэрээлэн гүйцэтгүүлэх зарчмаар хэрэгжүүлж болох юм.
12. *Төсвийн ил тод байдалд хяналт тавих механизмыг тодорхой болгох.* Аймаг, нийслэлийн төсвийн байгууллагууд төсвийн мэдээллээ хууль тогтоомжийн дагуу ил тод болгож буй эсэхэд хяналт тавих үйл ажиллагаа хангалтгүй байгаа нь үүнд хяналт тавих этгээд тодорхойгүй байгаатай холбоотой. Орон нутгийн төсвийн ил тод байдалд хяналт тавих чиг үүргийг хэн хариуцан гүйцэтгэхийг тодорхой болгож, хүлээлгэх хариуцлагыг хууль тогтоомжид тусгах нь чухал байна.
13. *Худалдан авах ажиллагаанд иргэний нийгмийн оролцоог нэг зарчмаар ханган хэрэгжүүлэх.* “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулинд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоод, хувийн хэвшил, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөл, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн ИТХ-аас томилсон иргэн, ЗДТГ-ын ажилтныг оролцуулахаар заасныг аймаг, нийслэлд хэрэгжүүлж буй практик янз бүр байна. Ихэнх аймагт үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг албан ёсоор зарлахгүйгээр нууцлан ажиллуулж байх жишээтэй. Бас салбарын мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллага гэдгийг янз бүрээр ойлгож өөрсдийн үзэмжээр шийдэж байна. Ялангуяа ИТХ-аас томилсон гэх иргэний асуудал хаалттай өнгөрч байна. Энэ бүгдийг харгалзан худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор аймаг, орон нутагт тендер шалгаруулалтыг зохион байгуулах үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд иргэд, иргэний нийгмийн төлөөллийг оролцуулах зарчим, шалгуурыг тодорхой болгох шаардлагатай.
14. *Орон нутгийн төсвийн мэдээллийг ил тод болгох замаар иргэд төсвийн үйл явцад бүтээлчээр оролцох нөхцөлийг бүрдүүлэх.* Төсвийн ил тод байдлыг хангаснаар төсвийн үйл явцад иргэд оролцож эхэлж байна. Зарим аймагт төсвийг сум, багийн түвшинд иргэдээр хэлэлцүүлж байгаа нь энэ үйл ажиллагаа хэдий жигдрээгүй ч гэсэн өмнөх судалгааны дүнд огт ажиглагдаагүй үйл ажиллагааг эхэлж байгааг харуулж

байна. Иймээс орон нутгийн төсвийн үйл явц, баримт бичгийн ил тод байдлыг илүү сайн хангаж чадвал иргэдийн бүтээлч оролцоог нэмэгдүүлэхэд чухал ач холбогдолтой байх болно. Орон нутгийн байгууллагууд төсвөө захиран зарцуулах эрх мэдэл авсан өнөө үед иргэд төсвийн үйл явцад оролцох сонирхол ихээхэн нэмэгдэж байна. Иймд төсвийн баримт бичиг, үйл явцын талаарх иргэдийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, төсвийн үйл явцад хяналт тавих, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгож, хууль хэрэгжүүлэх үйл ажиллагааг тогтмолжуулах зайлшгүй шаардлагатай байна.

5 Хавсралтууд

Хавсралт 1. Судалгааны арга зүй

Энэхүү судалгааг Улаанбаатар хот дахь судалгааны баг болон орон нутаг дахь ТББ-ууд хамтран гүйцэтгэнэ.

Улаанбаатар хот дахь судалгааны баг дараах үндсэн ажлуудыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Судалгааны ажлын арга зүйг боловсруулах. Үүнд:
 - Орон нутгийн төсвийн ил тод байдлыг үнэлэхэд шаардагдах баримт бичгийн жагсаалтыг гаргах
 - Орон нутгийн төсвийн ил тод байдлыг үнэлэх санал асуулгыг боловсруулах
 - Асуулгыг бөглөх заавар боловсруулах
 - Судалгааг үнэлэх аргачлал боловсруулах
- Судалгааг эхлүүлэхээс өмнө Орон нутгийн судлаачдад судалгааны асуулгыг бөглөх, мэдээлэл авах талаар сургалт, семинар зохион байгуулах
- Орон нутгаас мэдээлэл цуглуулахдаа 21 аймаг, нийслэлийн ТББ-уудтай гэрээ хийн ажиллах
- Орон нутгийн нэг нэгжийг сонгон асуулгыг турших, асуулга бөглөх явцыг ажиглан, холбогдох зөвлөмжийг орон нутгийн судлаачдад өгөх
- Аймаг, нийслэл, дүүрэгт уг судалгааны материалыг цуглуулж, асуулга бөглөх орон нутгийн ТББ-уудыг Улаанбаатараас чиглүүлж удирдах, Орон нутаг дахь ТББ-уудаас бэлтгэж ирүүлсэн судалгааны дүн мэдээллийг хүлээн авч нягтлах, тодруулга авах, боловсруулах, нэгтгэх.

Орон нутаг дахь ТББ-ууд дараах ажлыг гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгааны асуулгын дагуу баримт мэдээлэл цуглуулах
- Цуглуулсан баримт мэдээллийг баталгаажуулах
- Шаардлагатай тохиолдолд нэмэлт мэдээлэл авч, тодруулах
- Орон нутгийн төсвийн ил тод байдлын судалгааны асуулгыг маягтын дагуу бөглөх
- Бэлэн болгож, баталгаажуулсан баримт мэдээлэл, маягтын дагуу бөглөсөн материалыг Улаанбаатар хот дахь судалгааны багт хүлээлгэж өгөх.

Хавсралт 2. Орон нутгийн судлаачийн ажлын удирдамж

Судалгааны тухай

Энэхүү судалгаа нь 2010-2011 онд Олон улсын төсвийн түншлэл байгууллагын Нээлттэй төсвийн санаачилгын санхүүгийн болон арга зүйн дэмжлэгтэйгээр Нээлттэй Нийгэм Форум, “Иргэд төсвөө хянана” иргэний нийгмийн сүлжээтэй хамтран гүйцэтгэж байгаа хоёр жил тутмын ээлжит судалгаа юм.

Ажил гүйцэтгэх хугацаа

Орон нутгийн судлаач нь уг ажлыг 2013 оны 11-12 дугаар сард хийж гүйцэтгэх ба 2014 оны 1 дүгээр сарын туршид зарим мэдээлэл, нотолгоог гүйцээх, нягтлах зэргээр Улаанбаатар дахь судалгааны багтай хамтран ажиллана.

Ажлын хамрах хугацаа

- Зөвхөн 2013 оны туршид, цөөн тохиолдолд 2014 оны 1 дүгээр сард хамаарах төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичиг хамрах ба зөвхөн энэ хугацаанд тэдгээрийг хэрхэн “ил тод, нээлттэй болгосон”-ыг авч үзнэ. Төсвийн цаглабарыг хавсаргав.
- Өмнөх жилүүдийн, эсвэл тодорхой цаг хугацаагүй тохиолдлыг “ил тод болгодог” гэх мэтээр ерөнхийлөн авч үзэхгүй.

Ажлын үндсэн зорилго

Орон нутгийн судлаач нь Улаанбаатар дахь судалгааны багийн боловсруулсан асуулга буюу маягтын дагуу тус тусын орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгүүдийг үндсэн эхээр нь цуглуулж тэдгээрийг иргэд, олон нийтэд хэрхэн ил тод, нээлттэй болгосныг нотолсон баримтын хамт судалгааны багт шуурхай ирүүлэх үндсэн үүрэгтэй.

Баримтлах зарчмууд

- Орон нутгийн судлаачид нь “АЙМГИЙН ТӨСВИЙН МЭДЭЭЛЭЛ, БАРИМТ БИЧГИЙГ ЦУГЛУУЛЖ, ТЭДГЭЭРИЙГ ХЭРХЭН ИЛ ТОД, НЭЭЛТТЭЙ БОЛГОСНЫГ НОТОЛЖ ИРҮҮЛЭХ МАЯГТУУД”-ын асуулгад хариулах зарчмаар төсвийн мэдээлэл, баримт бичгийг цуглуулж тэдгээрийг ил тод болгосон эх сурвалж, цаг хугацаа, арга хэлбэр, нөхцөл байдлыг нотлох ба энэ тухайгаа хариултын нүд тус бүрт тайлбарлаж бичээд ямар ямар мэдээлэл, баримт бичиг, нотолгоог хавсаргаснаа жагсаана.
- Мэдээлэл, баримт бичгийн эх, эсвэл хуулбар, нотолгоог хавсаргаагүй бол ил тод биш байсан гэж үзнэ.
- Маягт буюу асуулгад хамаарахгүй мэдээлэл, баримт бичгийг ирүүлж болох ч судалгааны баг тэдгээрийг авч үзэх үүрэг хүлээхгүй.
- Мэдээлэл, баримт бичиг ба нотолгоо нь цаасан, цахим, дуу, дүрс бичлэгийн ямар ч хэлбэрээр байж болно.
- Орон нутгийн судлаач нь төсвийн баримт бичгийг анхдагч эх сурвалжаас авсан үндсэн эхээр, эсвэл хуулбарлаж ирүүлэх ба өөрчлөхгүй, нэмж хасахгүй, агуулгад дүгнэлт хийхгүй ба агуулгыг тайлбарлахгүй.

- Цуглуулсан мэдээлэл, баримт бичгийг энэхүү удирдамжийн төгсгөлд дурдсан хаягаар ирүүлнэ. Цаг алдахгүйн тулд цаасан баримт бичгийг сканнердаж электрон шуудангаар ирүүлж болно, гэхдээ цаасан эхийг хэсэг хугацааны дараа заавал ирүүлнэ.

Төсвийн ил тод, нээлттэй байдлыг нотлох дараалал

Дараах дэс дарааллыг баримталж нотолно.

Нэгдүгээрт, маягтад заасан төсвийн мэдээлэл ба баримт бичгийг нээлттэй эх сурвалжаас цуглуулна. Үүнд:

- Орон нутгийн сонин хэвлэл, телевиз, радио
- Орон нутгийн төр захиргааны албан ёсны болон бусад цахим хуудас
- Мэдээллийн хуудас, товхимол
- Мэдээллийн самбар
- Аймгийн номын сан
- Иргэний танхим
- Хэвлэлийн бага хурал, уулзалт, хэлэлцүүлэг
- Бусад

Хоёрдугаарт, төсвийн мэдээлэл ба баримт бичиг нээлттэй эх сурвалжаас олдоогүй буюу ил тод болоогүй тохиолдолд холбогдох байгууллага, албан тушаалтанд хандаж болно.

Гуравдугаарт, шаардлагатай тохиолдолд “Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”-ийн 3-р бүлгийн холбогдох заалтуудын дагуу хүсэлт тавьж мэдээлэл авч болно.

Төсвийн ил тод, нээлттэй болгосныг нотлох аргууд

- Гэрэл зураг, эсвэл видео бичлэг
- Сонин хэвлэлийн тухайн дугаар буюу хайчилбар
- Ном товхимол, сонин бичгийн нэг хувь
- Цахим сайтад нийтлэгдсэн материал, түүний зураг (screenshot) ба хуулбар (текст), огноо ба линк (холбоос)
- Мэдээлэл, баримт бичгийг олж авахын тулд байгууллага, албан тушаалтантай уулзаж харилцсан тухай товч тэмдэглэл.

Судалгааны цахим хуудас

Судалгааны явцад цуглуулсан төсвийн мэдээлэл, баримт бичгүүд нь www.iltusuv.mn цахим хуудсанд байршиж ил тод байх тул байнга үзэж танилцан өөрсдийн явуулсан мэдээлэл, баримт бичиг, тэдгээрийн нотолгоо бүрэн гүйцэд тавигдсан эсэхэд хяналт тавьж санал бодлоо хэлж байна.

Орон нутгийн судлаачийн ажлын удирдамжийн хавсралт

Орон нутгийн төсвийн үйл явцын мэдээлэл ба баримт бичгийг цуглуулж, хэрхэн ил тод, нээлттэй болгосныг нотлох цаглабар

Тайлбар: Энэ нь зөвхөн хураангуй цаглабар юм. Дэлгэрэнгүйг Маягтаас үзнэ үү.

Ил тод болгох ёстой буюу түүнийг нягтлах хугацаа	Төсвийн баримт бичиг ба үйл явц	Хугацаа
2013.04.01-ны дотор	2012 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан	Нөхөж авч үзнэ
2013.04.25-ын дотор	2012 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийсэн тайлан	Нөхөж авч үзнэ
2013.08.15-ны дотор	2014 оны төсвийн санал	Нөхөж авч үзнэ
2013.08.15-ны дотор	2014 оны төсвийн төсөл	Нөхөж авч үзнэ.
2013.08.15-ны дотор	2013 оны төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайлан	Энэ өдрийн байдлаар авч үзнэ.
2013.09.01-ны дотор 2013.09.30-ны дотор 2013.11.25-ны дотор	Орон нутгийн хөгжлийн сангийн ирэх 2014 оны төлөвлөгөө (урьдчилсан жагсаалт, иргэд, олон нийтийн санал авах явц)	2013 оны 11-р сард болон нөхөж авч үзнэ
2013.11.06-ны дотор 2013.12.06-ны дотор	2013 оны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ	2013 оны 11,12-р сарын байдлаар авч үзнэ
2013.11.10-ны дотор 2013.12.10-ны дотор	2013 оны худалдан авалтын явц, үр дүн	2013 оны 11,12-р саруудад болон нөхөж авч үзнэ
2013.11.10-ны дотор	2014 оны төсвийн төсөл (Аймаг, нийслэлийн ерөнхий аудиторт хүргүүлсэн)	Энэ өдрийн байдлаар авч үзнэ.
2013.11.25-ны дотор	2014 оны төсвийн төсөл (ИТХ-д өргөн мэдүүлсэн)	Энэ өдрийн байдлаар авч үзнэ.
2013.12.05-ны дотор	Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал	2013.12.05-наас өмнө хуралдсан байдлаар
2013.12.12-ны дотор	2014 оны батлагдсан төсөв	Энэ өдрийн байдлаар авч үзнэ.
2013.12.31-ны дотор	2014 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь	Энэ өдрийн байдлаар авч үзнэ.
2014.01.05-ны дотор	2014 оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө	Энэ өдрийн байдлаар авч үзнэ.
2014.01.10-ны дотор	2014 оны батлагдсан төсөв	Энэ өдрийн байдлаар авч үзнэ.
2014.01.15-ны дотор	2013 оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан	Энэ өдрийн байдлаар авч үзнэ.
Жилийн турш	Аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр ирэх 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал асуулга явуулж, жагсаалт боловсруулан өргөн барих үйл явц, үр дүн (Аймаг, нийслэлд шилжүүлсэн санал)	Нөхөж авч үзнэ
Жилийн турш	Аймаг, нийслэлийн Засаг даргын 2013 оны нөөц хөрөнгийн ил тод байдал	Нөхөж, эсвэл 2014 оны 1-р сарын байдлаар авч үзнэ.
Жилийн турш	Аймаг, нийслэлийн орон нутгийн тусгай сангуудын 2013 оны төсвийн ил тод байдал	Нөхөж, эсвэл 2014 оны 1-р сарын байдлаар авч үзнэ.

Жилийн турш	Аймаг, нийслэлийн 2013 оны хандив, тусламжаар авсан хөрөнгө, түүний зарцуулалтын ил тод байдал	Нөхөж, эсвэл 2014 оны 1-р сарын байдлаар авч үзнэ.
Хугацаа хамаарахгүй	Төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдал	Нөхөж, эсвэл 2014 оны 1-р сарын байдлаар авч үзнэ.
Хугацаа хамаарахгүй	Иргэний төсөв	Нөхөж, эсвэл 2014 оны 1-р сарын байдлаар авч үзнэ.
Хугацаа хамаарахгүй буюу тодотгол хийсэн тухай бүр	Аймаг, нийслэлийн 2013 оны төсвийн тодотгол (хэрвээ тодотгол хийгдсэн бол)	Нөхөж авч үзнэ.

Хавсралт 3. Аймаг, нийслэлийн төсвийн мэдээлэл, баримт бичгийг цуглуулж, тэдгээрийг хэрхэн ил тод, нээлттэй болгосныг нотолж ирүүлэх маягтууд

1. Төсвийн ил тод, нээлттэй байдлыг нутгийн удирдлагын байгууллагаас гаргасан эрх зүйн баримт бичигт тусгасан байдал

<p>Төсвийн ил тод байдлын тухайд орон нутгийн түвшинд гаргасан тогтоол, захирамж, шийдвэр зэрэг албан ёсны баримт бичиг</p>	<ol style="list-style-type: none"> 1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хуудасны тоо 2. Уг баримт бичгээс төсвийн ил тод, нээлттэй байдлын холбогдолтой бүлэг, зүйл, заалт, ишлэлийг хуулж оруулах. 3. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана) 4. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 5. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
<p>Орон нутгийн бодлогын баримт бичиг (Тухайлбал, аймаг, нийслэлийн нийгэм, эдийн засгийг 2013 онд хөгжүүлэх үндсэн чиглэл, зорилт)</p>	
<p>Аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал ба Тэргүүлэгчдийн тогтоол, шийдвэр</p>	
<p>Аймаг, нийслэлийн Засаг даргын салбарын Төсвийн ерөнхийлөн захирагч нартай байгуулсан төлөөлөн гүйцэтгэх гэрээ</p>	
<p>Аймаг, нийслэлийн Засаг даргын 2012-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөр</p>	
<p>Аймаг, нийслэлийн Засаг даргын захирамж, албан даалгавар</p>	
<p>Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын Засаг даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ</p>	
<p>Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын даргын албан бичиг, үүрэг даалгавар</p>	
<p>Аймаг, нийслэлийн ЗДТГ-ын даргын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргатай байгуулсан үр дүнгийн гэрээ</p>	
<p>Аймгийн ЗДТГ-ын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын албан бичиг, үүрэг даалгавар</p>	
<p>Аймгийн төсвийн байгууллагуудын төсвийн захирагч нартай байгуулсан үр дүнгийн гэрээ</p>	
<p>Бусад</p>	

2. Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийн баримт бичиг, түүний хэлэлцүүлгийн ил тод байдал

2014 оны төсвийн санал, төсвийн төсөл (2013 оны 8 дугаар сарын 15-ны дотор дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

"Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам":

- 3.1. "Төсвийн тухай хуулийн 27.5-д заасны дагуу санхүү, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 5-ны өдрийн дотор төсвийн удирдамжийг хүргүүлнэ"
- 4.3. Орон нутгийн суурь төсвийн саналыг дараах цаглабарын дагуу боловсруулж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлнэ:
 - 4.3.1. орон нутгийн төсөвт байгууллага болон орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа тусгай зориулалтын шилжүүлгийн гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсөвт байгууллагын төсвийн захирагч сум, дүүргийн Засаг даргад суурь төсвийн саналыг жил бүрийн 7 дугаар сарын 15-ны дотор хүргүүлнэ;
 - 4.3.2. сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсөвт байгууллага болон тусгай зориулалтын шилжүүлгийн үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг нэгтгэн аймаг, нийслэлийн Засаг даргад жил бүрийн 7 дугаар сарын 25-ны дотор хүргүүлнэ;
 - 4.3.3. аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох тусгай зориулалтын гэрээний үндсэн дээр санхүүжих улсын төсвийн байгууллагын суурь төсвийн саналыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагчид жил бүрийн 8 дугаар сарын 1-ний өдрийн дотор, орон нутгийн төсөвт байгууллагын суурь төсвийн саналыг санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад, үүнээс удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой хөрөнгийн суурь зардлын саналыг хөгжлийн бодлого төлөвлөлтийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор тус тус хүргүүлнэ;

"Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль":

- 9.1. Энэ хуулийн 3.1-д заасан байгууллага нь хуульд өөрөөр заагаагүй бол төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангах чиглэлээр дараах арга хэмжээ авч хэрэгжүүлнэ:
 - 9.1.1. тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх;
 - 9.1.1. в. дараа жилийн төсвийн төслийг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны өдрийн дотор.

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none"> 1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ 2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана) 3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	--

Аймаг, нийслэлийн 2014 оны суурь төсвийн саналыг боловсруулах явцад иргэд, олон нийтэд танилцуулсан, мөн тэдний саналыг авсан байдал

Аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох салбарын сайд, Сангийн яам, Эдийн засгийн хөгжлийн яаманд төсвийн саналыг 2013 оны 8 дугаар сарын 15-ны дотор хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгож танилцуулсан байдал

2014 оны аймаг, нийслэлийн төсвийн төслийг 2013 оны 8 дугаар сарын 15-ны дотор өөрийн цахим хуудсанд болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд байрлуулан иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал

2014 оны төсвийн төсөл (Аймаг, нийслэлийн аудитор 2013 оны 11 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлсэн)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд	
"Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам":	
7.3. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны төсвийн төслийг аймаг, нийслэлийн аудитор, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 11 дүгээр сарын 10-ны дотор хүргүүлнэ.	
Төсвийн баримт бичиг	<ol style="list-style-type: none"> 1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ 2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана) 3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэлийн Засаг дарга 2014 оны төсвийн төслийг 2013 оны 11 дүгээр сарын 10-ны дотор аймаг, нийслэлийн аудитор, Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхдээ олон нийтэд ил тод болгосон байдал

2014 оны төсвийн төсөл (ИТХ-д 2013 оны 11 дүгээр сарын 25-ны дотор өргөн мэдүүлсэн)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

"Төсвийн тухай хууль":

- 8.5.1. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн төслийг жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэх;
67 дугаар зүйл. Орон нутгийн төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх
67.1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга орон нутгийн төсвийн төслийг боловсруулж, энэ хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.
67.3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийн төслийг боловсруулах явцдаа төслийг тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулж, тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн санал, хүсэлтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулна.

"Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам":

- 7.4. Аймаг, нийслэлийн аудитор жилийн төсвийн төслийн талаарх дүгнэлтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

"Төсвийн тухай хууль":

- 67.2. Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:
67.2.1. орон нутгийн төсвийн бодлогын зорилтыг тусгасан дунд хугацааны төлөвлөгөө;
67.2.2. энэ хуулийн 22 дугаар зүйлд заасан төсвийн ангиллын дагуу боловсруулсан төсвийн төслийн тооцоо, танилцуулга;
67.2.3. аймаг, нийслэлийн төсвөөс сум, дүүргийн төсөвт олгохоор төлөвлөсөн санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлгийн санал;
67.2.4. дээд шатны төсөвт тусган баталсан дээд шатны төсөвт төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ.

"Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам":

- 7.2. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн жилийн төсвийн төслийг энэ журмын 5.1-д заасан мэдээлэлд үндэслэн Төсвийн тухай хуулийн 33.2-т заасны дагуу боловсруулж, мөн хуулийн 67.2-т заасан танилцуулгын хамт тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.
7.5. Аймаг, нийслэлийн жилийн төсвийн төсөлд Төсвийн тухай хуулийн 33.2-т заасныг дор дурдсан байдлаар тусгана

"Төсвийн тухай хууль":

- 33.2. Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална:
33.2.1. төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого;
33.2.2. төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ, үүнээс тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ;
33.2.3. төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын шинээр үүсгэх өр, гаргах баталгааны дээд хязгаар, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалт;
33.2.4. бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг;
33.2.5. төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар;
33.2.6. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;
33.2.7. /Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон/

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none"> 1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ 2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана) 3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	---

Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийг боловсруулах явцдаа тухайн шатны Засаг дарга олон нийтэд танилцуулсан байдал

Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийн талаар тухайн аймаг, нийслэлийн иргэдийн санал, хүсэлтийг тухайн шатны Засаг дарга Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд танилцуулсан байдал

Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийг тухайн шатны Засаг дарга 2013 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ ил тод болгож олон нийтэд танилцуулсан байдал

Аймаг, нийслэлийн аудитор 2013 оны төсвийн төслийн талаарх дүгнэлтийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор хүргүүлэхдээ ил тод болгосон байдал

3. Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн төслийг хэлэлцэж батлах ИТХ-ын хуралдааны ил тод байдал (2013 оны 11 дүгээр сарын 25-наас 12 дугаар сарын 5-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

"Төсвийн тухай хууль":

8.5.2. аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн шатны жилийн төсвийн төслийг хэлэлцэн жил бүрийн 12 дугаар сарын 5-ны дотор батлах;

Хуралдааны нээлттэй байдал	Тайлбар ба нотолгоог бичнэ. Шаардлагатай бол нотлох баримтыг хавсаргана.
----------------------------	--

Хуралдаан болсон огноо, газар, эхэлсэн, дууссан болон үргэлжилсэн хугацаа

Хуралдааны ирц

Хуралдааны хэлэлцсэн асуудлын жагсаалт, илтгэгчийн нэр, албан тушаал

Хуралдаанд иргэд, иргэний нийгэм, төрийн бус байгууллагын төлөөллийг оролцуулсан байдал (Хэрвээ оролцуулсан бол 5 хүний нэр, ажил, албан тушаалын жагсаалтыг энд бичнэ)

Хуралдаанд хэвлэл мэдээллийн хэрэгслийг оролцуулж сурвалжлуулсан байдал (Хэрвээ оролцуулсан бол тэдгээр байгууллагын жагсаалтыг энд бичнэ)

Хуралдааныг радио, телевизээр шууд дамжуулсан эсэх (Хэрвээ тийм бол тухайн радио, телевизийн нэр, хаягийг бичнэ)

Хуралдааны баримт бичгийн ил тод байдал

1. Иргэд, олон нийт дээрх баримт бичиг, материалыг хэзээ, хаанаас буюу хэнээс, хэрхэн олж авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
2. Судлаач өөрөө хуралдааны баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
3. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Хуралдааны хэлэлцэх асуудлын төлөвлөгөө

Хуралдаанд тараасан илтгэл, танилцуулга зэрэг материалууд

Хуралдааны тогтоол, шийдвэр

Хуралдааны тэмдэглэл буюу протокол

4. Аймаг, нийслэлийн 2014 оны батлагдсан төсвийн ил тод байдал 2014 оны батлагдсан төсөв (2013 оны 12 дугаар сарын 12-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

“Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”:

- 4.2. Тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталж, хүчин төгөлдөр болсны дараа төсвийн захирагч дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ:
- 4.2.2. төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн багцын төсвийг 7 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ.
[Энэ нь аймаг, нийслэлийн төсөв 12-р сарын 05-ны дотор батлагдсанаас хойш 12-р сарын 12-ны дотор гэсэн үг юм]

“Төсвийн тухай хууль”:

- 68.3. Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас баталсан тухайн жилийн төсвийг ил тод, олон нийтэд хүртээмжтэй байдлаар мэдээлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

Батлагдсан төсөв бүрэн эхээрээ, хавсралтуудын хамт. Үүнд:

1. Төсөв батлах тухай тогтоол
2. Төсвийн төлөвлөгөө (орлого зарлагын төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө)
3. Хавсралтууд

“Төсвийн тухай хууль”:

- 68.1. Орон нутгийн төсөвт энэ хуулийн 33.2.1-33.2.7-д заасныг тусгаж, батална.
- 33.2. Төсөвт дараах зүйлийг тусгаж, батална:
- 33.2.1. төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяалагдах шатны төсөвтөө тухайн жилд төвлөрүүлэх орлого, харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлого;
 - 33.2.2. төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсвийн зарлагын дээд хэмжээ, урсгал болон хөрөнгийн зарлагын дээд хэмжээ, үүнээс тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ;
 - 33.2.3. төсвийн алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр, Засгийн газрын шинээр үүсгэх өр, гаргах баталгааны дээд хязгаар, мөнгөн гүйлгээтэй холбогдох хязгаарлалт;
 - 33.2.4. бусад шатны төсөвт олгох орлогын шилжүүлэг, санхүүгийн дэмжлэг;
 - 33.2.5. төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг хавсралтаар;
 - 33.2.6. хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;
 - 33.2.7. концессын гэрээгээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт, тэдгээрт тавигдах тусгай шаардлага, нөхцөлийг хавсралтаар
- 68.2. Төсвийн төслийг Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцэх явцад нэмж тусгах хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг тухайн шатны төсвийг өргөн мэдүүлсэн этгээдээс энэ хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаж байгаа эсэх талаар санал, дүгнэлтийг авсны үндсэн дээр тусгана.

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none">1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	--

Аймаг, нийслэлийн 2014 оны төсөв батлагдаж хүчин төгөлдөр болсны дараа төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн багцын төсвийг 7 хоногийн дотор буюу 12 дугаар сарын 12-ны дотор олон нийтэд мэдээлсэн байдал

2014 оны батлагдсан төсөв (2014 оны 1 дүгээр сарын 10-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

"Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль":

9.1.1. тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх:

9.1.1. а.тухайн жилийн төсвийг жил бүрийн 01 дүгээр сарын 10-ны өдрийн дотор;

"Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам":

Нэг.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн төсвийг батлагдсан бүрэн эхээр нь ил тод болгоно. Энэ нь "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын хавсралт загвар, маягтуудын дагуу батлагдсан баримт бичгүүд байх юм.

Үүнд:

1. Хавсралт №2аймаг/нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол. Загвар маягт. " ... аймаг/нийслэлийн оны төсөв батлах тухай. Мөн тус тогтоолын хавсралтад заасан загвар, маягтуудын дагуу батлагдсан бусад баримт бичгүүд байна.

Үүнд:

2. "Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн" (... аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 1 дүгээр хавсралт)",

3. "...аймаг, нийслэлийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт (... аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 2 дугаар хавсралт),

4. "...аймаг/нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт" (... аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 3 дугаар хавсралт),

5. "...сум/дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны тогтоол (загвар маягт) ".... сум/дүүргийн оны төсөв батлах тухай",

6. "Төсвийн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн" (...сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 1 дүгээр хавсралт)"

7. "...сум/дүүргийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт (... сум/дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 2 дугаар хавсралт),

8. "...сум/дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт" (... сум/дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 3 дугаар хавсралт),

7. "...сум/дүүргийн төсвөөс санхүүжих хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт (... сум/дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 2 дугаар хавсралт),
8. "...сум/дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний жагсаалт" (... сум/дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдааны 20.. оны .. -р тогтоолын 3 дугаар хавсралт),

"Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам»:

Гурав. Мэдээллийн бүтэц

- 3.1. Төсвийн байгууллагын мэдээлэл дараах бүтэцтэй байна:
 - 3.1.1. эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв;
- 3.2. Энэ журмын 3.1.1-д заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:
 - 3.2.1. эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв, гүйцэтгэлийг хэмжих шалгуур үзүүлэлт;
 - 3.2.2. орлого (үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого);
 - 3.2.3. урсгал зардал (үндсэн цалин, цалингийн нэмэгдэл, бараа үйлчилгээний зардал, татаас, шилжүүлэг);
 - 3.2.4. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, концессийн зүйлсийн жагсаалт;
 - 3.2.5. улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа;
 - 3.2.6. зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр (улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого);
 - 3.2.7. байгууллагын батлагдсан орон тоо.

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none"> 1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ 2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана) 3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	---

Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийг 1 дүгээр сарын 10-ны дотор өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал

2014 оны батлагдсан төсвийн сар, улирлын хуваарь (2013 оны 12 дугаар сарын 31-ний дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

"Төсвийн тухай хууль":

- 8.7. Аймаг, нийслэлийн жилийн төсвийн сар, улирлын хуваарийг дараах цаглабарын дагуу боловсруулж, батлана.
 - 8.7.1. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор батлах;
 - 8.7.2. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны жилийн төсвийн сар, улирлын батлагдсан хуваарийг жил бүрийн 12 дугаар сарын 31-ний дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

Арга хэлбэр буюу загвар:

Бүрэн эхээр нь

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none">1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	--

Аймаг, нийслэлийн 2014 оны төсвийн сар улирлын хуваарийг 12 дугаар сарын 25-ны дотор батлах, эсвэл 12 дугаар сарын 31-ний дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ ил тод болгож танилцуулсан эсэх

5. Иргэний төсөв

Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

2013 оны байдлаар Монгол Улсын хууль тогтоомжид Иргэний төсвийн тухай заалт байхгүй.

Гэхдээ аймаг, нийслэлийн түвшинд өөрийн санаачилгаар болон бусад байгууллагатай хамтран иргэдэд зориулсан төсвийн баримт бичиг боловсруулж гаргах боломжтой бөгөөд тэгсэн тохиолдолд үнэлнэ.

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none">1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	--

2013 оны, эсвэл 2014 оны төсвийн жишээн дээр боловсруулсан байж болно

6. Аймаг, нийслэлийн 2013 оны төсвийн тодотгол (хэрвээ тодотгол хийгдсэн бол)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”:

- 9.1.1. тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх;
- 9.1.4. тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд ажлын 14 өдрийн дотор энэ тухай цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлэх;
- “Орон нутгийн төсөв боловсруулах журам”:

Арав. Төсвийн тодотголын төсөл боловсруулах

- 10.1. Төсвийн тодотголын төслийг Төсвийн тухай хуулийн 34.2-т заасан нөхцөл байдал үүссэн тохиолдолд боловсруулна.
- 10.2. Дээд шатны төсөвт тодотгол орсны улмаас доод шатны төсвийн захирагч батлагдсан төсөвтөө зайлшгүй тодотгол оруулах шаардлагатай гэж үзвэл дээд шатны төсөвт тодотгол орсноос хойш 45 хоногт багтааж төсвийн тодотголын төслийг боловсруулж тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.
- 10.3. Төсвийн тодотголын төслийг зөвхөн нэмэлт, өөрчлөлт оруулж буй зүйлийг энэ журмын 7 дугаар зүйлд заасны дагуу боловсруулж тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлнэ.
- 10.4. Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн төсвийн тодотголын төслийг тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал хэлэлцэн баталснаас хойш 30 өдрийн дотор сар, улирлын хуваарийг баталж, нэгтгэн, санхүү төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ.

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Хэрвээ 2013 онд төсвийн тодотгол хийгдсэн бол төслийг нь тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлэхдээ олон нийтэд ил тод болгож танилцуулсан байдал

Тухайн төсвийн тодотголын төслийг хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны огноо, болсон газар, хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хуралдааны илтгэл, танилцуулга, хуралдааны тэмдэглэл

Тухайн төсвийн тодотголын төслийг хэлэлцэж баталсан ИТХ-ын хуралдааны нээлттэй байдал

Тухайн жилийн төсөвт нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолдажлын 14 өдрийн дотор энэ тухай цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан мэдээлсэн эсэх

7. Аймаг, нийслэлийн 2013 оны хөрөнгө оруулалт, худалдан авах ажиллагааны ил тод байдал

2013 оны худалдан авах ажиллагааны жилийн тайлан (2014 оны 1-р сарын 15-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”:

3.6. Төсвийн ерөнхийлөн захирагч хуулийн 45.1 дэх, 45.2.1 дэх заалтыг үндэслэн батлагдсан багцын хүрээнд өөрийн хэрэгцээнд худалдан авах ажиллагааг зохион байгуулсан хэрэгжилтийн, мөн хуулийн 45.4 дэх заалтын дагуу Худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллага нь тухайн оны худалдан авах ажиллагааны тайланг Маягт 2, 3-ын дагуу нэгтгэн хуулийн 49.5-д заасны дагуу дараа оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

Сангийн сайдын 2012 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 264 тоот тушаалаар баталсан “Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 1-р хавсралтын “Захиалагчийн ... оны бараа, ажил үйлчилгээ худалдан авалтын тайлан” маягт №2, 3-ын дагуу.

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэлийн Засаг дарга 2013 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтийн тайланг 2014 оны 1 дүгээр сарын 15-ны өдрийн дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал

**2014 оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөө
(2014 оны 1 дүгээр сарын 5-ны дотор)**

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль":

48.5. Захиалагч худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг тухайн жилийн төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлнэ.

Хугацаа:

1 дүгээр сарын 05-ны дотор (Аймаг, нийслэлийн төсөв 12 дугаар сарын 5-ны дотор батлагдах тул түүнээс хойш нэг сарын дотор буюу 1 дүгээр сарын 05-ны дотор гэж тооцоолов)

Арга хэлбэр буюу загвар:

Батлагдсан бүрэн эхээр нь, дэлгэрэнгүй жагсаалт хэлбэрээр ил тод болгоно. Ингэхдээ, Сангийн сайдын 2012.12.13-ны 264-р тогтоолоор батлагдсан "Төрийн ба орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам"-ын хавсралт №1 буюу "Захиалагчийн ... онд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөө маягтыг баримтална.

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэлийн 2014 оны худалдан авах ажиллагааны жилийн төлөвлөгөөг төсөв батлагдсанаас хойш нэг сарын дотор буюу 1 дүгээр сарын 5-ны дотор хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд зарлан мэдээлсэн байдал

2013 оны худалдан авалтын явц, үр дүнгийн ил тод байдал

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

"Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"

(Сангийн сайдын 2012.12.27-ны 290-р тушаалаар батлагдсан):

- 3.29. Аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэх бөгөөд санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж байна.
- 4.5. Төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж буй ажлын санхүүжилт, түүний гүйцэтгэлтэй холбоотой асуудлаар төсвийн эрх захирагч, тухайн нутгийн захиргааны байгууллагаас орон нутгийн иргэд, төрийн бус байгууллагуудыг хөндлөнгийн хяналт тавих боломжоор хангах үүрэгтэй.
- 6.3. Төсвийн өрөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүр энэ журмын тавдугаар хавсралтаар батлагдсан маягтын дагуу гаргаж, сар бүрийн дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

Сангийн сайдын 2012.12.27-ны 290-р тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам"-ын Хавсралт №5 буюу "..... Аймаг/сумын нутагт улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдаж буй барилгын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн –р сарын мэдээ" маягтын дагуу.

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"

- 47.4. Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна.

"Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль"

- 46.1. Захиалагч бараа, ажил, үйлчилгээг худалдан авах талаар дараах эрх, үүрэгтэй байна:

- 46.1.9. гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг төв, суурин бүрийн олон нийтэд үзэгдэхүйц газар уг ажил, үйлчилгээний баталгаат хугацааны туршид заавал байрлуулахыг шаардах.

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none"> 1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ 2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана) 3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	---

Аймгийн төрийн сангийн асуудал хариуцсан нэгж, мэргэжилтэн нь 2013 онд тухайн орон нутагт төсвийн хөрөнгөөр хийгдэж буй ажлын санхүүжилтийн талаарх мэдээллийг Засаг даргын Тамгын газрын мэдээллийн самбарт шуурхай байрлуулж, нийтэд мэдээлэх ажлыг тогтмол гүйцэтгэж, санхүүжилт хийгдсэн тухай бүр мэдээллийг шинэчилж байсан байдал

2013 онд аймгийн төсвийн өрөнхийлөн захирагч нь өөрийн багцад батлагдсан төсвийн хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээ, ажлын явц, үр дүнгийн талаарх тайланг сар бүрийн дараа сарын 5-ны дотор Сангийн яаманд хүргүүлэхдээ олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал

Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор 2013 онд үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэнийг оролцуулсан байдал

2013 онд тухайн ажил, үйлчилгээний гүйцэтгэгч компанийн товч танилцуулга, харилцах утас, гүйцэтгэж байгаа ажил, үйлчилгээний гэрээний үнийн дүн, санхүүжилтийн хуваарь, ажил эхлэх, дуусах хугацаа болон авто зам, инженерийн шугам сүлжээний хувьд дайран өнгөрөх маршрут зэргийг багтаасан мэдээллийн самбарыг заавал байрлуулсан байдал

8. Аймаг, нийслэлийн 2012 оны төсвийн гүйцэтгэлийн ил тод байдал 2013 оны төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ (Сар бүрийн 6-ны дотор).

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

"Төсвийн тухай хууль":

- 8.8. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв, аймаг, нийслэлийн төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг дараах цаглабарын дагуу боловсруулж, батална.
- 8.8.1. төсвийн шууд захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 2-ны дотор харьяалагдах төсвийн төвлөрүүлэн захирагчид хүргүүлэх;
- 8.8.2. төсвийн төвлөрүүлэн захирагч тусгай сан, төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 4-ний дотор харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлэх;
- 8.8.3. төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 6-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

2013 оны төсвийн сарын гүйцэтгэлийн мэдээг аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч сар бүрийн 6-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ олон нийтэд танилцуулж ил тод болгосон байдал

2013 оны төсвийн гүйцэтгэлийн улирлын тайлан (2013 онд улирал бүрийн дараа сард)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм, журмын заалтууд

"Төсвийн тухай хууль":

- 8.9. Улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсөв, Хүний хөгжил сангийн төсөв, орон нутгийн төсвийн улирал, хагас, бүтэн жилийн төсвийн гүйцэтгэл, төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланг дараах цаглабарын дагуу боловсруулна: [Гэвч цааш нь улирлын төсөвтэй хамаатай тодорхой зохицуулалт олдсонгүй]

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

2013 оны аймаг, нийслэлийн төсвийн улирлын тайланг ил тод болгосон байдал

2013 оны төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайлан (2013 оны 8 дугаар сарын 15-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Төсвийн тухай хууль”:

8.9.5. төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 5-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

“Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам”:

4.3. Төсвийн гүйцэтгэлийн тайланг эрх бүхий этгээд дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ:

4.3.3. төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор.

Төсвийн баримт бичиг ба үйл явц

1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ
2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар. (Баримтаар нотолж хавсаргана)
3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар
4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт

Аймаг, нийслэлийн 2013 оны төсвийн хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг 2013 оны 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэхдээ ил тод болгож олон нийтэд хүргэсэн байдал

2012 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан (2013 оны 4 дүгээр сарын 1-ний дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль”:

9.1.1. тухайн жилийн төсөв, өмнөх оны төсвийн гүйцэтгэл, дараа жилийн төсвийн төслийг өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлэх:

9.1.1.б. өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор;

9.1.2. жилийн эцсийн санхүүгийн тайланг дараа жилийн 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангах;

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none">1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	--

2012 оны төсвийн гүйцэтгэлийг 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өөрийн цахим хуудас болон Монгол Улсын төсвийн ил тод байдал цахим хуудсанд дор дурдсан хугацаанд байрлуулан мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлийг бүрдүүлсэн байдал

2012 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг 2013 оны 4 дүгээр сарын 1-ний өдрийн дотор цахим хуудас болон мэдээллийн самбартаа ойлгомжтой байдлаар байрлуулан иргэд, иргэний нийгмийн байгууллагын зүгээс төсвийн зарцуулалтад хяналт тавих боломжийг хангасан байдал

2012 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийсэн тайлан (2013 оны 4 дүгээр сарын 25-ны дотор)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

"Төсвийн тухай хууль":

- 8.9. 4.аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 1-ний дотор төрийн аудитын байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг 4 дүгээр сарын 20-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх ба аудит хийсэн тайланг нийтэд мэдээлэх;
- 8.9.5. төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг жил бүрийн 8 дугаар сарын 15-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайланг дараа оны 4 дүгээр сарын 5-ны дотор төрийн аудитын төв байгууллагад хүргүүлж, аудит хийсэн тайланг жил бүрийн 4 дүгээр сарын 25-ны дотор санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none"> 1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ 2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана) 3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар 4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
---------------------------------	---

Аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагч
2012 оны жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн
тайланд аудит хийсэн тайланг нийтэд мэдээлсэн
байдал

9. Аймаг, нийслэлийн 2014 оны орон нутгийн хөгжлийн сангийн ил тод байдал Орон нутгийн хөгжлийн сангийн 2014 оны төлөвлөгөө (урьдчилсан жагсаалт, иргэд, олон нийтийн санал авах явц)

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

"Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам":

- 6.3. Орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл хөтөлбөр арга хэмжээг төлөвлөхөд дараах зүйлсийг баримтална:
- 6.3.5. иргэдийн оролцоог хангасан байх;

Арван хоёр. Төсвийн төслийг боловсруулахад иргэдийн оролцоог хангах

- 12.1. Аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээг төлөвлөхөд иргэд, олон нийтийн оролцоог дараах байдлаар хангана:
- 12.1.1. аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна;
- 12.1.2. иргэд, олон нийтийн саналыг цахим хуудас, санал асуулгын хуудас ашиглах, ярилцлага зохион байгуулах болон дэвшилтэт технологийн бусад хэлбэр ашиглах замаар явуулна;
- 12.1.3. аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд, олон нийтэд танилцуулна;
- 12.1.4. аймаг, нийслэлийн Засаг дарга аймаг, нийслэлийн чиг үүрэгт хамаарах асуудлын урьдчилсан жагсаалтыг олон нийтээр хэлэлцүүлж, баталгаажуулах үйл ажиллагааг сум, дүүргийн нэгдсэн жагсаалт боловсруулах үйл ажиллагаатай хамтад нь явуулж болно;
- 12.1.5. аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-д заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гарган тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд төсвийн төслийн хамт өргөн мэдүүлнэ.

Арга хэлбэр буюу загвар:

"Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-д (Сангийн сайдын 2012.11.19-ны 244-р тушаалаар баталсан) заасан загвар, маягтуудын дагуу ил тод, нээлттэй болгоно.

Төсвийн баримт бичиг ба үйл явц	<ol style="list-style-type: none">1. Баримт бичгийн албан ёсны нэр, дугаар, огноо, хэмжээ2. Иргэд, олон нийт тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас, хэрхэн олж үзэх буюу авах боломжтой байсан тухай тайлбар (Баримтаар нотолж хавсаргана)3. Судлаач өөрөө тухайн баримт бичгийг хэзээ, хаанаас буюу хэнээс хэрхэн олж авсан тухай тайлбар4. Хавсаргасан мэдээлэл, баримт бичиг, нотлох баримтын нэр буюу жагсаалт
<p>Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, 2013 оны 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авсан байдал [2013 оны 9 дүгээр сарын 30-ны дотор]</p>	
<p>Аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтээс хамгийн их санал авсан хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дарааллыг эрэмбэлэн, иргэд, олон нийтэд танилцуулсан байдал [2013 оны 10, 11 дүгээр саруудад]</p>	
<p>Аймаг, нийслэлийн Засаг дарга олон нийтийн дунд нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулснаар нийтийн эрх ашигт нийцсэн, эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан нэгдсэн жагсаалтыг гарган тухайн шатны Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд 2014 оны төсвийн төслийн хамт өргөн мэдүүлэхдээ иргэд, олон нийтэд танилцуулсан байдал [2013 оны 11 дүгээр сарын 25-ны дотор]</p>	

Аймаг, нийслэл, сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2014 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар санал асуулга явуулж, жагсаалт боловсруулан өргөн барих үйл явц, үр дүн [Аймаг, нийслэлд шилжүүлсэн санал]

Ил тод болгох тухай Монгол Улсын хууль, дүрэм журмын заалтууд

“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”:

- 12.2.1. баг, хорооны Засаг дарга орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга хэмжээ, тэдгээрийг хэрэгжүүлэх дараалал, арга замын талаар баг хорооны иргэдийн дунд олон нийтийн нээлттэй санал асуулгыг явуулна;
- 12.2.1. 6/ саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтыг ашиглах ба маягтыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ [Энэ нь 3 дугаар сарын 31-ний дотор гэсэн үг юм];
- 12.2.1. в/ энэ журмын 12.2.1.а-д заасан хэлбэрээр санал асуулгыг явуулахдаа, жил бүрийн 2 дугаар улирлын эхний 30 өдөрт багтаан санал авна [Энэ нь 4 дүгээр сарын 30-ны дотор гэсэн үг юм];
- 12.2.3. баг, хорооны Засаг дарга Иргэдийн Нийтийн Хурал хуралдахаас 2 долоо хоногийн өмнө тухайн сум, дүүрэгт хуваарилагдах хөрөнгийн урьдчилсан тооцоо, иргэдээс гаргасан саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн тухайн сум, дүүрэг, баг хороонд хэрэгжүүлэх шаардлагатай хөгжлийн бодлого чиглэлтэй уялдсан төслүүдийн мэдээлэл, өмнөх жилүүдэд хэрэгжсэн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаарх товч мэдээллийг баг, хороодод байршуулсан байна [Энэ нь 6 дугаар сарын 15-наас өмнө гэсэн үг юм];
- 12.2.4. баг, хорооны Засаг дарга иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, сум, дүүргийн Засаг даргаас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдсан төслийн санал болон Иргэдийн Нийтийн Хурал дээр гарсан саналыг тухайн Иргэдийн Нийтийн Хуралд хэлэлцүүлж, тус хурлаас эрэмбэлэгдэн гарсан төслийн жагсаалтыг сум, дүүргийн Засаг даргад 2 дугаар улиралд багтаан хүргүүлнэ [Энэ нь 6 дугаар сарын 30-ны дотор гэсэн үг юм];
<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Байгууллага /хувь хүн /</th> <th>Хандивын дүн</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td>Архангай аймаг нутгийн зөвлөл</td><td>340.0</td></tr> <tr><td>2</td><td>Мобиком</td><td>2,76</td></tr> <tr><td>3</td><td>Говь цогцолбор</td><td>30.0</td></tr> <tr><td>4</td><td>Макс групп</td><td>50.0</td></tr> <tr><td>5</td><td>Мобиком</td><td>2,76</td></tr> <tr><td>6</td><td>Хас банк</td><td>1,0</td></tr> <tr><td>7</td><td>ХААН банк</td><td>3,0</td></tr> <tr><td>8</td><td>Бэрэн групп ХХК</td><td>50,0</td></tr> <tr><td>9</td><td>Цомбо ХХК</td><td>4,0</td></tr> <tr><td>10</td><td>Нутгийн зөвлөл /өлзийт/</td><td>1,0</td></tr> <tr><td>11</td><td>Нутгийн зөвлөл /Дархан Уул/</td><td>5,0</td></tr> <tr><td>12</td><td>Нутгийн зөвлөл /Батцэнгэл сум/</td><td>5,35</td></tr> <tr><td>13</td><td>Р.Болдбаатар /Монгол өртөө групп/</td><td>10,0</td></tr> <tr><td>14</td><td>С.Одонтуяа /УИХ гишүүн/</td><td>5,0</td></tr> <tr><td>15</td><td>Б.Базар-Адьаа /Төвшрүүлэх/</td><td>1,0</td></tr> <tr><td>16</td><td>А.Эрдэнэцогт /Төвшрүүлэх/</td><td>2,0</td></tr> <tr><td>17</td><td>Т.Наранцагцаг /УБ хот/</td><td>1,0</td></tr> <tr><td>18</td><td>Д.Нэргүй /УБ /</td><td>5,0</td></tr> <tr><td>19</td><td>Ж.Баяраа</td><td>33,0</td></tr> <tr><td>20</td><td>Н.Пуржавжав / УБ /</td><td>30,0</td></tr> <tr><td>21</td><td>Амартүвшин, Батжаргал / Батцэнгэл сум/</td><td>2,0</td></tr> <tr><td>22</td><td>Бат-Эрдэнэ /Мулут сум/</td><td>10,0</td></tr> <tr><td colspan="2">Нийт дүн /сая төг/</td><td>593,9</td></tr> </tbody> </table>		№	Байгууллага /хувь хүн /	Хандивын дүн	1	Архангай аймаг нутгийн зөвлөл	340.0	2	Мобиком	2,76	3	Говь цогцолбор	30.0	4	Макс групп	50.0	5	Мобиком	2,76	6	Хас банк	1,0	7	ХААН банк	3,0	8	Бэрэн групп ХХК	50,0	9	Цомбо ХХК	4,0	10	Нутгийн зөвлөл /өлзийт/	1,0	11	Нутгийн зөвлөл /Дархан Уул/	5,0	12	Нутгийн зөвлөл /Батцэнгэл сум/	5,35	13	Р.Болдбаатар /Монгол өртөө групп/	10,0	14	С.Одонтуяа /УИХ гишүүн/	5,0	15	Б.Базар-Адьаа /Төвшрүүлэх/	1,0	16	А.Эрдэнэцогт /Төвшрүүлэх/	2,0	17	Т.Наранцагцаг /УБ хот/	1,0	18	Д.Нэргүй /УБ /	5,0	19	Ж.Баяраа	33,0	20	Н.Пуржавжав / УБ /	30,0	21	Амартүвшин, Батжаргал / Батцэнгэл сум/	2,0	22	Бат-Эрдэнэ /Мулут сум/	10,0	Нийт дүн /сая төг/		593,9	<table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Зарцуулалт</th> <th>Шагмал дүн</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td>Бөхийн бай</td><td>31,9</td></tr> <tr><td>2</td><td>Морины бай</td><td>158,6</td></tr> <tr><td>3</td><td>Сур харваан бай</td><td>13,0</td></tr> <tr><td>4</td><td>Шагайн харваан бай</td><td>7,0</td></tr> <tr><td>5</td><td>Морины нөмрөг</td><td>6,0</td></tr> <tr><td>6</td><td>Театр морин хуурын сургалт</td><td>10,0</td></tr> <tr><td>7</td><td>Зураач урчуудын уран бүтээлийн үзэсгэлэн</td><td>5,0</td></tr> <tr><td>8</td><td>90 морин хуурч , 90 уртын дуучин хувцас иж бүрэн</td><td>98,0</td></tr> <tr><td>9</td><td>Уран бүтээлчдийн хувцас</td><td>77,2</td></tr> <tr><td>10</td><td>90 жилийн ойн хөтөлбөр /сэтгүүл/</td><td>5,5</td></tr> <tr><td>11</td><td>Хүндэтгэлийн концерт , баярын хурал</td><td>30,0</td></tr> <tr><td>12</td><td>Уран бүтээлчдийн хоолны зардал /500 хүн/</td><td>25,0</td></tr> <tr><td>13</td><td>Гимнастийн хүүхдүүдийн хувцас хэрэгсэл</td><td>7,1</td></tr> <tr><td>14</td><td>Техник хэрэгсэлийн аппаратур УБ хот</td><td>40,0</td></tr> <tr><td>15</td><td>Урилгаар оролцсон уран бүтээлчдийн цалин</td><td>47,3</td></tr> <tr><td>16</td><td>90 жилийн ойн хэвлэл мэдээлэл ТВ -д</td><td>10,0</td></tr> <tr><td>17</td><td>Театрын тайзны засал чимэглэл</td><td>3,5</td></tr> <tr><td>18</td><td>Зочид төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулсан баазууд</td><td>18,8</td></tr> <tr><td colspan="2">ЗАРЦУУЛАЛТ ДҮН /сая төг/</td><td>593,9</td></tr> </tbody> </table>		№	Зарцуулалт	Шагмал дүн	1	Бөхийн бай	31,9	2	Морины бай	158,6	3	Сур харваан бай	13,0	4	Шагайн харваан бай	7,0	5	Морины нөмрөг	6,0	6	Театр морин хуурын сургалт	10,0	7	Зураач урчуудын уран бүтээлийн үзэсгэлэн	5,0	8	90 морин хуурч , 90 уртын дуучин хувцас иж бүрэн	98,0	9	Уран бүтээлчдийн хувцас	77,2	10	90 жилийн ойн хөтөлбөр /сэтгүүл/	5,5	11	Хүндэтгэлийн концерт , баярын хурал	30,0	12	Уран бүтээлчдийн хоолны зардал /500 хүн/	25,0	13	Гимнастийн хүүхдүүдийн хувцас хэрэгсэл	7,1	14	Техник хэрэгсэлийн аппаратур УБ хот	40,0	15	Урилгаар оролцсон уран бүтээлчдийн цалин	47,3	16	90 жилийн ойн хэвлэл мэдээлэл ТВ -д	10,0	17	Театрын тайзны засал чимэглэл	3,5	18	Зочид төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулсан баазууд	18,8	ЗАРЦУУЛАЛТ ДҮН /сая төг/		593,9	<p>АЙМАГ ӨӨРИЙН ХӨРӨНГӨӨР 90 ЖИЛИЙН ОЙГ ТЭМДЭГЛЭН ӨНГӨРҮҮЛЭХЭД ГАРГАСАН ЗАРДЛЫН ТООЦОО</p> <table border="1"> <thead> <tr> <th>№</th> <th>Зарцуулалт</th> <th>Үнэ</th> </tr> </thead> <tbody> <tr><td>1</td><td>90 жилийн ойн медаль энгэрийн тэмдэг , мөндчилгээ</td><td>94,7</td></tr> <tr><td>2</td><td>Арын сайхан Хангай альбом</td><td>12,1</td></tr> <tr><td>3</td><td>Арын сайхан Хангайд алдартан олон</td><td>7,5</td></tr> <tr><td>4</td><td>Архангайгаас төрсөн эрдэмтэд</td><td>7,0</td></tr> <tr><td>5</td><td>Архангайн Атлас</td><td>48,0</td></tr> <tr><td>6</td><td>Домгийн цэнхэр Хангай</td><td>2,6</td></tr> <tr><td>7</td><td>Үндэсний их баяр наадмын концертын хувцас</td><td>49,0</td></tr> <tr><td colspan="2">Нийт дүн /сая төг/</td><td>221,3</td></tr> </tbody> </table>	№	Зарцуулалт	Үнэ	1	90 жилийн ойн медаль энгэрийн тэмдэг , мөндчилгээ	94,7	2	Арын сайхан Хангай альбом	12,1	3	Арын сайхан Хангайд алдартан олон	7,5	4	Архангайгаас төрсөн эрдэмтэд	7,0	5	Архангайн Атлас	48,0	6	Домгийн цэнхэр Хангай	2,6	7	Үндэсний их баяр наадмын концертын хувцас	49,0	Нийт дүн /сая төг/		221,3
№	Байгууллага /хувь хүн /	Хандивын дүн																																																																																																																																																																	
1	Архангай аймаг нутгийн зөвлөл	340.0																																																																																																																																																																	
2	Мобиком	2,76																																																																																																																																																																	
3	Говь цогцолбор	30.0																																																																																																																																																																	
4	Макс групп	50.0																																																																																																																																																																	
5	Мобиком	2,76																																																																																																																																																																	
6	Хас банк	1,0																																																																																																																																																																	
7	ХААН банк	3,0																																																																																																																																																																	
8	Бэрэн групп ХХК	50,0																																																																																																																																																																	
9	Цомбо ХХК	4,0																																																																																																																																																																	
10	Нутгийн зөвлөл /өлзийт/	1,0																																																																																																																																																																	
11	Нутгийн зөвлөл /Дархан Уул/	5,0																																																																																																																																																																	
12	Нутгийн зөвлөл /Батцэнгэл сум/	5,35																																																																																																																																																																	
13	Р.Болдбаатар /Монгол өртөө групп/	10,0																																																																																																																																																																	
14	С.Одонтуяа /УИХ гишүүн/	5,0																																																																																																																																																																	
15	Б.Базар-Адьаа /Төвшрүүлэх/	1,0																																																																																																																																																																	
16	А.Эрдэнэцогт /Төвшрүүлэх/	2,0																																																																																																																																																																	
17	Т.Наранцагцаг /УБ хот/	1,0																																																																																																																																																																	
18	Д.Нэргүй /УБ /	5,0																																																																																																																																																																	
19	Ж.Баяраа	33,0																																																																																																																																																																	
20	Н.Пуржавжав / УБ /	30,0																																																																																																																																																																	
21	Амартүвшин, Батжаргал / Батцэнгэл сум/	2,0																																																																																																																																																																	
22	Бат-Эрдэнэ /Мулут сум/	10,0																																																																																																																																																																	
Нийт дүн /сая төг/		593,9																																																																																																																																																																	
№	Зарцуулалт	Шагмал дүн																																																																																																																																																																	
1	Бөхийн бай	31,9																																																																																																																																																																	
2	Морины бай	158,6																																																																																																																																																																	
3	Сур харваан бай	13,0																																																																																																																																																																	
4	Шагайн харваан бай	7,0																																																																																																																																																																	
5	Морины нөмрөг	6,0																																																																																																																																																																	
6	Театр морин хуурын сургалт	10,0																																																																																																																																																																	
7	Зураач урчуудын уран бүтээлийн үзэсгэлэн	5,0																																																																																																																																																																	
8	90 морин хуурч , 90 уртын дуучин хувцас иж бүрэн	98,0																																																																																																																																																																	
9	Уран бүтээлчдийн хувцас	77,2																																																																																																																																																																	
10	90 жилийн ойн хөтөлбөр /сэтгүүл/	5,5																																																																																																																																																																	
11	Хүндэтгэлийн концерт , баярын хурал	30,0																																																																																																																																																																	
12	Уран бүтээлчдийн хоолны зардал /500 хүн/	25,0																																																																																																																																																																	
13	Гимнастийн хүүхдүүдийн хувцас хэрэгсэл	7,1																																																																																																																																																																	
14	Техник хэрэгсэлийн аппаратур УБ хот	40,0																																																																																																																																																																	
15	Урилгаар оролцсон уран бүтээлчдийн цалин	47,3																																																																																																																																																																	
16	90 жилийн ойн хэвлэл мэдээлэл ТВ -д	10,0																																																																																																																																																																	
17	Театрын тайзны засал чимэглэл	3,5																																																																																																																																																																	
18	Зочид төлөөлөгчдийг хүлээн авч байрлуулсан баазууд	18,8																																																																																																																																																																	
ЗАРЦУУЛАЛТ ДҮН /сая төг/		593,9																																																																																																																																																																	
№	Зарцуулалт	Үнэ																																																																																																																																																																	
1	90 жилийн ойн медаль энгэрийн тэмдэг , мөндчилгээ	94,7																																																																																																																																																																	
2	Арын сайхан Хангай альбом	12,1																																																																																																																																																																	
3	Арын сайхан Хангайд алдартан олон	7,5																																																																																																																																																																	
4	Архангайгаас төрсөн эрдэмтэд	7,0																																																																																																																																																																	
5	Архангайн Атлас	48,0																																																																																																																																																																	
6	Домгийн цэнхэр Хангай	2,6																																																																																																																																																																	
7	Үндэсний их баяр наадмын концертын хувцас	49,0																																																																																																																																																																	
Нийт дүн /сая төг/		221,3																																																																																																																																																																	

Хүүхдийн шагнал

№	Шагналын төрөл	Хүүхдийн тоо	Олох шагнал /мөн.төг/	Нийт шагнал /мөн.төг/
1	Морь унаж айрагдсан хүүхдийн шагнал	45	50,0	2250,0
2	Морь унаж айрагдсан хүүхдийн шагнал	700	21,0	14700,0
Нийт дүн		530	71,0	16950,0

Үндэсний сурьн харвааны байр, шагналын тооцоо

№	Төрөл	Байр	Шагналын хэмжээ	Дүн
1	эрэгтэй	1-р байр	2000,0	5900,0
2		2-р байр	1500,0	
3		3-р байр	1000,0	
4		4-р байр	800,0	
5	эмэгтэй	5-р байр	600,0	2000,0
6		1-р байр	2000,0	
7		2-р байр	1500,0	
8		3-р байр	1000,0	
9	Хөвгүүд	4-р байр	800,0	300,0
10		5-р байр	600,0	
11		1-р байр	300,0	
12		2-р байр	200,0	
13	Охид	3-р байр	100,0	300,0
14		1-р байр	300,0	
15		2-р байр	200,0	
16		3-р байр	100,0	
Шагналын нийт дүн				

Уран бүтээлчдийн хоолны зардал

№	Зардлын нэр	Хүний тоо	Хонгийн зардал	Нийт зардал
1	Морин хуурчид	90	10 хонго	50
2	Уртын дуучид	90	10 хонго	50
3	Гимнастийн хүүхдүүд	150	10 хонго	50
4	Утлаач хөгжимчид	30	10 хонго	50
5	Найруулагч, балч нар	10	10 хонго	50
6	Уран бүтээлчид болох туслах ажилчид	130	10 хонго	50
Дүн		500		

Цуваа харваа

№	Цуваа харваа	Төрөл	Тоо	Шагнал
12	Цуваа харваа	2-р байр	1	80,0
13	Цуваа харваа	3-р байр	1	60,0
14	Цуваа харваа	4-р байр	1	30,0
15	Цуваа харваа	5-р байр	1	20,0
16	Цуваа харваа	1-р байр	1	150,0
17	Цуваа харваа	2-р байр	1	100,0
18	Цуваа харваа	3-р байр	1	80,0
19	Цуваа харваа	4-р байр	1	60,0
20	Цуваа харваа	5-р байр	1	50,0
21	Шүлчийн хөлс	2	50,0	100,0
22	Асар майхан барих, хөлслөх	1	500,0	500,0
23	Бусад			73,6
Дүн				7000,0

Баяр наадмын нээлтэнд оролцох гимнастийн хүүхдүүдийн зардал

Баяр наадмын бай шагналын зардлын тооцоо

№	Зардлын нэр	Нийт зардал
1	Бөхийн бай шагнал	31880,0
2	Морины бай шагнал	155280,0
3	Сур харвааны шагнал	13000,0
4	Шагайн харваан тооцоо	7000,0
Нийт зардлын дүн		219470,0

Бөхийн бай шагналын тооцоо

Даваа	Бөхийн тоо	Шагналын хэмжээ /мөн.төг/	Нийт шагнал /мөн.төг/
1	128	10,0	1280,0
2	64	20,0	1280,0
3	32	40,0	1280,0
4	16	80,0	1280,0
5	8	160,0	1280,0
6	4	320,0	1280,0
7	2	1500,0	3000,0
8	1	3000,0	3000,0
9	1	10000,0	10000,0
Нийт			23680,0

Азарга

№	Байр	Тоо	Нэг моринд олох шагнал /мөн.төг/	Бүгд /мөн.төг/
1	Түрүү	1	10000,0	10000,0
2	Аман хууц	1	5000,0	5000,0
3	Айргийн гурав	1	3000,0	3000,0
4	Айргийн дөрөв	1	2000,0	2000,0
5	Айргийн тав	1	1000,0	1000,0
6	6-д давхцсан морь	1	500,0	500,0
7	7-д давхцсан морь	1	400,0	400,0
8	8-д давхцсан морь	1	300,0	300,0
9	9-д давхцсан морь	1	200,0	200,0
10	10-22 д давхцсан морь	13	50,0	650,0
11	23-90 д давхцсан морь	68	40,0	2720,0
Нийт дүн				25770,0

Их нас

№	Байр	Тоо	Нэг моринд олох шагнал /мөн.төг/	Бүгд /мөн.төг/
1	Түрүү	1	10000,0	10000,0

3.1 Дорноговь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2013 оны 4 дүгээр улирлын гүйцэтгэл

Орон нутгийн төсвийн бүтцэд Засаг даргын нөөц хөрөнгө гэсэн зүйл байдаг. Энэхүү хөрөнгийг урьдчилан төлөвлөх, нарийвчлан тооцоолж тусгах боломжгүй, цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэх зориулалттай юм. Ийм учраас нийт дүнгээр, задаргаагүй батлагддаг төдийгүй зарцуулалтыг бараг бүх тохиолдолд тайлагнахгүй явж иржээ. Харин «Орон нутгийн төсвийн ил тод байдал -2013» судалгааны явцад зарим мэдээлэл нээлттэй болсон юм. Тухайлбал, Говьсүмбэр аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2013 оны 3 дугаар улирлын тайлан, Дорнод аймгийн Засаг даргын нөөцийн сангийн 2014 оны төлөвлөгөөны төсөл зэргийг дурдаж болно.

Дорноговь аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн 2013 оны 4 дүгээр улирлын гүйцэтгэл нэлээд дэлгэрэнгүй бөгөөд 138 удаагийн зарцуулалт тус бүрийг нэгбүрчлэн тайлагнажээ. Хүнд өвчин, гачигдлын үед буцалтгүй тусламж олгосон тохиолдол нэлээд байгаа боловч нэг удаагийн тусламжийн хэмжээ ихэнхдээ 100.000 төгрөгөөс хэтрэхгүй байна. Багийн Засаг дарга нарын тэтгэмжид 69 сая төгрөг олгосон нь орон нутгийн сонгуулийн дараа улс төрийн халаа сэлгээгээр халагдсан хүмүүст олгосон мөнгө байх магадлалтай. Барилга, хот байгуулалтын яамны төлөөлөгчдийг хүлээн авах зардалд 8.6 сая төгрөг төсөвлөснөөс 4.7 сая төгрөг зарцуулжээ. Ер нь төвөөс ирсэн сайд дарга, албан тушаалтнуудыг нутагтаа хүлээн авч зочлохдоо төсвөөс энэ мэт зардал гаргадаг нь хаа сайгүй түгээмэл үзэгдэл хэвээр байна.

№	Захирамжийн		Зориулалт	Төсөв	Мөнгөн хөрөнгийн зарлага	Жинхэнэ зарлага
	Он сар өдөр	№				
15	2013.02.20	A/78	Батлан хамгаалахын хуулийн шалгалт	2171000.00	2171000.00	2171000.00
16	2013.02.21	A/85	Хутагтын хойд дүр тодруулах	20746600.00	20746600.00	20746600.00
17	2013.02.22	A/87	Өмгөөлөгчийн хөлс	4900000.00	3430000.00	3430000.00
18	2013.02.22	A/91	Хутагтын хурд - 2013	347600.00	305900.00	305900.00
35	2013.03.29	A/174	Шагнал	753600.00	753600.00	760200.00
36	2013.03.29	A/175	Дархан муумянган хошууныхан	1372000.00	1372000.00	1372000.00
37	2013.04.04	A/187	Хэнтий аймгийн ЗДТГ-ынханд хүндэтгэл үзүүлэх	1677600.00	1645100.00	1645100.00
38	2013.04.04	A/189	Шагнал /ОБХ, Хатанбулаг сумын Засаг дарга/	155400.00	150000.00	159900.00
39	2013.04.04	A/190	Мал эмнэлгийн мэргэжилтнүүдийн сургалт	444500.00	401500.00	401500.00
40	2013.04.09	A/197	Хаврын баяр цэнгээнт бужгийн тэмцээн	750000.00	750000.00	750000.00
41	2013.04.10	A/204	ХАХНХ-ын сайд С.Эрдэнэ	891000.00	886500.00	886500.00
42	2013.04.11	A/211	Говийн ноён хутагт - 210 ' эрдэм шинжилгээний бага хурал	5280000.00	4099350.00	4099350.00
62	2013.05.29	A/318	Буцалтгүй тусламж /Мандах сумын иргэн О.Мөнхболдын охины эмчилгээнд/	100000.00	100000.00	100000.00
63	2013.05.29	A/319	Буцалтгүй тусламж /Сайншанд сумын 1-р багийн иргэн Я.Төмөрийн эмчилгээнд/	100000.00	100000.00	100000.00
64	2013.05.29	A/320	Үлэмжийн чанар яруу найргийн наадам	4625800.00	4625300.00	4625300.00
65	2013.05.29	A/321	Уртын дууны уралдаан	2775000.00	2775000.00	2775000.00
66	2013.06.07	A/334	Шагнал /Б.Дашаргал/	76800.00	69000.00	69000.00
67	2013.06.10	A/336	Зууны мэдлээ сонины ажилтнуудад хүндэтгэл үзүүлэх	1101400.00	1099200.00	1099200.00
84	2013.07.09	A/400	Шагайн харвааны тэмцээн оролцогчдод дэмжлэг	2000000.00	1545100.00	1545100.00
85	2013.07.16	A/414	Шагнал /Хажуу-улааны уурхайн 40 жил/	307200.00	307200.00	320400.00
86	2013.07.16	A/418	Нийтийн тээврийн нөхөн олговор	4440000.00	4213000.00	4213000.00
87	2013.07.17	A/426	Дээд эрүүл мэндийн үзмэрийн газар байгуулахад 3 гэр худалдан авах	5000000.00	5000000.00	5000000.00
88	2013.07.19	A/442	Багийн Засаг дарга нарын тэтгэмж	69321312.00	69321120.00	69321120.00
89	2013.07.17	A/429	Равжаа судлалын тойм ном худалдан авахад	680000.00	680000.00	680000.00
125	2013.10.08	A/597	Барилга хот байгуулалтын яамны төлөөлөгчид	8614400.00	4766400.00	4766400.00
126	2013.10.08	A/599	Эрүүл мэндийн дэд сайд Д.Амарсанаа	249700.00	249700.00	249700.00
127	2013.10.14	A/604	Японд туршлага судлах багийн зардал	6270500.00	6269900.00	6269900.00

3.2 Дорнод аймгийн Засаг даргын 2014 оны нөөцийн сангийн төлөвлөгөөний төсөл

Аймгийн ИТХ-ын хуралдаанд оруулсан Засаг даргын 2014 оны нөөц хөрөнгийг зарцуулах төлөвлөгөөний төслийг Дорнод аймгаас ирүүлжээ. Нөөц сангийн нийт хэмжээ 670 сая төгрөг, үүнээс 336.5 сая төгрөгийг хэрхэн зарцуулахыг урьдчилан төлөвлөж, 343.5 сая төгрөгийг задаргаагүй үлдээсэн харагдаж байна.

Уг төлөвлөгөөг ИТХ-ын хуралдаанаар нэгбүрчлэн хэлэлцсэн эсэх нь тодорхойгүй, боловч ийм мэдээлэл нээлттэй байх нь чухал юм. «Олон нийтэд түшиглэсэн хүүхэд, эмэгтэйчүүдийн хамгааллын төв»-ийг 42 сая төгрөгөөр дэмжихээр тусгасныг олон нийт дэмжих нь гарцаагүй. Харин олон нийтийн байгууллагуудаас зөвхөн нэгийг буюу Монголын Залуучуудын Холбоог сонгон авч үйл ажиллагаанд нь 10 сая төгрөгийг олгоход төлөөлөгчид болон иргэд нэлээд шүүмжлэлтэй хандсан байх магадлалтай.

төсөл

ДОРНОД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН 2014 ОНЫ НӨӨЦИЙН САН

2013.11.25

/мян.төг/

№	Зардлын нэр төрөл	төсөв
Орон нутгийн төсвийн нөөц хөрөнгийн зардал		670,000.00
1	Цахим засаглал хөтөлбөрийн хүрээнд	1,000.00
2	Багийн хөгжлийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд шилдэг баг шалгаруулах	3,500.00
3	Агентлаг сумдын Засаг даргын тамгын газрын үйл ажиллагаанд хяналт шинэжилгээ	10,000.00
4	Уламжлалт "Цагаан сар угтах баяр"	15,000.00
5	"Зүүн бүсийн түншлэл-2014" арга хэмжээ зохион байгуулах	20,000.00
6	Дэлхийн шилдэг сургууль болон хөрш зэргэлдээ улс орны сургуульд оюутан сургах	2,000.00
7	ОХУ, БНХАУ-ын хил залгаа хотуудын зохион байгуулж буй аялал жуулчлал, ОУ-ын үзэсгэлэн худалдаанд оролцох	5,000.00
8	Батлан хамгаалах салбарын хууль тогтоомж хэрэгжилт	5,000.00
9	Халхголын байлдааны ялалтын 75 жилийн ойн баярыг тэмдэглэн өнгөрүүлэх	30,000.00
10	Аймгийн ЗД нэрэмжит гамшигаас хамгаалах бэлтгэл сургалт 7 сум	3,000.00
11	ОХУ, БНХАУ-ын ӨМӨЗО-ны галаас сэргийлэх удирдах газруудтай хамтран ажиллах	5,000.00
12	Төрийн сангийн дотоод аудитын бүтцийг бий болгож, дотоод хяналтыг сайжруулна	4,000.00
13	Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийн тусламж үйлчилгээ "Хөдөлгөөнт эмнэлэг"	10,000.00
14	Хавдрын өвчлөлийг улсын дундаж түвшинд хүргэх бодлого боловсруулах	5,000.00
15	ОУ, улсын чанартай олимпиадад амжилттай оролцсон багш нарын урамшил	10,000.00
16	Аймгийн соёл спорт аялал жуулчлалын анхдугаар чуулган	8,000.00
17	Хаврын уянга спорт бүжгийн уралдааныг зохион байгуулах	5,000.00
18	Ном унших, ном уншуулах арга зүйг түгээн дэлгэрүүлэх	1,000.00
19	Алслагдсан баг сум байгууллагад явуулын номын санг ажиллуулах	1,000.00
20	Мал тооллогын зардал	8,000.00
21	Алтаргана-2014 наадамд оролцох	15,000.00
22	Миний тоонт, Алтандерөө наадмуудад зохион байгуулалттай оролцох	10,000.00
23	Хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйг сайжруулахад	5,000.00
24	ОУ-ын аялал жуулчлалын өдөрт Монголиа АйТи М	5,000.00
25	Хүүхдийн нэгдсэн чуулган	1,500.00
26	Ахмад настны урлаг спортын наадамд дэмжлэг	5,000.00
27	Зүүн бүсийн Яргуй хүүхдийн урлагийн наадам зохион байгуулах	1,000.00
28	Зүүн бүсийн хүүхэд залуучуудын урлаг спорт наадам	17,500.00
29	Хөдөө аж ахуйг хөгжүүлэх арга хэмжээний зардалд	15,000.00
30	ЖДҮ эрхлэгч хоршоологчдын чуулга уулзалт	3,000.00
31	Монголын Залуучуудын холбооны үйл ажиллагаанд дэмжлэг	10,000.00
32	БЗДХӨ-ийг эрт илрүүлэх, тархалтыг бууруулах зорилгоор эрсдэлтэй бүлгийн хүн амыг үзлэг оношлогоонд хамруулах	45,000.00
33	"Олон нийтд түшиглэсэн хүүхэд эмэгтэйчүүдийн хамгааллын төв"-д дэмжлэг	42,000.00
34	Нөөц хөрөнгө	343,500.00

4. Увс аймгийн «Шилэн халаас» хөтөлбөр

2013 оны Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа төсвийн ил тод байдлыг хангахад чиглэсэн «Шилэн данс», «Шилэн тендер» зэрэг санаачилгууд гарч ийм хуулийн үзэл баримтлал болон хуулийн төслийг боловсруулан хэлэлцэж байгаа билээ. Түүнээс арай өмнөхөн буюу 2013 оны 2 дугаар сард Увс аймгийн Засаг дарга Д.Цэндсүрэн захирамж гаргаж «Шилэн халаас» гэсэн арай өөр бөгөөд содон нэртэй хөтөлбөр баталжээ.

Орон нутагт төсвийн ил тод байдлыг тусгайлан зохицуулахыг оролдсон эрх зүйн баримт бичиг одоогоор ховор байна. Тэр тусмаа Өмнөговь аймгийн Засаг даргын албан даалгавар, Ховд аймгийн Засаг даргын захирамж зэргийг эс тооцвол ийм дэлгэрэнгүй хөтөлбөр өөр байхгүй байна.

«Шилэн халаас» хөтөлбөрт 2012 онд Монгол Улсын Засгийн газраас баталсан «Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам»-ын заалтуудаас аймаг, сумын түвшинд тохирохыг эшлэн авч оруулснаас гадна сум хөгжүүлэх сан, халамжийн сан, нийгмийн даатгалын сангууд, сумдад үйл ажиллагаа явуулж байгаа сан, гадаад дотоодын төсөл хөтөлбөр, хандив тусламжийн эх үүсвэр, зарцуулалтыг бусад төсвийн нэгэн адил сар бүрийн 5-ны дотор мэдээлж байхаар нэмж тусгажээ.

Гэсэн хэдий ч энэ нь зарчим, чиглэлүүд зонхилсон нэлээд ерөнхий баримт бичиг болох нь харагдаж байна. Хамгийн гол нь орон нутгийн төсөв, санхүүгийн мэдээллийн бүтэц, задаргаа, ялангуяа олон нийтэд хүргэх арга хэлбэрийг огт заагаагүй буюу орхигдуулжээ. Харин худалдан авах ажиллагааны талаар бас л ерөнхий заалтууд орсон хэдий ч www.uvstender.mn хаягтай, бусад аймагт байхгүй сайн цахим хуудас ажиллуулж байгааг хэлэх хэрэгтэй.

Аймгийн Засаг даргын 2013 оны 02 сарын 21-ны өдрийн
А/96 тоот захирамжийн хавсралт

**Төсөв, санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангах
"ШИЛЭН ХАЛААС" хөтөлбөр**

Нэг. Хөтөлбөр боловсруулах үндэслэл

Монгол улсын Төсвийн тухай хууль /2011.12.23/, Засгийн газрын тогтоол "Төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангахад дагаж мөрдөх журам" /2012.01.18 №17/, "Ил тод байдлыг илтгэх шалгуур үзүүлэлт батлах тухай" /2009.05.14 № 143/, Увс аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах нь энэхүү хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх үндэслэл болно.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, баримтлах зарчим, зорилт

2.1. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь бүх шатны төсвийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд /цаашид "төсвийн байгууллага" гэх/-ийн батлагдсан жилийн төсөв, түүний гүйцэтгэлийг олон нийтэд нээлттэй болгох, орон нутгийн төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад иргэд, олон нийтийн хяналт, оролцоог хангаж, төсөв, санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангахад оршино.

2.2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.

2.2.1. Төсөв, санхүүгийн ил тод байдлыг эрхэмлэх

2.2.2. Төсөв, санхүүгийн үр ашигтай байдлыг эрхэмлэх

2.2.3. Төсвийн бүрдүүлэлт болон зарцуулалтад иргэд, олон нийтийн хяналт, оролцоог хангах

2.2.4. Төсвийн тухай мэдээллийг тогтмол хугацаанд, тогтоосон стандартын дагуу үнэн зөв, ил тод байдлаар олон нийтэд хүргэх

2.2.5. Төсөв, санхүүгийн тухай мэдээлэл нь иргэд, олон нийтэд нээлттэй байх бүхий л боломжит арга хэрэгслээр хангагдсан байх

2.3. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэхийн тулд дараах зорилт дэвшүүлж байна.

2.3.1. Төсөв төлөвлөх, батлах үйл ажиллагааг нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх

2.3.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нээлттэй, ил тод байдлыг хангах

2.3.3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах

2.3.4. Халамжийн сангийн санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангах

2.3.5. Нийгмийн даатгалын сангуудын санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангах

2.3.6. Сумдад үйл ажиллагаа явуулж буй бусад сангуудын санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангах

2.3.7. Бусад гадаад дотоод төсөл, арга хэмжээ, хандив, тусламжаар хийгдсэн хөрөнгө оруулалт, үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах

2.3.8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах

2.3.9. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах

2.3.10. Иргэний нийгмийн танхимаар иргэд, байгууллагуудад төсөв, санхүүгийн хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг бий болгох

- 2.3.11. Төсвийн тухай болон холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан журмын хэрэгжилтийг хангах

Гурав. Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

3.1. Төсөв хэлэлцэх, батлах үйл ажиллагааг нээлттэй байлгаж, төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тайлагналын мэдээллийг олон нийтэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар хүргэх зорилтын хүрээнд:

3.1.1. Төсвийн хэлэлцүүлгийг иргэний танхимтай хамтран зохион байгуулж, тогтмолжуулна.

3.1.2. Төсвийн хэлэлцүүлэгт төр, хувийн хэвшил, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудыг татан оролцуулж, тэдний санал, санаачлагыг төсвийн үйл ажиллагаанд тусгаж ажиллана.

3.1.3. Төсөв батлах үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй байлгана.

3.1.4. Тухайн жилийн төсвийг эрх бүхий байгууллагаас баталж, хүчин төгөлдөр болсны дараа дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ.

3.1.4.1. Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн багцын төсвийг 7 хоногийн дотор

3.1.4.2. Төсвийн байгууллага өөрийн төсвөө 10 хоногийн дотор

3.1.5. Төсвийн орлого, зарлагын гүйцэтгэлийн тайланг эрх бүхий этгээд дор дурдсан хугацаанд олон нийтэд мэдээлнэ.

3.1.5.1. Төсвийн байгууллага сар, улирлын тайланг хамт олныхоо дунд хэлэлцүүлж, дараа сарын 5-ны дотор

3.1.5.2. Төсвийн байгууллага хагас жилийн тайланг 7 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг 2 дугаар сарын 25-ны дотор

3.1.5.3. Төсвийн ерөнхийлөн захирагч хагас жилийн тайланг 8 дугаар сарын 15-ны дотор, жилийн тайланг 4 дүгээр сарын 25-ны дотор

3.1.5.4. Сумын төрийн сан хагас жилийн тайланг 7 дугаар сарын 25-ны дотор, жилийн тайланг 3 дугаар сарын 5-ны дотор

3.1.6. Төсвийн байгууллага өмнөх оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь аудитын дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор олон нийтэд мэдээлнэ.

3.1.7. Төсвийн байгууллагын батлагдсан жилийн төсөв, түүний гүйцэтгэл /цаашид "мэдээлэл" гэх/ дараах бүтэцтэй байна.

3.1.7.1. Эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв

Энэ мэдээлэл нь дараах байдлаар илэрхийлэгдсэн байна.

1. эрх бүхий байгууллагаас баталсан жилийн төсөв

2. орлого /үндсэн үйл ажиллагааны орлого, төсөвт байгууллагын өөрийн орлого/

3. урсгал зардал /үндсэн цалин, цалингийн нэмэгдэл, бараа үйлчилгээний зардал, татаас, шилжүүлэг/

4. хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалт

5. улсын төсөв болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлого, тэдгээрийн задаргаа

6. зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр /улсын төсөв, орон нутгийн төсөв, өөрийн орлого/

7. байгууллагын батлагдсан орон тоо

3.1.7.2. Үзүүлэх үйлчилгээ

Энэ мэдээлэл нь дараах байдлаар илэрхийлэгдсэн байна.

1. байгууллагын чиг үүргийн дагуу иргэдэд үзүүлэх үйлчилгээ, түүний төрөл

2. үйлчилгээний өртөг, зардал

3.1.7.3. Төсвийн гүйцэтгэл, түүнд хийсэн аудитын дүгнэлт

Энэ мэдээлэл нь дараах байдлаар илэрхийлэгдсэн байна.

1. төсвийн гүйцэтгэлийг батлагдсан төсвийн төлөвлөгөөтэй харьцуулсан харьцуулалт
2. төсөв хэмнэгдсэн болон хэтэрсэн бол холбогдох шалтгааныг тайлбарласан тайлбар
3. төсвийн хэмнэлтийг урамшуулалд зарцуулсан бол зориулалтыг заасан байх
4. хандив, тусламжийн хэмжээ, түүний зарцуулалт
5. хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж, сонгон шалгаруулсан бол шалгаруулалтын мэдээлэл /шалгарсан аж ахуйн нэгж, тоо хэмжээ, үнэ/
6. төсвийн хагас, бүтэн жилийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, тухайн тайланд тусгагдсан асуудлын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээ

3.2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний нээлттэй, ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:

- 3.2.1. Багуудад олон нийтийн нээлттэй санал асуулга явуулж, хэлэлцүүлэг зохион байгуулна.
- 3.2.2. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээ нэг бүрийг багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлнэ.
- 3.2.3. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээний талаар иргэд, олон нийтэд төсөв батлагдсанаас хойш 7 хоногийн дотор мэдээлнэ.
- 3.2.4. Хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалтын ажлын явц, үр дүнд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- 3.2.5. Хөрөнгө оруулалтыг хүлээн авах, эзэмшигчийг тогтоох, бүртгэлд тусгах зэрэг ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулна.

3.3. Сум хөгжүүлэх сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:

- 3.3.1. Сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн шалгаруулалтыг олон нийтэд нээлттэй, ил тод байдлаар явуулж, дүнг мэдээлнэ.
- 3.3.2. Сангийн эх үүсвэр, зарцуулалт, зээлийн ашиглалт, үр дүн болон зээлийн эргэн төлөлтийн тухай иргэд, олон нийтэд сар бүрийн 5-ны дотор мэдээлнэ.
- 3.3.3. Сангийн эх үүсвэр болон зарцуулалтын үйл ажиллагааны явц, үр дүнд иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

3.4. Халамжийн сангийн санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:

- 3.4.1. Амьжиргааг дэмжих зөвлөлийг багийн ИНХ-аар хэлэлцүүлнэ.
- 3.4.2. Амьжиргааг дэмжих зөвлөлийн үйл ажиллагааны болон халамжийн сангийн санхүүгийн тайланг багийн ИНХ-аар хэлэлцүүлнэ.
- 3.4.3. Халамжийн сангийн санхүүжилтийн эх үүсвэр болон зарцуулалтыг /халамж, үйлчилгээний төрөл тус бүрээр/ сар бүрийн 5-ны дотор олон нийтэд мэдээлнэ.
- 3.4.4. Иргэдийн хүсэлтээр тухайн төрлийн халамж, үйлчилгээний зарцуулалтын мэдээг халамж үйлчилгээнд хамрагдсан иргэдийн нэрсийн хамт мэдээлж болно.

3.5. Нийгмийн даатгалын сангуудын санхүүгийн нээлттэй, ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:

- 3.5.1. Нийгмийн даатгалын сан тус бүрээр орлого ба зарлагын мэдээг сар бүрийн 5-ны дотор олон нийтэд мэдээлнэ.
- 3.5.2. Хуулийн дагуу гэрээ байгуулсан эмнэлэг, эмийн сангууд болон тэдгээрт олгогддог санхүүжилтийн мэдээг сар бүрийн 5-ны дотор олон нийтэд мэдээлнэ.
- 3.5.3. Хөнгөлөлттэй үнээр үйлчилдэг эмийн жагсаалтыг өөрчлөлт орсон тухай бүр олон нийтэд мэдээлнэ.
- 3.6. Сумдад үйл ажиллагаа явуулж буй бусад сангуудын ил тод, нээлттэй байдлыг хангах зорилтын хүрээнд:**
- 3.6.1. Бусад бүх сангуудын бүрдүүлэлт, зарцуулалтын гүйцэтгэлийн мэдээг иргэд, олон нийтэд сар бүрийн 5-ны дотор мэдээлнэ.
- 3.6.2. Мэдээлэлд тухайн сангийн хөрөнгөөр санхүүжүүлсэн үйл ажиллагаа тус бүрийн санхүүжилтийн эх үүсвэр, зарцуулалтыг тодорхой тусгасан байна.
- 3.7. Бусад гадаад, дотоод төсөл, арга хэмжээ, хандив, тусламжаар хийгдсэн хөрөнгө оруулалт, аливаа үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:**
- 3.7.1. Байгууллага, сум бүр гадаад, дотоод төсөл, арга хэмжээ, хандив, тусламжийн үйл ажиллагаа нэг бүрийн эх үүсвэр, зарцуулалтын мэдээллийг сар бүрийн 5-ны дотор олон нийтэд мэдээлнэ.
- 3.7.2. Дээрх эх үүсвэрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны явц болон дүнд байгууллагын ажилтан болон иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавих нөхцөлийг бүрдүүлж ажиллана.
- 3.7.3. Дээрх эх үүсвэрээр санхүүжүүлж, бий болсон эд хөрөнгийг хүлээн авах, эзэмшигчийг тогтоох, бүртгэлд тусгах зэрэг ажиллагаанд байгууллагын ажилтан болон иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг оролцуулна.
- 3.8. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:**
- 3.8.1. Төсвийн байгууллага төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээ болон түүний гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ны дотор олон нийтэд мэдээлнэ.
- 3.8.2. Төсвийн байгууллага худалдан авалтын үйл ажиллагааг тендер шалгаруулалтын аргаар явуулна.
- 3.8.3. Тендер шалгаруулах үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн байгууллагын төлөөллийг заавал оролцуулна.
- 3.8.4. Тендер шалгаруулалт явуулах хугацаа, газрыг болон олон нийтэд зарлаж, мэдээлнэ.
- 3.9. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг худалдан борлуулах үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг хангах зорилтын хүрээнд:**
- 3.9.1. Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийг дуудлага худалдаагаар худалдан борлуулна.
- 3.9.2. Дуудлага худалдааны зарыг тухай бүр 30 хоногийн хугацаанд олон нийтэд нээлттэй зарлаж, дуудлага худалдааны үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй явуулж, дүнг мэдээлнэ.
- 3.10. Иргэний танхимаар иргэд, байгууллагуудад төсөө, санхүүгийн хууль эрх зүйн туслалцаа үзүүлэх үйлчилгээг бий болгох зорилтын хүрээнд:**
- 3.10.1. Төсвийн асуудлаар тодорхой бүлэг болон олон нийтийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулна. /төсвийн байгууллагын ажилтнууд, мэргэжлийн эдийн засагчид, бодлого боловсруулагчид, шийдвэр гаргагчид, иргэний нийгмийн байгууллагууд, иргэд олон нийтийг тусгайлан оролцуулсан, эдгээрээс төлөөлөл оролцуулсан холимог бүтцийн оролцогчдыг хамруулах г.м/

- 3.10.2. Төсвийн ил тод байдлын талаар олон нийтийн саналыг сонсох нөхцөл боломжийг бүрдүүлэн, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллана.
- 3.10.3. Сургалт зохион байгуулах, сурталчилгаа хийх, зөвлөгөө өгөх зэргээр иргэд, төсвийн байгууллагуудад эрх зүйн туслалцаа үзүүлнэ

3.11. Төсвийн тухай болон холбогдох бусад хууль, тогтоомж, тэдгээрт нийцүүлэн гаргасан журмын хэрэгжилтийг хангах зорилтын хүрээнд:

- 3.11.1. Төсвийн бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүнгийн талаар байгууллагын ажилтнууд болон иргэдийн санал асуулга авч, дүнг эргэж мэдээлнэ.
- 3.11.2. Төсвийн хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийг хэрэгжүүлнэ.
- 3.11.3. Төрийн сангийн журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллана.

Дөрөв. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах

- 4.1. Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт
 - 4.1.1. Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах аймаг, сумын зөвлөлийг тухайн шатны Засаг даргын захирамжаар байгуулна.
 - 4.1.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд зохион байгуулах, мэргэжил арга зүйн удирдамжаар хангах, үр дүнд нь хяналт-шинжилгээ хийх үүргийг аймгийн ЗДТГ, ЗДТГ-ын СТСХ гүйцэтгэнэ.
 - 4.1.3. Хөтөлбөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг жил бүр тодотгон боловсруулж, засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжүүлэх үйл ажиллагааг холбогдох бусад байгууллагуудтай хамтран зохион байгуулна.
- 4.2. Хөтөлбөр хэрэгжүүлэх хугацаа
 - 4.2.1. "Шилэн халаас" хөтөлбөрөөр дэвшүүлсэн зорилтуудыг 2013-2016 онд хэрэгжүүлнэ.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хянаж, үнэлэх

- 5.1. Хөтөлбөрийн биелэлтийг улирал бүрийн дараа сарын 05-ны дотор аймгийн ЗДТГ-ын СТСХ-т ирүүлнэ.
- 5.2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг улирал бүр дүгнэж, нэгдсэн дүнг сум, байгууллагын жилийн ажлыг дүгнэх үзүүлэлтэд оруулж тооцно.
- 5.3. Хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтүүд:
 - 5.3.1. Төсвийн бүрдүүлэлт, зарцуулалтын талаар хугацаанд нь олон нийтэд мэдээлсэн байдал
 - 5.3.2. Төсвийн байгууллагын мэдээлэл нь журамд заасан бүтцийг агуулсан байдал
 - 5.3.3. Иргэдийн гаргасан санал, санаачлагыг төсөв боловсруулах, батлах, гүйцэтгэх, тайлагнах үйл явц, орон нутгийн хөгжлийн сан, сум хөгжүүлэх сан болон бусад сан, худалдан авалт, дуудлагын худалдааны үйл ажиллагаанд тусган хэрэгжүүлж, ажилласан байдал
 - 5.3.4. Төсвийг төр, хувийн хэвшил, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудаар хэлэлцүүлсэн байдал
 - 5.3.5. Төсвийн ил тод байдлын талаарх иргэд, олон нийтийн үнэлгээ

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлсэнээр гарах үр дүн

- 6.1. Сум, байгууллагын төсөв боловсруулах, батлах, гүйцэтгэх, тайлагнах үйл явц иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болсон байна.
- 6.2. Сум, байгууллагад улсын болон орон нутгийн төсөв, түүнчлэн бусад сан, гадаад дотоод төсөл, арга хэмжээ, хандив, тусламжаар хийгдсэн хөрөнгө оруулалт, аливаа үйл ажиллагаа бүгд иргэд, олон нийтэд нээлттэй, ил тод болсон байна.

5. «Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай» Улаанбаатар хотын Засаг даргын захирамж

2012 оны 11 дүгээр сард нийслэлийн Засаг дарга Э.Бат-Үүлийн А/606 тоот захирамжаар Улаанбаатар хотын төр, захиргааны байгууллагуудад «Мэдээллийн ил тод байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай» тогтоолыг баталсан юм. Ихэнх заалт нь тухайлбал төсөв санхүү, худалдан авах ажиллагааны заалтууд нь төрийн байгууллагын ил тод, нээлттэй байдлыг илтгэх дөрвөн бүлэг шалгуур үзүүлэлтүүдийг давтсан шинжтэй байна. Гэхдээ энэхүү захирамжид тусгасан зарчмуудын дагуу нийслэлийн удирдлагын зүгээс тодорхой төсөв, хөрөнгийг зарцуулах шийдвэр, тайланг цахим хуудсаар дамжуулан нээлттэй мэдээлж байгаа юм. Үүнд, нийслэлийн удирдах ажилтнуудын гадаад албан томилолтын зардлын тайлан, тендерийн үнэлгээний хорооны бүрэлдэхүүн зэргийг www.ulaanbaatar.mn цахим хуудсанд тухай бүр байршуулж хэвшсэн нь өөр хаана ч байхгүй сайн жишээ юм.

УРАМШУУЛАЛ ОЛГОХ ТУХАЙ

2014-03-28 09:59:43

A/211

2014 оны 03 сарын 26 өдөр

дугаар А/211

Улаанбаатар хот

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4.2, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2006 оны 44 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Нийслэлийн төсвийн ерөнхийлөн захирагчтай 2012 онд байгуулсан Үр дүнгийн гэрээгээ бүрэн хангалттай хэрэгжүүлж, төсвийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн нийслэлийн Татварын газарт 144.844.200 /нэг зуун дөчин дөрвөн сая найман зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгийн урамшууллыг олгосугай.
- 2.Урамшуулалд олгох 144.844.200 /нэг зуун дөчин дөрвөн сая найман зуун дөчин дөрвөн мянга хоёр зуун/ төгрөгийг Засаг даргын нөөц сангаас гаргахыг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Э.БАТ-ҮҮЛ

АНУ-ЫН АЛЯСКА МУЖИЙН АНКОРЭЙЖ ХОТОД ТОМИЛОЛТООР ЯВУУЛАХ ТУХАЙ

2014-03-25 16:19:14

A/201

2014 оны 03 сарын 24 өдөр

дугаар А/201

Улаанбаатар хот

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төсвийн тухай хуулийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

- 1.Гамшиг, онцгой байдлын үеийн хор уршгийг арилгах байгууллага хоорондын харилцан уялдаа, зохицуулалтыг сайжруулах зорилгоор Аляскын үндэсний гвардаас АНУ-ын Аляска мужийн Анкорэйж хотод зохион байгуулж буй "Вижилент Гаард - 2014" дасгал сургуульд ажиглагчаар оролцохоор Нийслэлийн Онцгой байдлын газрын дарга, онцгой байдлын хурандаа Н.Уламбаяр, мэргэжилтэн бөгөөд онцгой байдлын дэслэгч Г.Болортуяа нарыг 2014 оны 03 дугаар сарын 26-наас 31-ний өдрүүдэд томилон явуулсугай.
- 2.Холбогдох зардал болох 3 120 /гурван мянга нэг зуун хорь/ ам.долларын зардлыг гадаад арга хэмжээний зардлаас гаргахыг Тамгын газар /Ё.Гэрэлчулуун/-т зөвшөөрсүгэй.
- 3.Албан томилолтын тайланг ирснээс хойш 14 хоногийн дотор Нийслэлийн Удирдлагын зөвлөлд танилцуулж, хувийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтэст ирүүлэхийг Н.Уламбаярт даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ

Э.БАТ-ҮҮЛ

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ Ц.ЭНХЦЭНГЭЛИЙН ГАДААД ЗАРДЛЫН ТАЙЛАН

2014-01-08 14:26:09



Нийслэлийн Засаг даргын 2012 оны 10 сарын 08-ны өдрийн "Мэдээллийн ил тод байдлыг хангах тухай" 606 тоот захирамжийн дагуу нийслэлийн удирдах албан тушаалтнуудын гадаад томилолтын зардлын тайланг олон нийтэд нээлттэй мэдээлэдэг уламжлалтай. Нийслэлийн Засаг даргын орлогч Ц.Энхцэнгэл, Нийслэлийн Засаг даргын Зөвлөх Л.Ганхөлөг, Нийслэлийн Боловсролын газрын дарга Ц.Отгонбагана, Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтсийн дарга Х.Чинтогтох, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Гадаад харилцааны хэлтсийн мэргэжилтэн Ж.Гантулга нар БНСУ-ын нийслэл Сөүл хотод томиллоор ажиллалаа. Томилолтын баг БНСУ-ын нийслэл Сөүл хотын Боловсролын газрын урилгаар хоёр байгууллагын хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор 2013 оны 12 сарын 11-нээс 15-ны өдрүүдэд ажилласан юм. Төлөөлөгчдийн холбогдох

зардал болох 5 500 000 төгрөг, 1200 ам долларыг Нийслэлийн ЗДТГ-ын гадаад арга хэмжээний зардлаас гаргажээ. Энэхүү зардлын тайланг танилцуулж байна гэж **Нийслэлийн Хэвлэл мэдээлэл, олон нийттэй харилцах хэлтсээс мэдээллээ.**

№	Зардлын нэр	Тоо	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ	Тооцоо хийх хэлбэр
1	Онгоцны зардал	5 хүн	900 000 төгрөг	4 500 000 төгрөг	Нэхэнклэл
2	Бэлэг дурсгалын зардал		1 000 000 төгрөг	1 000 000 төгрөг	Бэлэн
3	Замын зардал	5 хүн	10 доллар 4 хоног	200 доллар	Бэлэн
4	Зам хоног	5 хүн	50 доллар 4 хоног	1 000 доллар	Нэхэнклэл

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРОО БАЙГУУЛАХ ТУХАЙ

2013-02-08 А/95

Монгол Улсын Засаг Захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3, 47 дугаар зүйлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Эдийн засгийн хөгжлийн газарт тавилга, компьютер, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдан авах ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог хавсралтаар баталсугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧ Э.БАТ-ҮҮЛ

Дарга:	Ш.Одончимэг	Нийтлэг үйлчилгээний газрын дарга
Гишүүн:	Ю.Идэрцогт	Нийслэлийн худалдан авах ажиллагааны дарга
	С.Баасанжав	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн мэргэжилтэн
	Я.Оюунсүрэн	Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга	Б.Түмэнжаргал	Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газрын мэргэжилтэн



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ТАМГЫН ГАЗАР

"ИРГЭНИЙ ОРОЛЦООТОЙ ТӨСӨВ-2014" ХОРООНЫ ИРГЭДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС

A

Нийслэлийн 2014 оны төсвийн талаар хэлэлцүүлэг явагдаж байна.
Та доорх 5 бүлэг ажлаас танай хороонд нэн тэргүүнд хийх шаардлагатай гэж үзсэн
ажлыг бүлэг тус бүрээс зөвхөн 1 –ийг сонгож будна уу.

0	0
1	1
2	2
3	3
4	4
5	5
6	6
7	7
8	8
9	9

САНАМЖ

1. Санал асуулгын хуудсыг нугалж, гэмтээж болохгүй.

2. Асуулгын өмнөх дөрвөлжин нүдийг хар өнгийн бал, эсхүл харандаагаар дүүргэж будна.

ТОВЧЛОЛЫН ТАЙЛАЛ

УТ – Улсын төсөв
НТ – Нийслэлийн төсөв
ОНХС – Орон нутгийн хөгжлийн сан

САНАЛ АСУУЛГАД ОРОЛЦОГЧ

Овоо: _____

Нэр: _____

Хаяг: _____

Холбоо барих утас: _____ / _____ гарын үсэг

Дүүрэг, хороогоо сонгоно уу.

1 БАГАНУУР
 2 БАГАХАНГАЙ
 3 БАЯНГОЛ
 4 БАЯНЗҮРХ
 5 НАЛАЙХ
 6 СОНГИНОХАЙРХАН
 7 СУХБААТАР
 8 ХАН-УУЛ
 9 ЧИНГЭЛТЭЙ

ТАНД БАЯРЛАЛАА

1 ХОРОО
2 ХОРОО
3 ХОРОО
4 ХОРОО
5 ХОРОО
6 ХОРОО
7 ХОРОО
8 ХОРОО
9 ХОРОО
10 ХОРОО
11 ХОРОО
12 ХОРОО
13 ХОРОО
14 ХОРОО
15 ХОРОО
16 ХОРОО
17 ХОРОО
18 ХОРОО
19 ХОРОО
20 ХОРОО
21 ХОРОО
22 ХОРОО
23 ХОРОО
24 ХОРОО
25 ХОРОО
26 ХОРОО
27 ХОРОО
28 ХОРОО
29 ХОРОО
30 ХОРОО
31 ХОРОО
32 ХОРОО

<input type="checkbox"/> НИЙГМИЙН ЧИГЛЭЛЭЭР <input type="checkbox"/> 1 БАГА СУРГУУЛЬ <input type="checkbox"/> 2 ЦЭЦЭРЛЭГ <input type="checkbox"/> 3 БИЕИЙН ТАМИР, ЧИЙРЭГЖҮҮЛЭЛТИЙН ТАЛБAY <input type="checkbox"/> 4 ХҮҮХДИЙН ТОГЛОМБЫН ТАЛБAY	САМУУЖИЛТЫН ЭХ ҮҮСВЭР УТ, НТ УТ НТ, ОНХС НТ, ОНХС
<input type="checkbox"/> ДЭД БҮТЦИЙН ЧИГЛЭЛЭЭР <input type="checkbox"/> 1 ХОРООЛЫН ДОТОРХ АВТО ЗАМ <input type="checkbox"/> 2 НЭГДСЭН ГРАЖ, АВТО ЗОГСОЛ <input type="checkbox"/> 3 ЦАХИЛГААНЫ ШУГАМЫН ШИНЭЧЛЭЛТ <input type="checkbox"/> 4 ДУЛААНЫ ШУГАМЫН ШИНЭЧЛЭЛТ <input type="checkbox"/> 5 ЦЭВЭР, БОХИР УСНЫ ШУГАМЫН ШИНЭЧЛЭЛТ	САМУУЖИЛТЫН ЭХ ҮҮСВЭР НТ НТ, ОНХС УТ УТ
<input type="checkbox"/> НИЙТИЙН ҮЙЛЧИГЛЭЭНИЙ ЧИГЛЭЛЭЭР <input type="checkbox"/> 1 НИЙТИЙН ТЭЭВЭР <input type="checkbox"/> 2 НИЙТИЙН ЭЗЭМШИЙН ОРОН СУУЦНЫ ГАДНА ДУЛААГА, ЗАСВАР <input type="checkbox"/> 3 ЦАХИЛГААН ШАТ, ДЭЭВРИЙН ЗАСВАР <input type="checkbox"/> 4 ДУГУЙН БОЛОН ГҮЙЛТИЙН ЗАМ <input type="checkbox"/> 5 УТАСГУЙ ИНТЕРНЭТ	САМУУЖИЛТЫН ЭХ ҮҮСВЭР НТ УТ, НТ НТ НТ
<input type="checkbox"/> ТОХИЖИЛТЫН ЧИГЛЭЛЭЭР <input type="checkbox"/> 1 ГЭРЭЛТҮҮЛЭГ <input type="checkbox"/> 2 НОГООН БАЙГУУЛАМЖ <input type="checkbox"/> 3 ЯВГАН ХҮНИЙ ЗАМ, ГҮҮР <input type="checkbox"/> 4 ХОГ ТЭЭВЭРЛЭЛТ	САМУУЖИЛТЫН ЭХ ҮҮСВЭР УТ, НТ НТ, ОНХС НТ, ОНХС НТ
<input type="checkbox"/> АЮУЛГҮЙ БАЙДЛИЙН ЧИГЛЭЛЭЭР <input type="checkbox"/> 1 УС ЗАЙЛУУЛАХ ДАЛАН, СУВАГ <input type="checkbox"/> 2 ЦАГДААГИЙН ПОСТ <input type="checkbox"/> 3 ХЯНАЛТЫН КАМЕР <input type="checkbox"/> 4 ЗАМЫН ТЭМДЭГ, ТЭМДЭГЛЭГЭЭ, ХҮРД СААРУУЛАГЧ <input type="checkbox"/> 5 ГАЛ КОМАНД, ЦАГДАА, ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИГЛЭЭГ ХҮҮГЭХЭД СААД ИЧРҮҮЛЖ БАЙГАА БАРИЛГА, ХАЦАА, ХААЛТ ЧӨЛӨӨЛӨЛТ	САМУУЖИЛТЫН ЭХ ҮҮСВЭР УТ, НТ УТ, НТ НТ НТ НТ

Санал асуулгатай холбоотой тодруулах зүйл байвал
Нийслэлийн Лавлагаа, Мэдээллийн төвийн
12-00, 12-34 дугаарын утсанд холбогдож тодруулна уу.

Хуулбарлахыг хориглоно.

2013.09.01.0113

6. Ховд аймагт төсвийн мэдээллийг иргэдэд хүргэх талаар авч буй арга хэмжээ

Ховд аймгийн Засаг дарга Д.Цэвээнравдан 2013 оны 4 дүгээр сарын 9-ний өдөр А/135 ба А/136 тоот хоёр захирамж гаргажээ. Нэг нь аймгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын khovdtusuv.wordpress.com цахим хуудас ба аймгийн нийтийн төв номын сан дахь төсвийн мэдээллийн буланг тогтмол ажиллуулж төсөв, санхүүгийн мэдээ, мэдээллийг тогтмол оруулж ажиллах, нөгөө нь дээрх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий хоёр ажлын хэсгийг тус тус байгуулж, бүрэлдэхүүн, ажил үүргийн хуваарийг баталсан юм.

Өнөөдөр орон нутгийн түвшинд хүртэл маш их цар хүрээтэй болж байнга нэмэгдэн шинэчлэгдэж байдаг төсөв, санхүү, худалдан авалтын мэдээллийг тусгайлсан цахим хуудсанд, харин интернэт ашиглах боломжгүй иргэдэд зориулж номын сангийн буланд шуурхай байршуулан иргэд, олон нийтэд хүргэх зохион байгуулалтыг бий болгосон нь иргэдэд төсвийн мэдээллийг хүргэхэд ач холбогдолтой арга хэмжээ болжээ. Өнгөрсөн хугацаанд цахим хуудасны нэрийг www.khovdtusuv.mn болгон өөрчилж төсөв, санхүү, худалдан авалтын нэлээд мэдээллийг оруулсан хэдий ч сүүлийн саруудад шинэчлэхгүй байгаа нь ажиглагдсан болно.



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2013 оны 09 сарын 09 өдөр Дугаар А/135 Ховд

Төсвийн ил тод, нээлттэй байдал
хяналт тавих тухай

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2010 оны 143, 2012 оны 17 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 2/2 дугаар тогтоолоор батлагдсан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.7 дахь заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "А" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Санхүү, төсвийн ил тод, нээлттэй байдлыг хангах, хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий аймгийн орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Хяналтын зөвлөлийн ахлагч:	М.Отгонханд	-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд:	Л.Жамъяндорж	-Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын ажлын албаны олон нийттэй харилцах хэлтсийн дарга /эвшилцсөнөөр/
	Д.Тогтуунбаяр	-Нийгмийн дэвшил, эмэгтэйчүүдийн холбооны салбарын тэргүүн
	Г.Төрмөнх	-Ховдын толь сонины эрхлэгч
	Ц.Цэндхүү	-“Цагаанбелбөө” ХХК-ний захирал

Г.З.Х.-090909



**ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2013 оны 09 сарын 09 өдөр Дугаар А/136 Ховд

Төсвийн ил тод байдлыг хангах зарим
арга хэмжээний тухай

Төсвийн тухай Монгол улсын хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалт, 6 дугаар зүйлийн 6.5 дахь заалт, Засгийн газрын 2010 оны 143, 2012 оны 17 дугаар тогтоол, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2012 оны 2/2 дугаар тогтоолоор батлагдсан Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн 3.1 дэх заалтын хэрэгжилтийг хангах зорилгоор Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн "А" заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төсвийн ил тод, нээлттэй байдлын www.khovdtusuv.wordpress.com веб сайт, Номын сан дээр байрлах санхүүгийн мэдээллийн буланд санхүү, төсвийн мэдээ, мэдээллийг тогтмол оруулж иргэд, олон нийтэд мэдээлж ажиллах чиг үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: П.Амгаланбаатар –Аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч

Гишүүд:	С.Оюундэлгэр	-Боловсрол, соёлын газрын мэргэжилтэн
	Ц.Мөнхцэцэг	-Эрүүл мэндийн газрын эдийн засагч
	Н.Оюунчулуун	-Нийгмийн халамжийн газрын мэргэжилтэн

7. Хөвсгөл аймгийн ИТХ-ийн ээлжит бус V хуралдаан

2013 оны 12 дугаар сарын 4-5-ны өдрүүдэд Хөвсгөл аймгийн ИТХ-ын ээлжит бус V хуралдаан болж 41 төлөөлөгчөөс гадна урилгаар сумдын ИТХ-ын болон Засаг дарга нар, газар, хэлтсийн дарга нар, иргэний нийгмийн зөвлөл, ТББ-ын төлөөлөл, хэвлэл мэдээллийн ажилтнууд оролцжээ.

Хуралдаанаар аймгийн Засаг даргад нэр дэвшүүлэх, аймгийн 2012 оны төсвийн давсан орлогыг хуваарилах, 2013 оны төсөвт тодотгол хийх, аймгийн Засаг даргын 2013-2016 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр батлах, аймгийн 2012 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны төсвийн гүйцэтгэлийн явц, 2014 оны төсвийн төслийн тухай, газар зохион байгуулалтын төлөвлөгөө зэрэг асуудлыг хэлэлцэж шийдвэрлэжээ. Эдгээр хэлэлцүүлгийн үеэр яригдсан төсөв, санхүүгийн холбогдолтой зарим онцлох санаануудыг дор сийрүүлэв.

Хэлэлцсэн нь 4. Аймгийн 2012 оны төсвийн давсан орлого хуваарилах, орон нутгийн байгууллагуудын дансны үлдэгдэл зарцуулах, 2013 оны төсөвт тодотгол хийх тухай асуудлыг аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав оруулж танилцуулав.

Т.Болдбаатар -Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан төлөөлөгчид, урилгаар оролцогчдоос асуулт, санал дүгнэлтээ гаргана уу.

Т.Болдбаатар - аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн хуралдаанаар давсан орлоготой холбоотой асуудлаар нилээд хэдэн удаа олон талаас нь нухацтай ярилцсан. Бид орлогоо төлөвлөхдөө бага төлөвлөсөн учир орлого давсан. Үүнийг юунд зарцуулах талаар Тэргүүлэгчдээс, хорооноос, иргэдийн байгууллагаас олон санал гарсан. Үүний дагуу төсөв санхүүгийн хуваарилалтыг өөрчлүүлэх саналыг СТСХ-т хүргүүлж байсан. Хэвээр орж ирсэн байна. Үүнийг бид бүрэн эрхийнхээ хүрээнд эцсийн шийдвэрийг гаргана байх. Эдгээр саналыг хүлээж авахгүй юм бол бид хуралдаад санал гаргаад байх шаардлагагүй. Нэгэнт хэвлэгдээд ном болоод гараад ирсэн учир өөрчлөх боломжгүй гээд сууж байна. Иймээс төлөөлөгчид та бүхэн нилээд нухацтай хэлэлцэж шийдвэрлэх нь зүйтэй. 400 гаруй сая төгрөг нь орон нутгийн сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн хүмүүст олгогдохоор шийдвэрлэж байгаа. Үүнийг дэмжиж байгаа. Үлдсэн 200 гаруй сая төгрөгөөс 130.0 сая төгрөгийг мал хамгаалах санд төлөвлөсөн байна...

Ас: Б.Лхагваа (иргэний нийгмийн зөвлөл)- Сонгуулийн үр дүнгээр чөлөөлөгдсөн хүмүүс өнөөдөр ихэнх нь эргээд төрийн албанд ажиллаж байгаа. Энэ хүмүүст тэтгэмж өгөх нь зөв үү?

Хр: Г.Сувд - 127 албан хаагчид олгохоор төлөвлөсөн. ЗЗНДНГУ-ын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-ийг үндэслэл болгосон байгаа. Чөлөөлөгдөөд эргээд ажилд орсон бол өгөхгүй гэсэн заалт байхгүй учир өгөхөөс өөр аргагүй байгаа.

Баярсайхан (Соёл, спорт, аялал жуулчлалын газрын дарга)- 2013 оны төсвийн тодотгол дээр улс, тивийн тэмцээн уралдаанд амжилттай оролцсон тамирчин, багш, дасгалжуулагч нарыг шагнаж урамшуулахаар 30.0 сая төгрөг төлөвлөсөн байсныг аймгийн ИТХ-аас бодитой болгож ир гээд буцаасан. Үүнийг өгөх нь зүйтэй.

Т.Болдбаатар - Танай газраас оруулж ирсэн материал бүрхэг, хэн хаанаас ямар медаль авсан энэ тэр нь байхгүй байсан учир буцаасан. Мэргэжилтэн нь өөрөө ч мэдэхгүй баахан жагсаалт гаргаад батлуулах гээд оруулж ирж байгаа нь буруу. Үнэхээр ази тив, улсын чанартай тэмцээнээс байранд орсон бол бид шагнахаас татгалзахгүй. Оны шилдэг багш, дасгалжуулагч шагнах шагналаа байгууллага дотоод зардлаасаа шийдвэрлээд явах нь зүйтэй юм.

Д.Пүрэвдорж (төлөөлөгч) - Хөрөнгөө зүй зохистой зүйлд тавьж байна уу? Аймгийн ИТХ-ын төлөөлөгчдөд төлөвлөсөн 100.0 сая төгрөгөөсөө татгалзъя. Бохирын машин, МХГ-т шинжилгээний лаборатори, аудитын газарт машин авахад хуваагаад өгөх саналтай байна.

Хуралдаан даргалагч дээр гарсан саналуудаар төлөөлөгчдөөс санал хураахад Бохирын машинд 60,0 сая төгрөг, тамирчдын шагнал урамшуулалд 30.0 сая төгрөг, Этүгэн тэнгэрийн дуудлага уран бүтээлд 14.5 сая төгрөг тус тус зарцуулах нь зүйтэй гэв. Шийдвэрлэсэн нь: Аймгийн 2012 оны төсвийн давсан орлого хуваарилах тухай тогтоол батлагдав.

Дараагийн асуудал болох, 2013 оны төсөвт тодотгол хийх тухай асуудлыг аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав танилцуулав.

Т.Болдбаатар (аймгийн ИТХ-ын дарга) - Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан төлөөлөгчдөөс асуух асуулт байна уу?

Хөлбөмбөгийн ногоон байгууламж бүхий талбай байгуулах хөрөнгө 2013 оны тодотголоос хасагдаж байгаа юм бол 2014 оны хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд оруулж өгөхийг хүсэж байна.

Энэ асуудал хоёр намын мөрийн хөтөлбөрт орсон, мөн Ерөнхийлөгчийн санаачлагаар хөдөө орон нутагт хүүхдийн сурч боловсрох орчин нөхцөлийг сайжруулах, хөлбөмбөгийн спортыг орон нутагт хөгжүүлэх хөтөлбөр хэрэгжихээр болсон. Аймгийн 20,000 хүүхэд хөлбөмбөгийн спортоор хичээллэх, гадаад дотоодын тэмцээн уралдаан зохион байгуулах боломжтой, улсын хэмжээнд Эрдэнэтийн дараа орохуйц том талбай болох юм. Ийм талбай байгуулчихвал зөвхөн хөлбөмбөг гэхгүйгээр улсын баяр наадмаа ч шороо тоосгүй, ногоон зүлгэн дээр цэвэрхэн хийх боломжтой болно. Газрын асуудал нь шийдэгдсэн. Хот тохижилтын мэдлийн газарт хийгдэх юм.

Л.Цэрэнжав (аймгийн Засаг дарга) - Хүүхдийн хөлбөмбөгийн талбай барих асуудал 2013 оны иргэдийн санал асуулгад ороогүй, төсөв нь хянагдаагүй гэсэн хоёр зөрчил байгаа учир болохгүй байгаа.

Т.Болдбаатар- Аймгийн ИТХ-ын захиалгаар иргэний нийгмийн байгууллага, аймгийн ИТХ-аас хамтран утсаар, шууд телевизийн эфирээр ийм их санал авсан (материалыг харуулав).

Х.Ган-Очир (аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга) - ... Хөл бөмбөгийн талбайн барих газар нь тодорхойгүй, ТЭЗҮ нь батлагдаагүй. Иргэдийн саналын эхний 64-т ороогүй, санал аваагүй асуудлыг оруулах нь хууль зөрчиж буй хэрэг.

Хэлэлцсэн нь 5: Аймгийн нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2013 оны үндсэн чиглэлийн биелэлт, 2014 оны үндсэн чиглэлийн тухай асуудлыг аймгийн Засаг даргын орлогч М.Очирхуяг оруулж танилцуулав.

Т.Болдбаатар: Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан төлөөлөгчдөөс асуух асуулт байна уу?

Ас: П.Отгон-Очир (төлөөлөгч) - ... 2-рт төр, нийгмийн байгууллагуудын хамтын ажиллагаа гээд л яриад байх юм. Өнгөрсөн хугацаанд иргэний байгууллагатайгаа хэрхэн яаж ажилласан бэ?

Хр: Х.Ган-Очир (аймгийн ЗДТГ-ын Хөгжлийн бодлогын хэлтсийн дарга) - ... Төр нийгмийн ажлын уялдаа холбоог хангах ажлыг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ хариуцаж байгаа. Ерөнхийд нь 7 ажлыг иргэний нийгмийн зөвлөлөөр хийлгүүлэхээр санал хүргүүлсэн. Үүнээс гурав, дөрвөн ажлыг нь хийнэ гэж төсөв хөрөнгөө авсан. Ажиллах байрыг нь гарган өгч хамтран ажиллаж байгаа. ТББ-уудын ажлыг хариуцдаг мэргэжилтэн Б.Ундрах дэлгэрэнгүй хариултыг өгөх байх.

Б.Ундрах (Аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-н мэргэжилтэн) - Төр-нийгмийн түншлэлийн харилцааг би хариуцаж ажилладаг. 2011 онд “Төр ба иргэний нийгмийн хамтын ажиллагаа” сэдэвт зөвлөгөөнийг аймгийн хэмжээнд зохион байгуулж хийх ажлаа төлөвлөсөн байгаа. Энэ хүрээнд тодорхой ахиц дэвшил гарч байгаа. Ирэх онд энэхүү зөвлөгөөнөө дахин хийж хамтын ажиллагаагаа тодорхойлно.

Б.Лхагваа (иргэний нийгмийн зөвлөл) - Иргэдээс 2011 онд улсын төсвөөс санхүүжүүлж айл өрхүүдэд шугам тавьсан. Хэзээ ашиглалтад орох вэ? 5,6-р хорооны замыг хэзээ дуусгах вэ? гэсэн асуултууд гарсныг уламжилж асууя.

Хр: М.Очирхуяг - Замын асуудал шүүхийн шатанд яваа. Зам, Тээврийн Яамнаас өөрсдийн хөрөнгөөр барьж дуусга гэсэн чиглэл өгөөд байгаа. 2014 онд 6 зам буюу 6.5 км замыг засна. Үүнд тав, зургаан замыг оруулж засахаар төлөвлөсөн.

Г.Цэнд-Аюуш (ГХБХБГ-ын дарга)- Өнгөрсөн онд хорооллын усан хангамжийг сайжруулах ажил нэлээд хийгдсэн. Энэ хүрээнд айл өрхүүдэд шугам татсан ч өргөлт насос байхгүй учир ашиглалтад ороогүй байна. Ирэх жил бохир, цэвэр усны шугамыг зэрэг өргөлтийн насостой нь шийднэ.

Б.Лхагваа (иргэний нийгмийн зөвлөл)- Үндсэн чиглэл хэт ерөнхий байна. Өсөлт, хүрэх үр дүн, хугацааг нарийн тодорхой болгоогүй байна. Цагийн ажлаа цагт нь хийж байхыг ард иргэд шаардаж байгааг хэлье.

Шинээр баригдаж буй замуудад цаашид ус зайлуулах суваг заавал хийж баймаар байна. Замыг эвддэг гол хүчин зүйл бол борооны болон үерийн ус байдаг. Техникийн нөхцөлөө эхлээд сайн гаргаж өгдөг байх хэрэгтэй. Мэргэжлийн хүн байхгүй байгаа бол чаддаг, мэддэг хүмүүсийг нь урьж авчраад хийлгэдэг баймаар байна.

Хэлэлцсэн нь 6, 7: Аймгийн 2012 оны төсвийн гүйцэтгэл, 2013 оны өнөөгийн байдал, 2014 оны төсвийн төслийн тухай, аймгийн 2014 оны төсвийн төслийн төсөлд өгөх аймгийн Аудитын газрын дүгнэлт

Асуудлуудыг аймгийн Засаг дарга Л.Цэрэнжав, аймгийн ерөнхий аудитор Г.Оюунгэрэл нар оруулж танилцуулав.

Т.Болдбаатар - Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан төлөөлөгчдөөс асуух асуулт, санал дүгнэлтээ гаргана уу.

Ч.Ням-очир (төлөөлөгч) - 2014 онд авто замын сангийн хөрөнгөөр хийгдэх ажилд хөрөнгө нь хүрч байгаа юу? Газрын дуудлага худалдаанаас 60.0 сая төгрөг олохоор төлөвлөснөөс дөнгөж 250.0 мянган төгрөг орсон гэсэн байх юм. Бүхэл бүтэн аймгийн хэмжээнд ийм бага орлого орсон юм уу?

Хр: Г.Сувд - Таслалыг нь буруу бичсэн байна.

Г.Энхболд (төлөөлөгч) - Үерийн далангийн зураг төсөв хийгдсэн үү?

Хр: Х.Ган-Очир - Үерийн далангийн санал иргэдээс их ирсэн. 4 км замын зураг төсөв нь хийгдсэн. Үертийн амнаас Хатгалтай холбогддог хар зам хүртэл 4 км замыг хамарна. Үлдсэн замын зураг төсөв нь одоо хийгдэж байгаа.

Ч.Ганбаатар (төлөөлөгч) - Татварын хэлтсийн даргаас асуулт асууя. Ирэх онд НӨАТ төлдөг газрууд нэмэгдэх үү? Ямар бэрхшээл гарч байна вэ?

Хр: В.Баяраа - Аймгийн хэмжээнд 1100 ААН бүртгэлтэй, Мөрөн сум болон бусад сумдад нийт 20,000 гаруй хувиараа хөдөлмөр эрхлэгч байдаг. Үүний 10 гаруй хувь НӨАТ-аа төлж байна. Зах дээр худалдаа эрхлэгчид, хэд хэдэн ААН-д шалгалт явуулсан. Урьд нь манай байцаагч нар хуулиа мөрдөж ажилладаггүй байснаас зарим татвар төлөгчид хугацаандаа татвараа төлөлгүй удааж явсаар байгаад бөөн төлбөр тогтоолгох асуудлууд гарч байна. Би ажлаа авснаас хойш байцаагч нараа хууль дүрмийн дагуу ажиллахыг шаардаж шахаж байгаа. Ихэнх иргэд маань хүлээн зөвшөөрч байгаа. Зарим нэг хүмүүсийн зүгээс эсэргүүцэл ирж байгаа. Актыг хүлээн зөвшөөрөхгүй байгаа иргэн, ААН-ийг албан ёсоор мэдээлнэ. Хууль журмын дагуу татвараа аваад эхлэхээр татварын орлого 5-70 сая төгрөг болж нэмэгдэж байгаа. Дансыг нь хууль бусаар авч шалгасан асуудал манайд байхгүй. НӨАТ яагаад хийдэлтэй байна вэ гэхээр падаан хураамчаар хийдэг хэсэг бүлэг хүмүүс байсан нь сая илэрсэн. Шалгагдаж байгаа.

Агнуурын нөөц ашигласны төлбөрийг манайх авах ёстой. Ахуйн хэрэгцээнд 1 иргэн жилд хэдийг агнах ёстой талаар БОГ-аас асууя.

н.Дашдэндэв (БОГ-ын мэргэжилтэн) - БОГ-аас аймгийн Засаг даргатай гэрээгээ байгуулах гэхээр байгаль орчны менежментийн төлөвлөгөөгөө хийж ир гээд байгаа. Сумдад явж агнуурын нөөцөө тодорхойлох гэхээр ихэнх сум мөнгө байхгүй байна. 21 сумын агнуурын

нөөц хийж дууссаны дараа менежментийн төлөвлөгөө батлагдах юм. Ингэснээр яамнаас зөвшөөрлөө авна гэсэн үг. Байгалийн ургамлын нөөц мөн адил 5 жил тутам нөөцөө тогтоох ёстой. Энэ жил манайд өгөхгүй гэсэн. 29.9 сая төгрөг нөөц тогтооход шаардлагатай байна. Гэтэл аймагт 2 сая гаруй төгрөг л төсөвлөсөн. Сум болгоны ой хамгаалах зардлаас нь 971.0 мянган төгрөг гаргаад өгвөл боломжтой болно.

Загас агнах ахуйн болон үйлдвэрлэлийн зөвшөөрөл энэ онд нэгийг ч өгөөгүй.

Г.Сувд - БОГ-т иймэрхүү бодлогын чанартай асуудлаа өөрсдөө зохицуул гээд байгаль хамгаалах санд 30 хувийг нь эрхтэй нь өгсөн. Үүгээрээ энэ мэт асуудлаа шийдээд явах боломжтой.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгө сумын төсвөөс тусдаа.

Хр: В.Баяраа: ... Загасан консервыг очиж шалгаад хаанаас авсныг нь асуухаар хэлдэггүй. Үүнийг орон нутгаас шийд гаргаж өгөх хэрэгтэй.

П.Отгон-Очир (төлөөлөгч) - Татвар төлөгчдийн мөнгөөр хууль бус зүйл хийдгээ болих хэрэгтэй. Машин бол тэвчиж болох зардал. Ер нь энэ дарга нарын зардал хэтэрхий их байна. Үүндээ жаахан анхаарахгүй бол татвар төлөгчдийн мөнгө хэдэн хурган дарга нарын гэр орны ажлыг амжуулахад зориулагдаад байна шүү.

Ц.Зоригт (төлөөлөгч, Хот тохижилтын дарга) - Хот тохижилтоос өнгөрсөн жил бүх шатны байгууллагуудтай уулзаж хэлэлцүүлэг зохион байгуулсан. Бид менежментээ шинэчилж байгаа. Энэ ажлын хүрээнд хог тээвэрлэх зориулалтын автомашинтай болсон. Айл болгоны хогийг ангилж хийхээр 2 ширхэг хогийн сав айл бүрт өгөх гэж байгаа. Хогийн савны нэг бүрийн үнэ нь 50000 төгрөг. Нэгийн үнийг тухайн айлаас нь авья, нөгөөг нь тавьж өгье гэж төлөвлөж байгаа. Үерийн далангийн хөрөнгөөс хогийн сав авах зардлыг шийдвэрлэж өгнө үү.

Б.Намуунцэцэг (Төлөөлөгч) - Үерийн далан зайлшгүй барих хэрэгтэй. Харин ямар газраас үер орж ирэх магадлалтайг нь сайн судлах хэрэгтэй.

О.Баатар (Төлөөлөгч) - Үерийн даланг яг бодитой газарт нь бариад үлдсэн хөрөнгийг нь Мөрөн доторх замыг засахад зарцуулья.

Мөрөн сумын ЗДТГ-ын барилгыг түр царцаах саналтай байна. Өвсний фондоо бэлдэх хэрэгтэй.

С.Даваасүрэн (ОБХ-ийн дарга) - 2006 онд манайд томоохон хэмжээний үер болж байсан. Жил бүр үерийн улмаас хүмүүс амь насаа алддаг. Энэ жил гэхэд аймгийн төвд 3 хүн үерээс болж амиа алдсан. Үерийн далан гэхээр шороо овоолно гэсэн үг биш. Энэ бол байгууламж. Засгийн газрын тогтоол ч гарсан. Үүнийг барих нь зөв.

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан тогтоолын төслийг уншиж танилцуулав.

Хуралдаан даргалагчаас доторх хөрөнгөндөө зохицуулалт хийх эрхийг нь Тэргүүлэгчдэд шилжүүлж үүрэг болгохоор тогтоолд оруулах талаар санал хураахад дэмжигдсэнгүй.

8. Булган аймгийн төсөвт байгууллагуудын 2012 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлтийн тухай

Орон нутгийн төсвийн төлөвлөгөө, гүйцэтгэлд аудитын байгууллагаас өгсөн дүгнэлт маш чухал ач холбогдолтой бөгөөд төсвийн зарцуулалтын байдал, хууль зөрчсөн үйлдлүүдийг илрүүлсэн дүгнэлт, зөвлөмж гаргадаг. Жишээ болгож Булган аймгийн 2012 оны орон нутгийн болон төсвийн байгууллагуудын жилийн эцсийн санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийсэн дүгнэлтийг тус аймгийн аудитын газрын дарга Г.Ганбаатар ИТХ-ын төлөөлөгчид танилцуулсан илтгэлээс зарим баримтыг толилуулж байна.

Төсвийн тухай хууль болон Төрийн аудитын тухай хуулиар олгодсон эрх хэмжээний дагуу орон нутгийн төсвийн 44, эрүүл мэндийн салбарын 23, боловсрол, соёлын 67, тусгай зориулалтын 5, улсын төсвийн 27, орон нутгийн өмчит 1 компани бүгд 167 байгууллагын санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийж 58.7 хувь буюу 98-д стандарт; 35.3 хувь буюу 59-д зөрчилгүй боловч нэмэлт тайлбартай; 4.2 хувь буюу 7-д хязгаарлалттай, 1.8 хувьд дүгнэлт гаргахаас татгалзлаа.

Аудитаар 6339.5 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлж аудитын явцад 6339.5 сая төгрөгийн алдааг залруулж, санхүүгийн тайланд гарсан алдаа өмнөх онд 5662.1 сая төгрөг байсан энэ онд 6339.4 сая төгрөг болж 677.3 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Санхүүгийн тайланд алдаа зөрчлийг гаргахгүй байх, санхүүгийн тайлан тэнцлийг хууль, тогтоомж, заавар, журмын дагуу үнэн зөв илэрхийлэх, удирдлагыг мэдээллээр хангах, ажил сайжруулах талаар 107 байгууллагын дарга эрхлэгч нарт 221 хугацаатай зөвлөмжийг хүргүүлээ.

Сумдын албан томилолтын зардалд судалгаа хийж үзэхэд Улаанбаатар хотод 26.2 сая, аймагт 83.9 сая, сумдад 1.6 сая, Орхон, Дархан-Уул аймгуудад 2.9 төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Тухайлбал, Булган сум нь албан томилолтын зардалд 5.9 сая төгрөг зарцуулснаас Улаанбаатар хотод 5.3 сая төгрөг буюу 89.3 хувийг, үүнээс сумын засаг дарга Улаанбаатар хотод 12 удаа 49 хоног ажиллан 1749.4 мянган төгрөгийн зардал гаргасан нь нийт албан томилолтын зардлын 43.1 хувийг эзэлж байгаа.

Бүрэгхангай сум нь нийт 11.2 сая төгрөгийн албан томилолтын зардал гаргасны 46.6 хувь буюу 5.2 сая төгрөгийг Улаанбаатар хотод зарцуулсан.

Сумдын засаг дарга нар Улаанбаатар хотод ажилласан албан томилолтын зардалд их хэмжээний мөнгө зарцуулсан зөрчил байна.

Мөн сумын ЗДТГ-ын албан хэрэгцээний суудлын авто машиныг Засаг дарга нар өөрийн хувийн хэрэгцээнд унаж төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг явдал газар авсан байна.

Аймгийн ЗДТГ нь Аймгийн ИТХ-ын 2011 оны 12 дугаар сарын 22-ны өдрийн 10-р хуралдаанаар тээвэр шатахууны зардлыг 34.7 мянган төгрөгөөр баталсан боловч Аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2012 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 100 тоот тогтоолоор 37.8 сая төгрөг болгон 3.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, гүйцэтгэлээр 43.9 сая төгрөг зарцуулан

6.1 сая төгрөг хэтрүүлж төсвийг аривлан хэмнэлттэй үр ашигтай зарцуулах зардлын норм нормативыг баримтлаж ажиллаагүй байна.

Цагаан суврагын тохижилтын ажилд 2011 онд 350.0 сая төгрөг тусгагдан тендер зарлан “Авзага трейд” ХХК-тай гэрээ байгуулж ажил эхлүүлээгүй байхад урьдчилгаа санхүүжилтэд 200.0 сая төгрөгийг олгосон, 2011 оны 8 дугаар сарын 15-нд ажлыг дуусгах гэрээ байгуулсан боловч дуустал 2011 оны 9 дүгээр сарын 12-ны өдрөөс 3 сараар сунган нэмэлт гэрээ байгуулж хууль, гэрээний заалтыг зөрчсөн, гэрээнд заасны дагуу алданги тооцоогүй, 2011 оны гэрээт ажлыг дуусгаагүй учир 2012 онд нэмэлт гэрээ байгуулаагүй байхад СТСХ-ийн дуусаагүй барилгын данснаас ажлын гүйцэтгэл, үндсэн баримтгүйгээр 86.0 сая төгрөгийн санхүүжилтийг нэмж олгосон зөрчил илэрлээ. Аймгийн ГХБХБГазраас барилгын ажлын гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.

Дутуу хэрэгжсэн арга хэмжээнүүдээс 13 нь тендерийн хугацаа алдсан, 2 ажил зураг төсөв, техникийн нөхцөлд өөрчлөлт орсон, 3 ажил буюу аймгийн ЗДТГ-ын барилгад 639,5, Хялганат тосгоны спорт цогцолборын барилгад 1083.0, Хутаг-Өндөр сумын эмнэлгийн барилгад 379.3 сая төгрөгийн нэмэлт төсөв шаардлагатай болсон зэрэг шалтгаанаар хөрөнгө оруулалтын ажил дутуу хэрэгжсэн байна. Тухайлбал, Хүүхэд залуучуудын паркийн тохижилтод АСБИ ХХК-ийг сонгосон, 2013 оны 5 дугаар сарын 1-нээс 8 дугаар сарын 1-нд дуусгахаар гэрээ байгуулсан, санхүүжилтийг орон нутгийн дуусаагүй барилгын дансанд шилжүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын конторын барилга 2011 онд тендер зарлаж гүйцэтгэгчээр “Түмэн-Алт” ХХК шалгарсан байна. Гэрээний үнэ 2984.5 сая төгрөг, батлагдсан хөрөнгийн зөрүү 639.5 сая төгрөг шаардлагатай. Барилгын ажлын санхүүжилт дутуу, хугацаандаа дуусаагүй, гэрээний биелэлт хангалтгүй байна.

Булган сумын 1-р багт 2км хатуу хучилттай автозам шинээр барих: “Хур ноёд” ХХК-тай 9 дүгээр сарын 20-ны өдөр дуусгахаар 2012 онд 480.2 сая төгрөгийн санхүүжилт олгохоор гэрээ байгуулан ажлын гүйцэтгэлийг хянаж 468.2 сая төгрөг олгосон боловч, 2013 оны 4 дүгээр сарын 20-ноос 6 дугаар сарын 20-ны өдөр ашиглалтад оруулахаар гэрээнд өөрчлөлт оруулж хөрөнгө оруулалтын ажлыг хүлээж аваагүй байна.

Булган сумын төвийн багийн 10, 12, 14, 20-р байрны орц гарц талбайн авто зогсоолын 160.3 сая төгрөгийн ажлыг “Булган АЗЗА” ХХК-тай 6 дугаар сарын 30-нд дуусгахаар гэрээ байгуулж санхүүжилтэд 134.8 сая төгрөгийг олгосон боловч авто замын газраас тавих хяналт суд, 10-р байрны зам талбайн ажил хийгдээгүй байна.

Цэнгэлдэх хүрээлэнгийн уулзвараас хийд хүртэлх 1.2 км хатуу хучилттай авто замын ажилд 506.5 сая төгрөг, “Булган-АЗЗА” ТӨХК шалгарч 7 дугаар сарын 6-ны өдөр ашиглалтад өгөхөөр гэрээ байгуулсан боловч ажил дуусаагүй 472.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон, нэмэлт гэрээ байгуулсан, ажлын гүйцэтгэлд тавих хяналт муу байна.

Могод Сайхан сумыг холбох Орхон гол дээр барих гүүрийн зураг төсөвт “Мон аз” ХХК оролцож 39.6 сая төгрөгөөр 12 дугаар сарын 20-ны өдөр дуусгахаар гэрээ байгуулсан боловч дуусаагүй байна.

Хангал сум, Хялганат тосгоны Спорт цогцолборын барилгын ажлын сонгон шалгаруулалтад “Бат ван” ХХК шалгарч гэрээнд санхүүжилтийн хуваарийг ажлын гүйцэтгэлээр 30, 30, 30, 10 хувиар олгохоор заасан боловч хуурамч гүйцэтгэл гарган ГХБХБГ-ын дарга Д.Цэрэндорж, БХБХэлтсийн дарга Ч.Балдандорж, мэргэжилтэн Г.Төрмандах, СТСХ-ийн хөрөнгө оруулалтын мэргэжилтэн Д.Батцогт нар гарын үсэг зурж баталгаажуулан 12 дугаар сарын 24-нд 49.9 сая төгрөгийн санхүүжилт олгосон зөрчил илэрлээ.

Орон нутгийг судлах музейн барилгын халаалтын засварын ажилд 57.0 сая төгрөг батлагдаж Орхон аймгийн “Эрдэнэт орд” ХХК шалгарч санхүүжилтийг бүрэн олгосон боловч засварын ажилчанаргүй, хангалтгүй дутуухийгдсэн, ажлын комисс хүлээж аваагүй, захиалагчийн зүгээс болон ашиглагч байгууллагын зүгээс тавих хяналт сул байна.

Хангал сумын тэжээлийн агуулах барих 35.0 сая төгрөг суманд эрх нь шилжиж “Цагаан зуун” ХХК шалгарч 15.0 сая төгрөг олгосон, барилгын ажлын зураг төсөвгүй, ажил хийгдээгүй байна.

Хөрөнгө оруулалтаар хийгдэж байгаа ажлын гүйцэтгэлд захиалагч, мэргэжлийн байгууллагын зүгээс тавих хяналт сул, гэрээний дагуу ажлыг дүгнэдэггүй, барилгын ажлын гүйцэтгэлийг хуурамчаар гарган баталгаажуулдаг, санхүүжилтийг урьдчилан олгодог, хөрөнгө оруулалтын ажил удаашралтай, хэрэгжилт хангалтгүй байна.

9. Өмнөговь аймгийн 2014 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалтын батлагдсан жагсаалт нь тухайн жилийн худалдан авах ажиллагааны талаарх үндсэн мэдээллийг иргэдэд өгдөг. Иргэд нарийвчлан судалбал олон чухал зүйлийг мэдэж авах ба энэ нь цаашид хяналт тавих үйл ажиллагааны эхлэл юм.

Өмнөговь аймагт гэхэд 2014 онд 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэхээс 9 тэрбум төгрөг нь олон нийтийн саналыг авч эрэмбэлсэн Орон нутгийн төсвийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээ байгааг доорх жагсаалтаас харж болно.

2014 онд ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт				
/мян.төг/				
л/д	Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний нэр	Хэрэгжих хугацаа	Төсөвт өртөг	2014 онд санхүүжих
1	Даланзадгад суманд 200 хүүхдийн цэцэрлэгийн барилга барих	2014	1 800 000,0	1 751 271,7
2	Буянт хотхон хүүхдийн зуслангийн үйл ажиллагааг дэмжиж, байрыг засварлах, тохижуулах	2014	300 000,0	300 000,0
3	Шинэ суурьшлын бүсд дулаан түгээх төв ЦТП-4 болон гадна дулааны гол тараагуур шугам барих	2014	4 770 000,0	2 000 000,0
4	Шинэ суурьшлын бүсийн барилга байгууламжийн дундах 10 кВ-ын ЦДШ, дэд станцыг барих ажлыг үргэлжлүүлэх	2014	7 200 000,0	3 600 000,0
5	Даланзадгад, Баянووо сумын төвийн гэр хорооллын 0.4 квт-ын цахилгааны шугам өргөтгөж, Номгон сумын 15/04 кВ-ын дэд станцыг шинээр барих	2014	435 700,0	435 700,0
6	Даланзадгад хотын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн хэрэгжүүлж, шинэ суурьшлын бүсийн цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээг барих ажлыг үргэлжлүүлэн гүйцэтгэх	2014	854000	854 000,0
7	Даланзадгад Шинэ суурьшлын бүсэд 2,3-р ЦТП ажлыг дуусгах	2013-2014	496 000,0	198 000,0
8	Даланзадгад шинэ суурьшлын бүсийн 10 кВ-ын 4.18 км шугамын ажлыг гүйцэтгэж дуусгах	2013-2014	1 520 000,0	299 700,0
9	Ханбогд, Цогтцэций, Гурвантэс Даланзадгад сумдыг хөдөлгөөнт эргүүлийн машинаар хангах, эргүүлийн автомашины тоог нэмэгдүүлэх	2014	60 000,0	60 000,0
ОНХСангийн хөрөнгө оруулалтын дүн			17 435 700,0	9 498 671,7
2014 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт				
1	"Эрүүл хөг" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхлэх	2014	100 000,0	100 000,0
2	Сүү, тараг хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2014	120 000,0	120 000,0
3	Эрүүл иргэн хөтөлбөрийн хүрээнд тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, малчдыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулах	2014	15 000,0	15 000,0
4	Эмч, мэргэжилтний мэргэшил, ур чадварыг дээшлүүлж, төрөлжсөн нарийн мэргэжлийн зөвлөх эмчийг ажиллуулж, ажлын байран дээрх сургалтыг үе шаттай зохион байгуулах	2014	200 000,0	200 000,0
5	Эмнэлгүүдийг дэвшилтэт технологи бүхий тоног төхөөрөмжөөр ханган, ашиглалтын чадавхийг сайжруулж, эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулна	2014	5 000 000,0	2 200 000,0
6	Эмнэлгийн үйлчилгээний ая тухтай, ээлтэй орчинг бүрдүүлж, иргэдийн сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх	2014	500 000,0	500 000,0
7	ХБНГУ-аас нийлүүлэгдэх эмнэлгийн яаралтай түргэн тусламжийн, бүрэн тоноглогдсон автомашиныг хүлээн авч, тусламж үйлчилгээг үзүүлэх	2013-2014	214 000,0	214 000,0
8	90 ортой эмнэлгийн их засвар хийх	2014	600 000,0	600 000,0
9	Цогтцэций суманд 200 хүүхдийн цэцэрлэг барих ажлыг эхлүүлэх	2014	1 800 000,0	1 800 000,0
10	Даланзадгад суманд баригдаж байгаа 1200 хүүхдийн сургуулийн барилгыг ашиглалтанд оруулах	2014	980 000,0	980 000,0
11	Булган сумын хичээлийн байрны барилгыг засварлах	2014	250 000,0	250 000,0
12	Хүүхдийн бие дааж хөгжих нөхцөл боломжийг бүрдүүлэх зорилгоор сургалтын тоног төхөөрөмж, техник хэрэгсэлээр хангах	2014	1 375 000,0	1 375 000,0
13	Сургууль, цэцэрлэгийг хяналтын камертай болгож, сургалтын үр дүнг тооцох, ил тод нээлттэй байдлыг хангах	2014	75 000,0	75 000,0
14	Авьяас хөтөлбөрийн хүрээнд хүүхдийг хөгжүүлэх дугуйлан секц хичээллүүлэх нөхцөл боломжийг бүрдүүлж, тоног төхөөрөмж техник хэрэгсэлээр бүрэн хангасан танхимууд, Өсвөрийн загвар зохион бүтээгчдийн төвийг Соёл спортын цогцолборт байгуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	2014	100 000,0	100 000,0
15	Насан туршийн боловсролын төвийг тохижуулж, үйл ажиллагааг тогтмолжуулах	2014	20 000,0	20 000,0
16	Мэргэжлийн урлагийн байгууллагад гэрэлтүүлэг, техник хэрэгслийн дэвшлийг нэвтрүүлэх	2014	60 000,0	60 000,0
17	Төв, хөдөөгийн музейн сан хөмрөгийн баяжилтийг нэмэгдүүлэх	2014	50 000,0	50 000,0
18	Соёлын өвийг эрэн сурвалжлах, судлах, хадгалж хамгаалах, сэргээн засварлах, сурталчлах түгээн дэлгэрүүлэх ажлыг эрчимжүүлэх	2014	20 000,0	20 000,0
19	Өмнөговь аймгийн онцлог уран бүтээл "Хөхөө Намжил" дуулалт жүжгийг сэргээн тавих	2014	25 000,0	25 000,0
20	Үндэсний спортыг хөгжүүлэх зорилгоор холбооны үйл ажиллагааг бодлогоор дэмжих	2014	20 000,0	20 000,0
21	Соёл спортын цогцолборын дотоод торхижилт	2014	100 000,0	100 000,0
22	Стандартын хөл бөмбөгийн талбай байгуулах	2014	500 000,0	500 000,0
23	Ханбогд сумын төвд 500 хүний суудалтай соёлын төвийн барилга барих	2014	1 535 000,0	1 535 000,0
24	40-өөс дээш насны ажил олоход бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2014	40 000,0	40 000,0
25	Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, ажлын байр бий болгох хөтөлбөр хэрэгжүүлэх	2014	30 000,0	30 000,0
26	Төрийн сангийн тогтолцоог иж бүрэн нэвтрүүлж, компьютер техник хэрэгслийг шинэчлэн, ЗГ-ын удирдлагын мэдээллийн системд бүрэн холбох	2014	150 000,0	150 000,0
27	Аймгийн төвийн хүн амын махны хэрэгцээг махны хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор мах бэлтгэж нөөцлөх арга хэмжээг холбогдох байгууллага, аж ахуйн нэгжтэй хамтран зохион байгуулах	2014	100 000,0	100 000,0
28	Мах боловсруулах үйлдвэрийг түүхий эдээр хангах зорилгоор махны чиглэлийн аж ахуйг байгуулах	2014	100 000,0	100 000,0
29	Төлөөр нь өсгөсөн тэмээ тутамд мөнгөн урамшуулал олгох арга хэмжээг үргэлжлүүлэн зохион байгуулах	2014	45 000,0	45 000,0

Орон нутгийн төсвийн ил тод байдал - 2013

30	Даланзадгад суманд үйл ажиллагаа явуулж байгаа шохойн үйлдвэрийн чиглэл 0.4 кв-ын ЦДАШ татах ажлыг зураг төсвийг боловсруулж, ажлыг гүйцэтгэх	2014	20 000,0	20 000,0
31	Алслагдсан сум, багийн малчдын үүрэн холбооны тархалтыг нэмэгдүүлж, сүлжээг сайжруулах	2014	60 000,0	60 000,0
32	Орон нутгийн зорчигч тээврийн үйлчилгээг сайжруулж Даланзадгад хот доторхи нийтийн тээврийн хүртээмжийг нэмэгдүүлэх	2014	50 000,0	50 000,0
33	1000 айлын орон сууц хөтөлбөрийг хэрэгжүүлж, орон сууцны хангамжийг нэмэгдүүлэх	2014	6 000 000,0	2 000 000,0
34	Даланзадгад сумын нийтийн зориулалттай орон сууцуудыг хэрэглээний халуун усанд холбох ажлыг үргэлжүүлнэ	2014	540 800,0	540 800,0
35	Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	2014	98 000,0	98 000,0
36	Дүгнэлт гарсан ашиглалтын шаардлага хангахгүй байгаа нийтийн зориулалттай орон сууцуудын байршил дахин төлөвлөлтийн зураг төсвийг боловсруулах	2014	70 000,0	70 000,0
37	Шинэ суурьшлын бүсийг үргэлжлүүлэн 50 га газарт хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах	2014	35 000,0	35 000,0
38	Даланзадгад сумын 1500 км газар нутгийн сансарын зураг авч 1:1000 байр зүйн дэвсгэр зургийг хийн GNSS сүлжээг байрлуулах	2014	190 000,0	190 000,0
39	Даланзадгад суманд инженерийн дэд бүтэц бүхий 200 айлын жишиг хорооллыг байгуулах	2014	2 200 000,0	1 000 000,0
40	Ойрын жилүүдэд нийгмийн салбарт шинээр баригдах болон засварлах барилга байгууламжийн геологийн судалгаа, зураг төсвийг боловсруулах Үүнд: 8 сумын төвийн цэвэр бохир усны шугам сүлжээний зураг төсөв, Сэврэй сумын 320 хүүхдийн сургуулийн барилгын зураг төсөв, 200 тонн багтаамжтай тээжээлийн агуулахын зураг төсөв, Спортын сургалттай дунд сургуулийн зураг төсөв	2014	500 000,0	500 000,0
41	Бүх сумдын Засаг даргын Тамгын газрыг интернетийн сүлжээнд бүрэн холбож цахим хурал, сургалт семинар зохион байгуулах, мэдээлэл дамжуулах найдвартай эх үүсвэртэй болгох	2014	250 000,0	250 000,0
42	Аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтэс, нэгжийн ашиглалтын хугацаа дууссан техник, хэрэгсэл, тоног төхөөрөмжийг шинэчлэх	2014	150 000,0	150 000,0
43	Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавч, чадварыг бэхжүүлэх	2014	80 000,0	80 000,0
44	Даланзадгад, Баянووоо, Сэврэй сумдын ЗДТГ азырн конторын барилгыг бүрэн ашиглалтанд оруулж, Ноён сумын ЗДТГ-ын конторын барилгын ажлыг эхлүүлэх	2013-2014	3 180 559,2	1 980 559,2
45	Сумдын 12 багийн төвийн барилга барих	2014	840 000,0	735 014,7
46	Даланзадгад сумын 7-р багийн цогцолбор барилга дуусгаж, 4-р багийн барилга барьж эхлүүлэх	2013-2014	450 000,0	450 000,0
47	Багийн Засаг дарга нарыг унаагаар хангах	2014	39 000,0	39 000,0
48	Сумдын 10 багийн төвийг эд хогшлоор хангах	2014	100 000,0	100 000,0
49	Аймгийн Нутгийн удирдлагын ордны их засвар хийх	2014	300 000,0	300 000,0
50	Төрийн албаны үйлчилгээний зарим автомашиныг шинэчлэх	2014	200 000,0	200 000,0
51	Орон нутгийн 1-р телевизийн сувгийг ДДШ-д холбож сансарт цацах/ хөдөөгийн иргэдийг мэдээллээр хангах/	2014	30 000,0	30 000,0
52	Төрийн үйлчилгээний нэгдсэн байрны барилгыг барих ажлыг эхлүүлэх	2014	7 000 000,0	3 000 000,0
53	Хилийн зурвас нутагт харуулын байр барих /0131 ба 0166-р анги/	2014	72 000,0	72 000,0
54	Хил хамгаалахад туслалт хүчиний аймгийн зөвлөл, хил хамгаалах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх	2014	100 000,0	100 000,0
55	Гадаадын иргэдийн бүртгэл хяналтын үйл ажиллагааг боловсронгуй болгож тэдгээрийн орон нутгийн орлогот төвлөрүүлэх татварын тогтолцоог тодорхой болгох	2014	40 000,0	40 000,0
56	Гурвантэс, Сэврэй, Ноён сумдыг эрх зүйн туслалцааны төвтэй болгох	2014	3 000,0	3 000,0
57	"Архидалтгүй Өмнөговь" хөтөлбөрийг батлуулах хэрэгжүүлэх	2014	30 000,0	30 000,0
58	Төрийн архивт нягтруулсан шүүгээ суурилуулах	2014	32 500,0	32 500,0
59	Төрийн болон албан байгууллагын архивын улсын үзлэгийг зохион байгуулж, төрийн архивын цахим сангийн тоног төхөөрөмжийг шинэчлэх, Манлай, Гурвантэс, Булган сумдын архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах	2014	11 000,0	11 000,0
Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын дүн			36 795 859,2	23 490 873,9

2014 онд Байгаль хамгаалах чиглэлийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний жагсаалт

1	Мод тарьж ургуулсан иргэн аж ахуйн нэгж байгууллагад урамшуулал олгох журмын дагуу 2012,2013 онд тарисан болон 2014 онд шинээр мод тарьж ургуулсан иргэн , аж ахуйн нэгжид урамшуулал олгох, Бүх нийтийн мод тарих өдрийг зохион байгуулах	2014	50 000,0	50 000,0
2	Даланзадгад, Цогтцэций, Гурвантэс, Ханбогд сумдын агаарын бохирдлын зэрэглэлийг мэргэжлийн байгууллагаар тогтоолох	2014	50 000,0	50 000,0
3	Даланзадгад суманд Соёл амралтын хүрээлэн байгуулах	2014	3 000 000,0	1 500 000,0
4	Тусгай хамгаалалттай газар нутгийн хөрсний элэгдэл эвдрэл бууруулах зорилгоор хатуу хучилттай автозам тавих	2014	8 365 000,0	8 365 000,0
5	Гадаргын усны нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн хэмжээнд булгийн эхийг хашиж хамгаалах ажлыг үргэлжүүлэх	2014	65 000,0	65 000,0
6	Даланзадгад сумын үерийн хамгаалалтын далан барьж байгуулах	2014	1 290 000,0	590 000,0
7	Ногоон хэрэм үндэсний хөтөлбөрийн хэмжээнд 50 га талбайг ойжуулах	2014	500 000,0	200 000,0
8	Даланзадгад суманд түлшний модны хангамж нэмэгдүүлэх	2014	16 000,0	16 000,0
9	Аялагч жуулчдын аюулгүй зорчих боломжийг хангах зорилгоор ГТСБЦГ-ын музейгээс Ёлын ам хүртлэх зам засварлах	2014	100 000,0	100 000,0
10	Өмнөговь аймгийн Номгон сумын Буурын хяр, Их Номгон, Баяндалай сумын Зурамтай, Аргалант зэрэг газруудад нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийн, менежментийн төлөвлөгөө хэрэгжүүлэх	2014	10 000,0	10 000,0

11	Иргэд, сургууль цэцэрлэгийн хүүхдүүдийн экологийн боловсролыг дээшлүүлж, соёлын өвийг хамгаалах төсөл хөтөлбөрийг дэмжих, нөхөрлөл, идэвхтэй байгаль хамгаалагчийн ажлыг үр дүнгээр урамшуулах үйл ажиллагааг нь дэмжих, сургалт суртчилгааны ажил зохион байгуулах	2014	40 000,0	40 000,0
12	Хууль бус ашигт малтмалын олборлолтын улмаас эвдрэлд орж орхигдсон газарт нөхөн сэргээлт хийх	2014	50 000,0	50 000,0
13	Өмнөговь аймгийн хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж аймгийн ИТХ-аар батлуулж, хэрэгжүүлэх	2014	10 000,0	10 000,0
14	Даланзадгад сумын нэгдсэн хогийн цэгийг өргөтгөх, ангилан ялгах цех, аюултай хог хаягдлын цэг, шатаах зүүх, цахилгаанд холбох	2014	200 000,0	200 000,0
15	Агаарын бохирдлыг бууруулах зорилгоор Даланзадгад сумын айл өрхийг утаагүй зуухаар хангах	2014	929 150,0	929 150,0
16	Елын ам, Баянзаг, Хонгорын голын элс орчмын газарт байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийлгэж, менежментийн төлөвлөгөө боловсруулах	2014	50 000,0	50 000,0
17	Аймгийн нутаг дэвсгэрийн хөрсний доройтол, цөлжилтийн төлөв байдал, цөлжилтийн зэрэглэл тогтоох	2014	50 000,0	50 000,0
18	Ахуйн болон үйлдвэрлэлийн бохир усыг эргүүлэн ашиглах олон улсын туршлагыг судалж, бодлого боловсруулах	2014	10 000,0	10 000,0
19	Иргэд олон нийтэд усны үнэ цэнэ, үйл ажиллагааны талаар мэдээлэл, мэдлэг өгөх зорилгоор "Дэлхийн усны өдөр"-ийг аймгийн хэмжээнд тэмдэглэн өнгөрүүлэх	2014	5 000,0	5 000,0
20	Ус цаг уур орчны шинжилгээний хамгаалалтын газрын хашааг шинэчлэх	2014	100 000,0	100 000,0
21	Газар зүйн мэдээллийн Arc GIS программ суулгах, сургалтанд хамруулах	2014	22 000,0	22 000,0
22	Усан хангамж хүрэлцээгүй бүс нутагт инженерийн хийцтэй худаг гаргах	2014	220 000,0	220 000,0
23	Балгасны нуурын 100 га-ын усалтын системийг шинээр барьж байгуулах ажлыг эхлүүлэх	2014	980 000,0	980 000,0
24	Номгон сумын Эрдэнэбулагийн усалтын системийг засварлах	2014	225 000,0	225 000,0
25	Даланзадгад суманд өвлийн хүлэмж барих	2014	150 000,0	150 000,0
26	Даланзадгад сумын зарим гэр хорооллыг цэвэр бохир усны шугам сүлжээнд холбож, Цогт-Овоо сумын төвийн цэвэр бохир усны шугам сүлжээ, Номгон суманд бага оврын цэвэрлэх байгууламж барих	2014	2 000 000,0	2 000 000,0
Байгаль хамгаалах чиглэлээр хийгдэх хөрөнгө оруулалтын дүн			18 487 150,0	15 987 150,0
Замын сангийн хөрөнгөөр хийгдэх хөрөнгө оруулалт				
1	Даланзадгад сумын шинэ суурьшлын бүсэд 3.1 км хатуу хучилттай авто зам тавих	2013	1 296 000,0	596 000,0
2	Цогтдун сумын төв доторхи 2 км хатуу хучилттай автозам барьж байгуулах	2014	840 000,0	840 000,0
3	Аймгийн төвөөс зүүн чиглэлд гэрэх автозамын уулзварт хяналтын постыг барьж байгуулах	2014	188 000,0	188 000,0
4	Авто зам дагуух гэрэлтүүлэг	2014	260 385,9	260 385,9
Замын сангийн хөрөнгө оруулалтын дүн			2 584 385,9	1 884 385,9
2014 ОНЫ НИЙТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ДҮН			75 303 095,1	50 861 081,5

Тайлбар: /Балгасан төсөв 2408762.1 мянган төгрөг; үүнээс АТБӨЯХАТатварын нийт орлого, суурь орлогын зөрүү 315000.0 мянган төгрөг, авто тээврийн албан журмын даатгалд 209376.2 төгрөг хасаад 1884385.9 мянган төгрөг/